



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

АШГИЙН ТӨЛӨӨ БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

ҮНДЭСНИЙ БОЛОН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ж.Содномдаржаа, Ц.Одгэрэл, М.Долгорсүрэн, Р.Бат-Эрдэнэ нар



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

АШГИЙН ТӨЛӨӨ БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

ҮНДЭСНИЙ БОЛОН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааг өмгөөллийн “ӨҮ ЭС ДИ ПАРТНЕРС” ХХН-ийн
ажилтнууд хийж гүйцэтгэв.

Багийн ахлагч: Ж.Содномдаржаа /судлаач/

Багийн гишүүд: Ц.Одгэрэл /LL.M./,

М.Долгорсүрэн /судлаач/

Зөвлөх: Р.Бат-Эрдэнэ /Ph.D/

ННА 67

ДАА 340

А-941

ISBN 978-99978-803-5-2

Улаанбаатар хот

2018 он

Гарчиг

ӨМНӨХ ҮГ	7
УДИРТГАЛ	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
АШГИЙН БУС САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	10
1.1. Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалт	10
1.1.1. Ашгийн бус салбарт төрөөс баримталж буй бодлого	20
1.1.2. Монгол Улс дахь ашгийн бус хуулийн этгээдийн төрөл, хэлбэр	22
1.2. Төрийн өмчөөс ашгийн бус байгууллага болгон хувиргах туршилт, түүний үр дүн	24
1.3. Ашгийн бус хуулийн этгээдийн бүртгэлийн харилцаа, тулгамдаж буй асуудал	27
Бүлгийн дүгнэлт	30
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
АШГИЙН БУС САЛБАРЫН ТАТВАРЫН ЗОХИЦУУЛАЛТ	32
2.1. Ашгийн бус салбарыг дэмжих зохицуулалт	32
2.1.1. Ашгийн бус байгууллагад татварын таатай нөхцөл олгож буй АНУ-ын тогтолцоо	34
2.1.2. Ашгийн бус байгууллагад хамаарах Монгол Улсын татварын зохицуулалт	37
2.2. Ашгийн бус хуулийн этгээдийг татварын бодлогоор дэмжих аргууд	41
Бүлгийн дүгнэлт	45
ГУРАВДУГААР БҮЛЭГ	
АШГИЙН БУС САЛБАРЫН ХЯНАЛТ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО	47
3.1. Ашгийн бус хуулийн этгээдийн тайлагнах үүрэг	47
3.1.1. Нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагааг зохицуулж буй туршлага: Япон Улс	53
3.2. Ашгийн бус хуулийн этгээдийн зохион байгуулалт, дотоод хяналтын тогтолцоо	54
3.2.1. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: ХБНГУ-ын практик	55
3.2.2. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: АНУ-ын практик	55

3.2.3. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: Япон Улсын практик	58
3.2.4 Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: Монгол Улсад	61
Бүлгийн дүгнэлт	70
<hr/>	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	
ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	72
4.1 Ашгийн бус салбарын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	72
<hr/>	
БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	76
<hr/>	
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	80
<hr/>	
ХАВСРАЛТ 1: АШГИЙН БУС САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	83
<hr/>	
ХАВСРАЛТ 2: АШГИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУДАЛГАА	108
<hr/>	
ХАВСРАЛТ 3: МОНГОЛ УЛС ДАХЬ АШГИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	114
<hr/>	
ХАВСРАЛТ 4: АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАТВАРЫН ЗОХИЦУУЛАЛТ	116
<hr/>	
ХАВСРАЛТ 5: ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР	118
<hr/>	
ХАВСРАЛТ 6: АШГИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ	120
<hr/>	
ХАВСРАЛТ 7: НҮБ-ЫН АШГИЙН БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АНГИЛАЛ	124
<hr/>	
ХАВСРАЛТ 8: АШГИЙН БУС САЛБАРЫГ СУДАЛСАН БАЙДАЛ	130

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БСБ	Боловсролын сургалтын байгууллага
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БЗД	Баянзүрх дүүрэг
МЗХ	Монголын залуучуудын холбоо
МУЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
СЭЗДС	Санхүү эдийн засгийн дээд сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТББтХ	Төрийн бус байгууллагын тухай хууль
ТБОНӨтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТАХЗГБ	Татварын асуудал хариуцсан засгийн газрын байгууллага
УБИС	Улаанбаатар Их Сургууль
ШУА	Шинжлэх ухааны академи
УДШ	Улсын Дээд Шүүх
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХҮИС	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль
ХУДС	Хүмүүнлэгийн ухааны дээд сургууль
ХК	Хувьцаат компани
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭЗБтХ	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
ХЭУБтХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
ХМБ	Хэвлэл мэдээллийн байгууллага
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХУИС	Хүмүүнлэгийн ухааны их сургууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Бүдүүвч, хүснэгтийн тайлбар

Бүдүүвч 1. Иргэний хуульд хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тодорхойлсон нь (33 дугаар зүйл)	12
Бүдүүвч 2. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тогтоон бүртгэж буй практик	14
Бүдүүвч 3. Япон Улсын нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд	19
Хүснэгт 1. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тогтоож бүртгэсэн байдал	15
Хүснэгт 2. Ашгийн бус хуулийн этгээд: ОӨУБЕГ–ын мэдээ	22
Хүснэгт 3. Ашгийн бус хуулийн этгээд: Хуулийн зохицуулалтын харьцуулалт	23
Хүснэгт 4. ХЗДХЯ болон Татварын ерөнхий газарт ирүүлсэн тайлангийн статистик мэдээлэл	29
Хүснэгт 5. ХЗДХЯ болон Татварын ерөнхий газарт бүртгүүлсэн байгууллагын тоо (2008–2011 он)	29
Хүснэгт 6. Хуулийн этгээдийг бүртгэсэн мэдээ: 2017 оны байдлаар	30
Хүснэгт 7. ТББ–ын тайлангийн мэдээ	48
Хүснэгт 8. Япон Улсын ашгийн бус байгууллагын удирдлагын бүтэц	58

ӨМНӨХ ҮГ

Хүний эрхийг хамгаалах, ардчилсан сайн засаглалыг бэхжүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах, ашгийн төлөө бус нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нь чухал билээ.

1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулахад чухал алхам болсон хэдий ч төрийн бус байгууллагын тогтвортой, үр нөлөөтэй хөгжлийг дэмжих болон ашгийн төлөө бус нийтэд тустай үйл ажиллагааг оновчтой зохицуулах хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр нийтэд тустай үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус байгууллагууд салбарын хууль тогтоомжийн хүрээнд харилцан адилгүй зохицуулагдаж, бүртгэл, тайлагналын хувьд ойлгомжгүй байдал үүсгэж, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааг ялгаж салгахад ч хүндрэл учруулж ирлээ.

Хууль тогтоомжийн энэхүү тодорхойгүй байдлаас үүдсэн ашгийн бус байгууллагын харилцаанд үүсэж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, улмаар нийтийн эрх ашгийг хамгаалах, нийтэд тустай үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор хийсэн судалгааны тайланг эрхэм уншигч Та бүхэнд хүргэж байна.

Энэхүү судалгааг санаачилсан УИХ-ын эрхэм гишүүн Ц.Мөнх-Оргил, судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн судлаачид, судалгаанд оролцож мэдээллээ сэтгэл харамгүй хуваалцсан байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

УДИРТГАЛ

Боловсрол мэдлэг эзэмших, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх боломжоор хангагдах зэрэг иргэдийн үндсэн эрхээ эдлэхэд зайлшгүй шаардлагатай суурь үйлчилгээг тэгш хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нь аль ч төрийн үүрэг билээ. Харин энэхүү үүргийг иргэдийн өөрсдийн оролцоо, хяналттайгаар хэрэгжүүлэх нь хамгийн үр өгөөжтэй байх тул улс орнууд нийтэд тустай үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих бодлогыг хөгжүүлж иржээ. Түүхээс үзвэл, 1600-аад оны үеэс эхлэн нийгмийн эмзэг хэсгийг дэмжих ашгийн бус зорилготой, сайн дурын үйл ажиллагааг Америкийн Нэгдсэн Улс (АНУ) болон Европын улс орнуудад төрийн бодлогоор дэмжин зохицуулж ирсэн байна.

Ашгийн бус салбар нь нийгэмд хэрэгцээтэй байгаа үйл ажиллагааг нийтийн сайн сайхны төлөө хэрэгжүүлдгээрээ чухал ач холбогдолтой юм. Нийтэд зориулсан үйлчилгээг төр дангаараа бүрэн хүргэх нөөц хязгаарлагдмал нөхцөлд иргэдийн санаачилгыг дэмжсэнээр нийгмийн эмзэг асуудлыг амжилттай шийдвэрлэх боломж нэмэгддэг. Нөгөө талаас, ашгийн бус салбар хөгжсөнөөр энэрэнгүй сэтгэлийн үүднээс нийгмийн

эмзэг хэсэгт туслах, дэмжих санаачилга, хөдөлгөөн илүү зохион байгуулалттай бөгөөд чиглэсэн зорилгодоо нийцтэй, үр өгөөжтэй болж хүмүүнлэг нийгмийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Монгол Улсын хувьд төрийн хяналттай социалист дэглэмээс иргэний ардчилсан нийгэмд шилжих чиг баримжааг 1990 оноос баримтлан, хүмүүнлэг, энэрэнгүй нийгмийн орчныг бүрдүүлэхийг эрхэмлэн зорьж, улс төр, эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй өөрчлөн байгуулалтыг эхлүүлсэн билээ. БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1992 онд баталсан Үндсэн хуульд "иргэн"-ний эрх, эрх чөлөөг төв болгон шинээр томъёолж, иргэнд хүрэх төрийн үйлчилгээ, иргэний эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл, баталгааг бүрдүүлэх үүргийг төрд хүлээлгэсэн. Тэрчлэн, Үндсэн хуулиараа хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон манай улсын хувьд ч нийтэд тустай чиг үүргийг хэрэгжүүлэх иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжсэн хуулийн зохицуулалт шинээр бий болж байна. Харин ашгийн бус, нийтэд тустай үйл ажиллагааг дэмжсэн заалт зарим хуульд тусаж батлагдсан хэдий ч цогц шинжтэй эрх зүйн оновчтой зохицуулалт болж хараахан чадаагүй байна.

Судалгааны багийн зүгээс өмнө нь хийгдсэн ашгийн бус салбарт хамаарах судалгаануудыг тоймлон мета-анализ хийж, мөн энэ салбарт ажиллаж байгаа Хөдөө аж ахуйн их сургууль, Чойжин ламын сүм музей зэрэг байгууллагуудыг кейс болгон авч үзэв. Үр дүнд нь судалгааны үндсэн асуудлаа тодорхойлж, социологийн (анкет) судалгаагаар ашгийн бус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн хандлагыг тодорхойллоо. Үүний үндсэн дээр

манай орны ашгийн бус салбарын эрх зүйн орчныг бусад улс орны жишиг туршлагатай харьцуулан судалж, цаашид боловсронгуй болгох чиглэл, практик алхмыг тодруулах зорилт тавин ажиллав. Судалгааны үр дүнд ашгийн бус салбарын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт өгч, цаашид хэрхэн хөгжүүлэх талаар Зөвлөмж боловсруулан энэхүү тайланд багтааж, бодлого тодорхойлогчдод хүргүүлэхээр зорьж ажиллалаа.

Нэгдүгээр бүлэг

АШГИЙН БУС САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

1.1. Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалт

Эх газрын эрх зүйн систем бүхий улс орнуудад Иргэний хуулийг нийгмийн амьдралын үндсэн харилцааг зохицуулах хоёрдогч суурь хууль (Үндсэн хууль) гэж үздэг. Учир нь, нийгмийг бүрдүүлэгч үндсэн субъектүүд болох хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрх зүйн үндсийг энэ хууль тодорхойлж өгдөг байна.

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчлөлтэй байж болох бөгөөд ашгийн төлөө болон ашгийн бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулж болохоор нээлттэй зохицуулсан. Гэтэл хуулийн этгээдийг тодорхойлсон Иргэний хуульд “ашгийн төлөө”, “ашгийн төлөө бус” зорилго нь хэрхэн ялгагдах, үүнд үндэслэн холбогдох зохицуулалт ямар байхыг тодорхойгүй орхисон. Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулсан бусад хуульд ч энэхүү ялгаа нь тодорхойгүй, бүдэг зааглагдсан байна.

Манай судалгааны хүрээнд Иргэний хуулийн дээрх субъектүүдээс нийтэд ашиг тустай үйл ажиллагаа эрхлэх болон эрхэлж буй хуулийн этгээдүүдийн өөр хоорондоо болон төртэй харилцаа харилцааг тухайлан авч үзсэн болно. Хуулийн этгээдийн ерөнхий шинжийг

Монгол Улсын Иргэний хууль (2002 онд батлагдсан)-ийн 25 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлсон байдаг:

“Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж

чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.”

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчлөлтэй байж болох бөгөөд ашгийн төлөө, ашгийн төлөө бус зорилготойгоор үйл ажиллагаа явуулж болохоор нээлттэй зохицуулсан. Хуулийн

этгээдийг тодорхойлсон Иргэний хуульд “ашгийн төлөө”, “ашгийн төлөө бус” зорилго хоорондоо хэрхэн ялгагдах, үүнд үндэслэн холбогдох зохицуулалт ямар байхыг тодорхойгүй орхисон. Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан

зохицуулсан бусад хуульд ч энэхүү ялгааг тодруулан заагласан нь бүдэг байна.

Ерөнхийд нь авч үзвэл, ашгийн төлөө бус хуулийн этгээд нь олон нийтэд үйлчлэх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд ашиг орлого бүрдүүлэх үйл ажиллагаа эрхэлж, санхүүгийн нөөц бий болгох хэрэгцээ шаардлагатай тулгардаг. Харин ийнхүү олсон орлогоо үүсгэн байгуулагч, дарга, ажилтан, гишүүн зэрэг ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй ашиг сонирхол нь уягдсан аливаа этгээдэд ногдол ашиг болгон хуваарилах бус (non-distributing), байгууллагын дүрэмд заасан нийтэд тустай зорилгыг хэрэгжүүлэхэд зарцуулдаг¹ онцлогтой. Ашгийн бус үйл ажиллагааг дэмжсэн хандив, өглөг, буяны уламжлал сайн төлөвшөөгүй, энэхүү үйл ажиллагаагаа санхүүжүүлэх хувийн хөрөнгө оруулалт бүрдээгүй улс орнуудад ашгийн төлөө бус хуулийн этгээдэд арилжаа, бизнесийн үйл ажиллагаа явуулах эрх олгож, шаардлагатай орлогын эх үүсвэр бий болгохыг тэдэнд зөвшөөрч² ашгийн бус үйл ажиллагааг дэмждэг туршлага олон байдаг.

¹ ХЗҮХ (2014 он) “Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудал”, 9 дэх тал.

² Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) “Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж” ННФ, 46 дахь тал.

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан “Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно” гэсэн эрх зүйн харилцааны суурь нөхцөлийг эдгээр үйл ажиллагааны зорилго, мөн чанар, үр дагавартай холбон нарийвчлан тодотгосон зохицуулалт энэ хууль болон бусад хуульд тун ч бүдэг байна. Үүнийг тодотгож байж ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй харьцах зохицуулалт боловсронгуй болох нөхцөл бүрдэнэ.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийн “төрөл”, “хэлбэр”-ийг

”Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.”

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.2


зөвхөн зорилгоос нь шууд хамааруулан тодорхойлсон нь ойлгомжгүй байдал үүсэх эхлэлийг тавьсан гэж үзэж болохоор байна. Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д ерөнхий шинжийг нь тодорхойлсон хуулийн этгээдийн төрлийг, харин хэлбэрийг 33-36 дугаар зүйлд нарийвчлан заажээ. Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох”-оор заасны зэрэгцээ

“Хоёрдугаар дэд бүлэг: Хуулийн этгээдийн төрөл” гэсэн бүлэгт нөхөрлөл, компани, холбоо, сангийн эрх зүйн байдлыг тус бүрд нь хуулиар зохицуулах (34.2, 35.2, 36.3 дахь заалт)-аар заажээ. Ингэхдээ хоршоог нэлээд онцолж, 36 дугаар зүйлийн 36.5-д “Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна” хэмээн заажээ. Эндээс харахад, Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан 5 хэлбэрийн аль нэгд нийцсэн байх ёстой бөгөөд хуулийн этгээдийн хэлбэр нь ашгийн төлөө, эсвэл ашгийн бус зорилгоор ажиллахыг давхар тодорхойлохоор болсон байна.

Нийтийн сайн сайхны төлөө, нийтэд тустай, ашгийн бус үйл ажиллагаа явуулах ихэнх байгууллага нь манай улсын хувьд иргэний нийгмийн байгууллагууд байдаг. Тиймээс иргэний нийгмийн байгууллагуудын санаачилга, идэвхтэй оролцоотойгоор 2012 онд “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал”-ын төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд гол үзэл санааг доор товчлон харуулав. Үүнд:

“2.1. Иргэд үзэл бодол, нийтлэг ашиг сонирхлоороо албан болон албан бус бүлэгт сайн дураараа нэгдэн, эсхүл дан ганцаараа улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор орон нутаг, салбар, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахыг иргэний нийгэм гэж ойлгоно. Үүнийг

Бүдүүвч 1. Иргэний хуульд хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тодорхойлсон нь (33 дугаар зүйл)



- дэлхий нийтэд иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, эсвэл дан ганцаараа нийтлэг эрх ашиг, зорилго, үнэт зүйлсийн төлөө, гэр бүл, төр, зах зээлээс гадуур үйл ажиллагаа явуулдаг талбар хэмээн томъёолдог. Иргэний нийгмийг олон улсын хэмжээнд “ашгийн төлөө бус”, “сайн дурын”, “нийгмийн”, “буяны”, “гурав дахь хэвшил” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь иргэний нийгмийн олон төрөл, хэлбэр бүхий байгууллагуудад нэгэн адил хамаарна.
- 2.2. Сүм хийд, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, худалдаа аж үйлдвэрийн танхим, улаан загалмайн байгууллага зэрэг эрх зүйн тусгай зохицуулалт бүхий байгууллага нь иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд иргэний нийгмийн байгууллагын үндсэн шинж чанарыг өөртөө нэгэн адил агуулна.
- 2.3. Иргэний нийгмийн байгууллагууд нь хөгжлийнхөө түвшин, хараат бус байдал, нөлөөлөх чадварынхаа хувьд хоорондоо ялгарах боловч дараах нийтлэг шинж чанарыг агуулна:
- 2.3.1. Нийтийн ашиг тусад чиглэсэн зорилготой, ашгийн төлөө бус буюу олсон аливаа орлогоосоо ашиг хуваарилдаггүй, нийгэмд буюу гишүүддээ үйлчилдэг, тодорхой зохион байгуулалт, өөрийн удирдлагын бүтэц бүхий, төрөөс хараат бус зэрэг үндсэн шинж чанарыг агуулдаг гадна үйл ажиллагаандаа сайн дурын оролцоо, дэмжлэгийг зохих хэмжээгээр шингээсэн;
- 2.3.2. Иргэдийн эрх ашиг, хэрэгцээг төлөөлөн илэрхийлэх, хүний эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг хүлээдэг;
- 2.3.3. Төрийн аливаа дарамт, шахалт, нөлөөнөөс ангид байх бөгөөд энэ нь ардчиллыг гүнзгийрүүлэх, нийтлэг эрх ашиг, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, нийгмийн өөрчлөлтийг нэхэн шаардах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа шударга, үр дүнтэй явуулах гол нөхцөл болдог.
- 2.4. Иргэний нийгмийн байгууллага, албан болон албан бус бүлгүүдийг төлөвшүүлэн бэхжүүлэх нь иргэний нийгмийн хөгжлийг хангах үндсэн арга зам мөн.”
- хэмээн тодорхойлсон нь тухайн үед төр засгийн болон иргэний нийгмийн төлөөллийн харилцан зөвшилцөж илэрхийлсэн нэгдмэл ойлголтын томъёолол болж байжээ. Харин энэ баримт бичгийг УИХ-аар хэлэлцүүлэлгүй буцаан татсан шалтгаан нь тодорхойгүй үлджээ. Нэгэнт ойлголцож зөвшилцсөн энэ байр суурь нь нийтийн ашиг тусад чиглэсэн ашгийн бус үйл ажиллагаа, түүнийг эрхэлдэг хуулийн этгээдийн шинж төрх, эрх зүйн байдлыг тодотгох, үүнд нийцүүлэн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгоход баримтлах зарчим, чиглэлийг олон улсын туршлагад үндэслэн гаргасныг манай хууль тогтоогчид анхааран үзэх шаардлагатай юм.
- Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалт нь дээрх

төсөлд тусгасан үзэл санаанаас ихээхэн зөрүүтэй бөгөөд амьдрал практикт зохицуулах бус, зөрчил үүсгэх шинжтэй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (ХЭУБТХ, 2015 оны)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д ”хуулийн этгээд гэж Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг ойлгоно” хэмээн заасан атал 8 дугаар зүйлд нь 12 төрлийн хуулийн этгээдийн хэлбэрийг улсын бүртгэлд бүртгэхээр тогтоосон нь Иргэний хуулийн 33 дугаар зүйлд тодорхойлсон хуулийн этгээдийн 5 хэлбэрээс зөрүүтэй байгаа юм. Тухайлбал, Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заагаагүй “Төрийн бус байгууллага”, “Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар”, “Шашны байгууллага”, “Хэвлэл мэдээллийн байгууллага”, “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд”, “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж”, “Соёл, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага”, “Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар” гэсэн хэлбэрийг тусгасан байдгийг нэр мөр болгон зохицуулах шаардлагатай байна³. (Бүдүүвч 2-ыг харна уу).

Бүдүүвч 2. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тогтоон бүртгэж буй практик



Цаашилбал, хуулийн этгээдийн бүртгэлийн харилцааг гардан хэрэгжүүлж буй байгууллагын практикт энэ байдал бүр ч тодорхойгүй болсон байна. ОӨУБЕГ-т 2018 оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн хэлбэрийн жагсаалт (судалгааны тайлангийн хавсралт 5-ыг үзнэ үү)-аас харахад тодорхой болно. Ийнхүү Иргэний хууль ба Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар ашгийн бус хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тус бүр ялгаатай (3 ба 9) тодорхойлсон байгаа бол, Хуулийн этгээдийн Улсын Бүртгэлийн газраас энэ төрөл, хэлбэрийг 2 дахин нэмэгдүүлсэн байна (Хүснэгт 1).

³ Кейс судалгаанд хамрагдсан Шинэ Монгол сургуулиас бүртгэлтэй холбоотой энэхүү саналыг ирүүлсэн байдаг.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тогтоож бүртгэсэн байдал

№	Эх сурвалж	Хуульд заасан хэлбэр	Үүнээс ашгийн бус төрөлд хамаарах хэлбэрүүд
1	Иргэний хууль (2002)-д тодорхойлсон хуулийн этгээдийн төрөл	5	3
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)-д тодорхойлсон хуулийн этгээдийн төрөл	11	9
3	Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас бүртгэж буй хуулийн этгээдийн төрөл (2018.01-р сарын байдлаар) ⁴	40	18

Хүснэгтээс харахад, улсын бүртгэлд хуулийн этгээдийг нийт 40 өөр хэлбэрээр тодорхойлж, үүнээс ашгийн төлөө бус хуулийн этгээдийг 18 хэлбэрээр бүртгэж байгаа бөгөөд Иргэний хууль болон ХЭУБтХ-д тусгаагүй хэлбэрийг ч гарган бүртгэсэн байна. Жишээ нь, “Үйлдвэрчний эвлэл”-ийг хуулийн этгээдийн тусгай хэлбэр болгон бүртгэжээ. Энэ тохиолдолд Иргэний хуулиар хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг ангилан тогтоож, эрх зүйн байдлыг нь үүнд үндэслэн тусгай хуулиар зохицуулахын утга учир алдагдаж байна.

Хуулийн этгээдийн бүртгэл нь хяналтын анхан шатны албан ёсны хэрэгсэл хэмээн үзвэл үүнд хамаарах харилцаа ийнхүү маш ойлгомжгүй, тодорхойгүй зохицуулагджээ. Энэ нь хууль тогтоох бодлогын уялдаа холбоогүй байдал, салбарын хууль тогтоомжийг боловсруулахдаа Иргэний

хууль дахь хуулийн этгээдийн суурь зохицуулалттай нийцүүлээгүй зэргээс шууд хамааралтай гэж үзэж болохоор байгаа юм. ХЭУБтХ-иар тодорхойлсон хуулийн этгээдийн хэлбэрүүд нь Иргэний хуулиас гадна бусад хууль тогтоомжид дурдсан хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг нэгтгэсэн зохицуулалт байна. Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд боловсролын сургалтын байгууллага нь ашгийн төлөө, эсвэл ашгийн бус байж болохыг заасан боловч эдгээр нь Иргэний хуульд тодорхойлсон хуулийн этгээдийн аль төрөлд хамаарах, эсхүл шинээр хуулийн этгээдийн хэлбэр үүсгэж байгаа эсэхийг тодорхойгүй болгож орхигдуулсан. Ингэснээр ашгийн болон ашгийн бус зорилготой хуулийн этгээдүүд улсын бүртгэлд “боловсролын сургалтын байгууллага” гэсэн нэг ижил статустай бүртгэгдсэн нь цаашдын зохицуулалтыг бүрхэг тодорхойгүй болгожээ.

⁴ Хавсралт 5-аас дэлгэрүүлэн харах боломжтой.

Гэхдээ улсын бүртгэлийн харилцаанд үүсэж байгаа дээрх асуудлыг 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар ерөнхийд нь шийдвэрлэсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлд 10 шинэ хэлбэрийг нэмж, Иргэний хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (ХЭЗБтХ) болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (ТБОНӨтХ)-иар тогтоосон зохицуулалтын хүрээнд бүртгэхээр тусгажээ. Ийнхүү шинээр батлагдсан хуулийг хэрэгжүүлэхэд салбарын хуулиудыг түүнд хэрхэн нийцүүлэх, мөн Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг хэрхэн зөв тогтоох нь хэрэгжүүлэгч байгууллагад багагүй сорилт болох нь ойлгомжтой.

Хуулийн этгээдийн хэлбэрийг өргөжүүлэн зохицуулах дараагийн нэг үндэслэл нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-т хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчлөлтэй байж болохоор заасан ч 33-р зүйлд заасан хуулийн этгээдийн хэлбэр нь өмчлөлийн байдлаас хамаарах эсэхийг тодорхойгүй үлдээсэн. Тухайлбал, нийтийн өмчийн хуулийн этгээдийн хэлбэрийг зохицуулаагүй орхигдуулсан байна. Жишээ нь, ТБОНӨтХ (1996)-ийн Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал гэх 13 дугаар зүйлд:

“Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан

хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

- 1/ төрийн байгууллага, албан газар;
- 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар.
- 3/ төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.”

хэмээн заасан байна. “Үйлдвэрийн газар” нь бүтээгдэхүүн үйлдвэрлэн ашиг олох зорилгоор байгуулдаг аж ахуйн нэгж хэмээн үздэг нийтлэг төсөөллийг баримталбал энэ ангиллаар бүртгэгдсэн хуулийн этгээд нь Дулааны цахилгаан станц, эсвэл МИАТ компани зэрэг төстэй эрх зүйн зохицуулалттай байх болно. Гэтэл энэ ангилалд төрийн өмчийн их, дээд сургуулийг хамааруулан бүртгэж байгаа нь зохимжгүй юм. Иймд төрийн болон орон нутгийн өмчит “үйлдвэрийн газар” хэмээн бүртгэсэн боловсрол сургалтын болон соёл, урлаг, эрдэм шинжилгээний байгууллага нь “төрийн өмчит болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг”-ээс хэрхэн ялгарах, эдгээр байгууллага ашгийн төлөө ажиллаж болох эсэхийг тодорхой заалгүй үлдээжээ.

Түүнчлэн, Иргэний хуульд “нийтийн өмчийн” хуулийн этгээд гэж тодорхойлсныг ТБОНӨтХ-д “төрийн өмчит”, “орон нутгийн өмчит” хуулийн этгээдүүд болгон зөрчилдөөнтэй

зохицуулжээ. Энэ нь нэг талаасаа, хуулиудын нэр томъёог нэг мөр хэрэглэж чадахгүй байгааг харуулахын зэрэгцээ нөгөө талаас, өмнөх нийгмийн суурь ойлголт, үзэл санаа өнөөг хүртэл хадгалагдсаар байгаагай холбон дүгнэж болохоор байна.

Мөн Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийн хэлбэрийг тогтоохдоо зорилгоор нь хязгаарлаж өгсөн нь онолын хувьд зөрчилтэй болгожээ. Тухайлбал,

Иргэний хуулиар хоршоог ашгийн бус хуулийн этгээд гэж тодорхойлсон боловч Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д “гишүүний нийлүүлсэн эд хөрөнгийг үнийн дүнгээр болон биет байдлаар давхар бүртгэнэ”, 14 дүгээр зүйлийн 14.1.6-д “Хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хүртээх эрхтэй” гэсэн нь ашгийн төлөө байгууллагын шинжийг агуулсан байна. Түүнчлэн компани, нөхөрлөл нь зөвхөн удирдлага, зохион байгуулалтын хэлбэрээрээ хуулийн этгээдийн бусад төрлөөс ялгаатай зохион байгуулалтын нэгдэл юм. Зохион байгуулалтын уг хэлбэрийг ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус зорилготой аль ч байгууллага ашиглах боломжтой. Гэтэл манай оронд компанийн хэлбэрийг зөвхөн ашгийн төлөө зорилготой хуулийн этгээд

байхаар хуульчилсан нь бусад улсын практикт байхгүй, хуулийн этгээдийн эрх зүйн онолд нийцэхгүй зохицуулалт болсон.

Компани, нөхөрлөл нь зөвхөн удирдлага, зохион байгуулалтын шинжээрээ хуулийн этгээдийн бусад хэлбэрээс ялгаатай зохион байгуулалтын нэгдэл юм. Зохион байгуулалтын уг хэлбэрийг ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус зорилготой аль ч байгууллага ашиглах боломжтой. Гэтэл манай оронд компанийн хэлбэрийг зөвхөн ашгийн төлөө зорилготой хуулийн этгээд байхаар хуульчилсан нь бусад улсын практикт байхгүй, хуулийн этгээдийн эрх зүйн онолд нийцэхгүй зохицуулалт болсон.

Дээрхтэй холбогдуулан иргэний эрх зүйн эртний уламжлалтай ХБНГУ, Франц, Япон улсуудын хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзье.

ХБНГУ-д Иргэний хуулиараа холбоо болон сангийн эрх зүйн харилцааг зохицуулдаг бөгөөд холбоо нь ашгийн болон ашгийн төлөө бус зорилготой байж болохоор, сангийн хувьд ч үүсгэн байгуулах гэрээ, дүрэмд заасан зорилгынхоо дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч, хуулийн этгээдийн зорилгыг хуулиар хатуу тогтоогоогүй байна⁵. ХБНГУ-д холбоо,

⁵ МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхим (2017 он). ХБНГУ-ын Иргэний хууль (Кодификацийн бүрэн эх), орчуулсан Б.Буянхишиг

сан, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй хуулийн этгээдийн аль нь ч ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхлэх боломжтой боловч ашгийн бус хуулийн этгээдийн дотор ХХК-ийн хэлбэр давамгайлдаг. Холбоо, сангийн хувьд албан ёсоор бүртгэгдэн эрх зүйн чадамжтай болсноор үйл ажиллагаа явуулах боломж бүрддэг. Ийнхүү бүртгүүлээгүй буюу албан бус холбоог эрх зүйн чадамжгүй гэж үздэг байсан боловч сүүлийн үед эрх зүйн чадамжтай гэж үзэх хандлага ажиглагдах болжээ. Албан бус сангууд нь эрх зүйн чадамжгүй хэдий ч бэлэглэл, итгэлцлийн гэрээний дагуу байгуулагддагаараа онцлогтой. Зөвхөн энэхүү гэрээний үндсэн дээр эрх зүйн тодорхой харилцаанд оролцож, үйл ажиллагаа явуулах эрх эдлэх нөхцөл бүрддэг ажээ. ХБНГУ-ын ашгийн бус байгууллагууд нь ерөнхийдөө холбооны хуульд захирагддаг боловч сангууд нь зарим талаараа мужийн хуульд хамаарна. Холбооны хуулиар тухайн байгууллага татварын таатай нөхцөл эдлэх эсэхийг тодорхойлж өгдөг боловч эцсийн шийдвэрийг орон нутгийн татварын байгууллага гаргадаг байна. ХБНГУ-ын ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг Харьцуулсан судалгаанаас (Хавсралт-1) дэлгэрүүлэн харах боломжтой.

Франц Улсад Иргэний хуулиараа фирм болон компани зэрэг гишүүд нь ашиг хүртэж болох хуулийн этгээдийн

харилцааг зохицуулж өгсөн. Тэрчлэн холбоо, нөхөрлөл зэрэг гишүүнчлэл үүсгэх хэлбэртэй хуулийн этгээд ч байж болохоор зохицуулжээ.⁶ Мөн нөхөрлөлийн хэлбэрээр ашгийн бус зорилготой үйл ажиллагаа явуулж болохоор зохицуулсан байдаг.

Япон Улсын Иргэний хуульд хуулийн этгээдийн статусыг тусгайлан зохицуулаагүй. Харин эрдэм шинжилгээ, урлаг, буяны, тахилга, шашны болон бусад олон нийтийн эрх ашгийн төлөө хуулийн этгээд байж болохоор тусгасан байдаг⁷. Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг ерөнхий ба тусгай хуулиар зохицуулж байна. Ерөнхий хуулийн зохицуулалтад хамаарах ашгийн бус хуулийн этгээдийн харилцааг “Ашгийн төлөө бус байгууллага болон сангийн тухай хууль” (Act on General Incorporated Associations and General Incorporated Foundations)-иар зохицуулдаг ажээ. Уг хууль нь 2006 онд батлагдсан бөгөөд ашгийн бус хуулийн этгээдийн харилцааг нарийвчлан зохицуулсан хууль юм. Харин ашгийн төлөө бус хуулийн этгээд дундаас нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг тухай магадлан итгэмжлэлд (accreditation) хамрагдсан хуулийн этгээдийг нийтийн

⁶ Францын Иргэний хуулийн 1832-1873 дахь зүйлд хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулсныг үзнэ үү.

⁷ МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхим (2016 он). Япон Улсын Иргэний хууль, орчуулсан Б.Урангоо

ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд гэж ангилдаг. Өөрөөр хэлбэл, ашгийн төлөө бус байгууллагын хоёр шатлалт тогтолцоотой болжээ. Энэ харилцааг зохицуулсан хууль нь “Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон

санг магадлан итгэмжлэх тухай хууль” (Act on Authorization of Public Interest Incorporated Associations and Public Interest Incorporated Foundation) бөгөөд мөн 2006 онд батлагдсан байна.

Бүдүүвч 3. Япон Улсын нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд

2006 оноос өмнөх тогтолцоо

Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд (Иргэний хуулийн 34-р зүйлд заасан байгууллага, эсхүл сангийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.)

Дундын хуулийн этгээд
(Дундын хуулийн этгээдийн тухай хууль)

Шинэчлэлийн агуулга

- Ашгийн бус хуулийн этгээдийг бүртгэх болон нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдийг тодорхойлох асуудлыг заагласан
- Эрх олгох, бүртгэх, хяналт тавих захиргааны байгууллагыг өөрчилсөн
- Ил тод байдлыг хангасан шинэ бүтэц бий болгосон

2006 оноос хойших тогтолцоо

Ашгийн бус байгууллага болон сан

- Бүртгүүлснээр хуулийн этгээд болно.
- Нийтийн ашиг сонирхлын төлөө байхыг шаардахгүй.
- Бие даасан засаглалтай байхыг баталгаажуулсан.

Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон сан

- Өндөр мэдлэг, туршлагатай иргэдээс бүрдсэн хорооны саналыг үндэслэн ашгийн бус хуулийн этгээдийн зорилго, үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг тогтооно.
- Захиргааны үзэмжийг аль болох багасгах үүднээс харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг илүү тодорхой болгосон.
- Засаглал, мэдээллийн нээлттэй байдлыг сайжруулсан, зохистой хяналтын арга хэмжээг бий болгосон.

Япон Улс дахь ашгийн бус хуулийн этгээдийн талаарх зохицуулалтыг Харьцуулсан судалгаанаас (Хавсралт 1: Япон Улсын эрх зүйн зохицуулалтаас) дэлгэрүүлэн харах боломжтой.

Дээрх улс орнуудын зохицуулалт, туршлагатай харьцуулж үзэхэд, манай Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийн хэлбэр, зорилгыг тодорхойлж, хязгаарласан нь оновчгүй болжээ. Учир нь хуулийн этгээдийн хэлбэр нь зөвхөн зохион байгуулалтын хувьд ялгагдахаас бус, зорилгоор

Иргэний хууль болон бусад хуульд заасан хуулийн этгээдийн талаарх зохицуулалт агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, мөн Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийн хэлбэрийг тодорхойлохдоо ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус зорилготой нь шууд холбоотойгоор явцуу байдлаар тогтоосон нь оновчтой биш юм.

нь ялгаж, хязгаарладаг туршлага харагдахгүй байна. Иргэний хууль болон бусад хуульд заасан хуулийн этгээдийн талаарх зохицуулалт агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, мөн Иргэний хуулийн 33 дугаар зүйлд хуулийн этгээдийн хэлбэрийг тодорхойлохдоо ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус зорилготой нь шууд холбоотойгоор явцуу байдлаар тогтоосон нь оновчтой биш юм. Үүнээс шалтгаалж ХЭУБтХ-ийн зохицуулалт Иргэний хуультай

зөрчилдөж, ОӨУБЕГ нь амьдралд бодитой байгаа хуулийн этгээдийн хэлбэрүүдийг бүртгэхийн тулд ашгийн бус хуулийн этгээдийн шинэ шинэ хэлбэр гарган бүртгэж ирсэн нь хуулиас давсан үйл ажиллагаа болж байна.

1.1.1. Ашгийн бус салбарт төрөөс баримталж буй бодлого

Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 42 хууль, УИХ-ын 4 тогтоолд ашгийн бус салбарт хамаарах заалт туссан байна.⁸

Ашгийн бус хуулийн этгээдийг 1991-1997 онд “Засгийн газрын бус байгууллага”, “Олон нийтийн байгууллага” хэмээн нэрлэж Эрдэс баялгийн тухай (1991), Засгийн газарт эрх олгох тухай (1991), Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай (1991), Засгийн газрын тухай (1993), Онц байдлын тухай (1995), Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай (1995), Орон сууц хувьчлалын тухай (1996) хуулиудад тус тус хэрэглэсэн байдаг. 1997 онд баталсан Төрийн бус байгууллагын тухай хууль (ТББтХ)-д ашгийн төлөө бус зорилготой, нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг

⁸ Хавсралт-3. Ашгийн бус салбарын харилцааг зохицуулсан эрх зүйн эх сурвалжийн жагсаалтаас дэлгэрүүлэн харах боломжтой.

төрийн бус байгууллага (ТББ) гэсэн хоёр хэлбэрийг хуульчилжээ. Харин 2002 оны Иргэний хуульд ашгийн төлөө бус зорилготой хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тодорхойлжээ. УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар Төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичигт “...Нийгмийн салбарт эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ...” гэж заасан нь нийтэд ашиг тустай, ашгийн төлөө бус үйл ажиллагаа, хуулийн этгээдийг тодорхой салбарт дэмжих агуулгатай гэж үзэж болохоор байна.

Тэрчлэн, Засгийн газрын түвшинд 1994 оноос эхлэн “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал”, “Хүүхэд хөгжил, хамгаалал”, “Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах”, “Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр”, “Хүн амын эрүүл мэндийн боловсрол”, “Боловсролын мастер төлөвлөгөө” зэрэг Засгийн газрын хөтөлбөр, төсөлд ашгийн төлөө бус үйл ажиллагааг дэмжих тодорхой зорилт, арга хэмжээг тусган боловсруулж хэрэгжүүлсэн байдаг.

Монгол Улсад ашгийн төлөө бус салбарын харилцаа, түүний дотор иргэний нийгмийн харилцааг хөгжүүлэх, эрх зүйн зохистой орчин бий болгох зорилго, зарчим, арга замыг тодорхойлсон “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал”-ын төслийг 2011 онд Засгийн газрын 17 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсруулж, УИХ-д өргөн барьсан ч өнөөг хүртэл батлагдаагүй байна. Энэхүү Үзэл баримтлалын төсөл нь төрөөс хэрэгжүүлж буй зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагууд болон ашгийн төлөө бус салбарт шилжүүлэх, ашгийн бус, буяны, сайн санааны үйлсийг төрөөс

Монгол Улсад ашгийн төлөө бус салбарын харилцаа, түүний дотор иргэний нийгмийн харилцааг хөгжүүлэх, эрх зүйн зохистой орчин бий болгох зорилго, зарчим, арга замыг тодорхойлсон "Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал"-ын төслийг 2011 онд Засгийн газрын 17 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсруулж, УИХ-д өргөн барьсан ч өнөөг хүртэл батлагдаагүй байна.

дэмжих, түүнийг хэрэгжүүлэх цогц механизм бий болгох талаар тусгасан ач холбогдолтой баримт бичиг болох байжээ. Ашгийн бус салбарыг цогцоор нь харсан уг бодлогын баримт бичгийг нэмж сайжруулан Улсын Их Хурал (УИХ)-аар батлуулж, түүнийхээ дагуу

эрх зүйн орчныг бий болгох шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Ийнхүү ашгийн бус зорилготой хуулийн этгээд байж болох талаар Иргэний болон Боловсролын тухай зэрэг зарим хуульд дурдаж, Засгийн газрын хөтөлбөр төсөлд тэднийг дэмжих зорилт, арга хэмжээг тусгасан боловч энэ талаар төрөөс баримтлах бодлого, стратегийг илэрхийлсэн албан ёсны бодлогын баримт бичиг өнөө хэр гараагүй байна. Бусад улс оронд ашгийн бус хуулийн этгээд хэмээн тодорхойлсонтой ижил төстэй байгууллага, үйл ажиллагаа цар хүрээний хувьд цөөнгүй байгаа боловч үүнд хамаарах бодлого, зохицуулалт хангалтгүй байна гэж үзэх үндэслэл байна.

1.1.2. Монгол Улс дахь ашгийн бус хуулийн этгээдийн төрөл, хэлбэр

Ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих албан ёсны механизм нь улсын

бүртгэл юм. Гэтэл энэ төрлийн хуулийн этгээдийг тодорхойлох, бүртгэх зохицуулалт хангалтгүй байгааг өмнө тайлбарласан билээ. Энэхүү хууль тогтоомжийн зөрүү, тодорхойгүй байдал нь ашгийн бус хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг ОӨУБЕГ-аас 2018 оны 1 дүгээр сарын байдлаар гаргаж өгсөн ашгийн бус хуулийн этгээдийн бүртгэлийн дүн мэдээнээс харж болно. Бүртгэлийн үйл ажиллагаа эмх цэгцгүй байгаагаас Хүснэгт 1-д дурдсан ашгийн бус хуулийн этгээдийн 18 хэлбэрт холбогдох хуулийн этгээдийн тоог нарийвчлан гаргах боломжгүйд хүрчээ. Иймээс бүртгэлийн байгууллагаас тоон мэдээлэл гарах боломжтой буюу ашгийн бус хуулийн этгээдийн нийтлэг 8 хэлбэрээр бүртгүүлсэн 22473 байгууллага байгааг Хүснэгт 2-оор харуулж байна.

Хүснэгт 2. Ашгийн бус хуулийн этгээд: ОӨУБЕГ-ын мэдээ

№	Хуулийн этгээдийн хэлбэр	Хуулийн этгээдийн тоо
1.	ТББ	17,599
2.	Сан	1,302
3.	Шашны байгууллага	549
4.	Үйлдвэрчний эвлэл	1,264
5.	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	1
6.	Хэвлэл мэдээллийн байгууллага	1,072
7.	Боловсрол сургалтын байгууллага	819 (ашгийн - 26, ашгийн бус - 670)
8.	Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар (Төрийн өмчит их сургууль)	16

Тэрчлэн улсын бүртгэлийн байгууллагаас албан ёсоор гаргаж өгсөн энэхүү мэдээнээс тухайн хуулийн этгээд ашгийн төлөө бус, эсвэл ашгийн төлөө зорилготой эсэхийг эрх бүхий байгууллага төдийлөн анхаарч үздэггүй буюу улсын бүртгэл нь хяналтын тодорхой чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байна гэж ойлгоход хүргэж байгаа юм. Тухайлбал, төрийн өмчит их дээд сургуулийг боловсрол сургалтын байгууллагаас тусад нь ангилан “үйлдвэрийн газар” хэмээн бүртгэсэн төдийгүй ашгийн төлөө болон ашгийн төлөө бус боловсрол сургалтын байгууллагыг нэг бүлэгт бүртгэжээ. Энэ байдал эрүүл мэнд, соёлын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн

бүртгэлийн ангилалд бүр ч илүү харагдаж байна. Үүнээс үзэхэд хуулийн этгээдийн бүртгэл, тэр дундаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн бүртгэлийг цэгцлэх шаардлагатай болжээ. Түүнчлэн, ашгийн төлөө бус зорилгоор нийтэд ашиг тустай үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагыг тодруулж, хуульд заасан дэмжлэг үзүүлэх, хуулийн хүрээнд үндсэн зорилгынхоо дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих зэрэг улсын бүртгэлийн үүрэг биелэгдэхгүй байгаад анхаарал хандуулах цаг болсон байна.

Судалгааны явцад үүссэн хэд хэдэн хүндрэлийг 2018 онд батлагдсан Улсын бүртгэлийн тухай хуулиар ерөнхийд нь шийдвэрлэхийг зорьж, хуулийн

Хүснэгт 3. Ашгийн бус хуулийн этгээд: Хуулийн зохицуулалтын харьцуулалт

№	ИРГЭНИЙ ХУУЛЬ (2002)	ТБОНӨТХ (1996)	ХЭУБТХ (2018)
1	Холбоо (ИХ-ийн 36.1)		Холбоо (төрийн бус байгууллага) (ХЭУБТХ-ийн 7.1.3)
2	Сан (ИХ-ийн 36.2)		Сан (ХЭУБТХ-ийн 7.1.4)
3	Хоршоо (ИХ-ийн 36.4)		Хоршоо (ХЭУБТХ-ийн 7.1.5)
4	Сүм хийд (ИХ-ийн 36.6, 36.2)		Шашны байгууллага (ХЭУБТХ-ийн 7.1.6)
5			Нийтийн эрх зүйн хуулийн этгээд ХЭУБТХ-ийн 7.1.7
6		Төрийн байгууллага албан газар (ТБОНӨТХ-ийн 13.1)	Төрийн байгууллага, албан газар ХЭУБТХ-ийн 7.1.8
7		Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТБОНӨТХ-ийн 13.2)	Улсын төсөвт үйлдвэрийн газар ХЭУБТХ-ийн 7.1.9
8		Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг (ТБОНӨТХ-ийн 13.3)	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар ХЭУБТХ-ийн 7.1.10

этгээдийн зарим хэлбэрийг нэгтгэсэн нь Хүснэгт 3-т харагдаж байна. Иргэний хууль, ТБОНӨтХ болон ХЭЗБтХ-д заасан хуулийн этгээдийн хэлбэрүүдийг тус хуулийн 7 дугаар зүйлд нэгтгэн

тусгажээ. Гэвч өмнө дурдсан хуулийн этгээдийн хэлбэрийг түүний зорилго, хэлбэрээс үл хамааран тодорхойлоход чиглэсэн зохицуулалт хараахан хийгдээгүй хэвээр байна.

1.2. Төрийн өмчөөс ашгийн бус байгууллага болгон хувиргах туршилт, түүний үр дүн

1990 оноос Монгол Улсад эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн салбарын санхүүжилт огцом буурчээ. Тухайлбал, 1990 оноос өмнө боловсролын салбарт улсын төсвийн 25 хувь, Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ)-ий 64 хувийг зориулж байсан бол 1992 онд ҮНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх жин бараг 2 дахин (33 хувь) багасаж, боловсрол, эрүүл мэндийн салбарын нийт хөрөнгө оруулалт 69 хувиар буурсан байна. Учир нь 1990-ээд оныг хүртэл Монгол Улсын төсвийн гуравны нэгээс багагүй хэсгийг санхүүжүүлж байсан Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) задарч өмнө авч байсан зээл, тусламж зогссонтой холбоотой байдаг.

Иймээс 1990 оноос хойш өрнөсөн улс төр, эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй өөрчлөлтийн нэгээхэн хэсэг нь нийгмийн салбарт тулгарсан олон асуудлыг шийдвэрлэх арга замыг судалж хэрэгжүүлэх явдал байлаа. Энэ үүднээс эдийн засгийн салбарт хэрэгжүүлж байсан өмч хувьчлалыг нийгмийн салбарт үргэлжлүүлэх асуудалд анхаарал хандуулсан байна.

1995 оны сүүлээс боловсрол, эрүүл мэндийн салбараас хувьчлалд хамруулах объектоор тухайн үеийн Эдийн засгийн коллеж (1996 оноос Санхүү, эдийн засгийн дээд сургууль гэх болсон – СЭЗДС), Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн эмнэлгийг тодруулжээ. Харин эдгээр объектыг хувьчлах хэлбэрийг УИХ-ын 1996 оны сонгуулийн дараа тодорхойлсон байна. Тухайн үеийн сонгуулийн дүнд засгийн эрх “Ардчилсан холбоо эвсэл”-д шилжсэн бөгөөд уг эвсэлд Монголын Үндэсний Ардчилсан Нам (МУАН), Монголын Социал Демократ Нам (МСДН), Монголын Ногоон Нам (МНН)-ын төлөөллүүд багтсан байдаг.

Гэгээрлийн яамны хувьд өмч хувьчилсан зорилго, аргыг давтах бус, төрийн өмчит байгууллагаас ашгийн төлөө бус, бие даасан боловсролын байгууллага болгон хувиргах замаар нийгэмд үзүүлэх үйлчилгээний зорилго, чиглэлийг өөрчлөлгүй, цар хүрээг бууруулалгүй, чанарыг сайжруулах хувилбар боловсруулах зорилт тавьсан байна. Нийгмийн салбарын

хувьчлалын асуудлаар техникийн туслалцаа үзүүлж байсан Дэлхийн Банкны Ж.Касаграндэ ахлагчтай нийгмийн салбарын хувьчлалын төслийн баг “менежментийн үр дүнг харгалзан туршилтаар хувьчлах” үзэл баримтлалыг 1997 онд боловсруулсан юм. Засгийн газар энэ үзэл баримтлалыг зөвшөөрч, 1997 оны 7 дугаар сарын 2-ны 160 дугаар тогтоолоороо нийгмийн салбарын хувьчлалын хүрээнд СЭЗДС-ийг ашгийн бус байгууллага болгон хувиргах аргыг туршилтын журмаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ.⁹ СЭЗДС-ийг ашгийн бус байгууллага болгон өөрчлөх туршилтын 3 жилийн ажлын үр дүнд үндэслэн, тус сургуулийн удирдах эрх мэдлийг “СЭЗДС” ТББ-д шилжүүлж, 2000 онд 30 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байна.

Дараагийн Засгийн газар нийгмийн салбарт хувьчлал хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Нийгмийн салбарын хувьчлалын тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаан, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж байсан ч эцэслэн батлуулалгүй орхисон. Энэ хуулийн төслийг Дэлхийн Банкны мэргэжилтэн У.Мако, Х.Эрик нар судалж, 2001 оны 5 дугаар сарын эхээр дүгнэлтээ танилцуулж байжээ. Энэхүү дүгнэлтдээ тэд “Нийгмийн салбарын

хувьчлалын тухай” хуулийн төсөлд Засгийн газрын зорилтыг тодорхой тусгах, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээс гадна хувьчлах байгууллагуудын нөхцөлийг бүрдүүлэх, Төрийн өмчийн хорооны эрх, үүргийг тодорхой болгох, бие даасан байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, шийдвэр гаргагчтай шууд харилцах боломж бүрдүүлэх нь зүйтэйг тэмдэглэжээ. Тэрчлэн, чадварлаг мэргэжилтнүүдээс бүрдсэн баг бүрдүүлэхийг баталгаажуулах нь чухал гэж үзсэн байна. Мөн төрийн байгууллагыг компани хэлбэрээр (өөрөөр хэлбэл, ашгийн төлөө байгууллага болгон) хувьчилж болно. Гэхдээ энэ үед ажиллагчдын давуу эрх, төрийн эрх мэдлийг хэрхэн тусгах талаар анхаарах нь зүйтэй гэжээ. Мөн орлого хуваарилах, нийгмийн үйлчилгээний чанарын талаар нийтийн эрх ашгийг хамгаалсан заалт байх ёстой гэсэн санал өгсөн байна. Нөгөө талаар, нийгмийн салбартай холбоотой бусад хуулийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөхийн чухлыг У.Мако, Х.Эрик нар тэмдэглэжээ.

Боловсролын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан хувьчлалын тухайд дээрх мэргэжилтнүүдийн хийсэн дүгнэлтэд БСШУЯ-нд хувьчлалын талаарх эдийн засгийн тооцоо, судалгаа хангалттай бус, тусгай мэргэжлийн сургуулийг хувьчлах арга нь тодорхой бус байгаа учраас хувьчлалыг хэрэгжүүлэх цаг арай болоогүй байна гэж дурджээ. Мөн салбарын яамдад стратегийн

⁹ МННХ/ННФ (2003 он) “Боловсролын салбарын өөрчлөлт, хувьчлалын кейс судалгаа” https://forum.mn/res_mat/final_report.pdf 2018.03.09-нд хандан.

ба хувьчлалын судалгаа байхгүй, ер нь нийгмийн салбарын хувьчлалын стратеги төлөвлөгөөг Засгийн газраар хэлэлцүүлэх шаардлагатай гэжээ.

Менежментээр хувьчлагдсан хуулийн этгээдийн нийгмийн салбарт үзүүлэх үйлчилгээний үнэ тариф хямд, нийгмийн эмзэг хэсэгт хүртээмжтэй байлгах зорилттой байсан ч энэ зорилт зөрчигдсөн байдаг. Менежментийн хувьчлал нэрээр төрийн өмчийн байгууллагын байр, газрын өмчлөлийг шилжүүлэхэд л илүү анхаарал хандуулснаас, хувьчлагдсан хуулийн этгээдийн статус тодорхойгүй болсон тохиолдол цөөнгүй гарчээ.

Ийнхүү шийдвэрлэх, зохицуулах шаардлагатай олон зүйл байгаа учраас энэ хуулийг ядаж 6 сар хойшлуулах хэрэгтэй гэсэн санал дүгнэлтийг эцэст нь өгсөн байдаг. Дээрх хуулийн үзэл баримтлалын хувьд нийгмийн салбарын хувьчлалын онцлог, хөндөгдөх асуудлыг бүрэн судалж тусгаагүй, төсөл хангалттай хэмжээнд боловсруулагдаж чадаагүй байна гэж үзээд дахин боловсруулахаар шийдвэрлэж буцаасан бөгөөд энэ хууль өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Харин 2002 оны 7 дугаар сарын 10-нд УИХ-аас ТБОНӨТХ-д “нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал” гэсэн бүлэг нэмж оруулан¹⁰ төрийн өмчит их сургууль, мэргэжлийн сургуулиудыг хувьчилжээ. Хуульд нийгмийн салбарын

¹⁰ ТБОНӨТХ-ийн Долдугаар бүлэг “Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал” нэртэйгээр 65¹⁻⁵ дугаар зүйлд зохицуулсан байдаг.

менежментийн хувьчлалыг өмч хувьчлалын адилаар уралдаант сонгон шалгаруулалтын аргаар явуулахаар зохицуулсан. Мөн хувьчлал явуулах процедур,

түүний ил тод нээлттэй, шударга байдлыг хангах механизм нь хангалттай тодорхой биш, төрийн байгууллагын үүрэг оролцоо бүдэг, хэт товч, ерөнхий зохицуулалттайгаас шалтгаалж менежментийн хувьчлал хийх анхны үзэл баримтлал зарим талаар алдагдсан ажээ. Тухайлбал,

менежментээр хувьчлагдсан хуулийн этгээдийн нийгмийн салбарт үзүүлэх үйлчилгээний үнэ тарифыг хямд, нийгмийн эмзэг хэсэгт хүртээмжтэй байлгах зорилттой байсан ч энэ зорилт зөрчигдөж, хувьчлагдсан байгууллагуудын үнэ тариф өөрчлөгдөн, үнэ нь нэмэгдсэн байдаг.¹¹ Менежментийн хувьчлал нэрээр төрийн өмчийн байгууллагын байр, газрын өмчлөлийг шилжүүлэхэд л илүү анхаарал хандуулснаас, хувьчлагдсан хуулийн этгээдийн статус тодорхойгүй болсон тохиолдол цөөнгүй гарчээ.¹²

¹¹ Эдийн засгийн бодлого судлал нийгэмлэг (2004 он) “Нийгмийн салбарын хувьчлал: Эрүүл мэндийн салбарын хувьчлал судалгаа, 30 дахь тал (Монгол эм импекс, Эмийн үйлдвэр, Клиникийн III эмнэлэг, Шаргалжуут, Хужирт рашаан сувиллын туршлага)

¹² Удирдлага, Эдийн Засгийн Сургалт, Эрцэм Шинжилгээний Байгууллагуудын Консорциум (2004 он) “Нийгмийн салбарын хувьчлал, соёл, урлагийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын кейс судалгаа” 76 дахь тал.

Ерөнхийдөө нийгмийн салбарын хувьчлал УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарын хувьчлах байгууллагуудын жагсаалт”-ын хүрээнд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Улаанбаатар Их Сургууль, Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль, Техник технологийн коллеж, “Монгол Эм Импекс” эмийн үйлдвэр, Клиникийн нэгдсэн III эмнэлэг, Шаргалжуут, Хужирт рашаан сувилал, Улсын Цирк зэрэг боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёлын салбарын төрийн өмчит нийт 19 байгууллагыг хувьчлахаар зарласан байна. Боловсролын салбараас сонгож хувьчилсан тохиолдлуудаас

Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Хүнсний технологийн коллеж, Техник технологийн коллежийн туршилтын хугацааны менежментийн гэрээний нөхцөл биелэгдсэн тул өмч хөрөнгийг нь тогтоосон үнээр менежментийн багт нь худалдаж, харин Улаанбаатар Их Сургууль, Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн хувьчлалын гэрээг цуцалж, төрийн өмчид буцаан авсан байна.

Ийнхүү Монгол Улсад нийгмийн салбарт хувьчлал хийх эхний туршилт төрийн өмчит сургалтын байгууллагыг ашгийн бус, нийгэмд үйлчлэх бие даасан байгууллага болгон хувиргах зарчмаар хэрэгжсэн боловч дараагийн шатанд нээлттэй дуудлага худалдааны аргыг хүртэл хэрэглэн хувийн өмчлөлд шилжүүлэх замаар үргэлжилжээ.

1.3. Ашгийн бус хуулийн этгээдийн бүртгэлийн харилцаа, тулгамдаж буй асуудал

Иргэд ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулахын тулд заавал хуулийн этгээд байгуулах шаардлагагүй, харин зорьж сонирхож буй чиглэлээрээ ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг албан ёсны статустай хуулийн этгээдтэй хамтрах, түүний үйл ажиллагааг дэмжих нь илүү үр дүнтэй байж болох юм. Үнэхээр нийтэд тустай ашгийн бус үйл ажиллагааг чухалчилж байгаа бол санаа зорилгоо нэгтгэж, хүчин чармайлтаа хамтатгах нь илүү зохистой, хэмнэлттэй бөгөөд иргэний нийгмийн институцийг

бэхжүүлэх, итгэлцлийг бататгах давхар ач холбогдолтой билээ.

Монгол Улсын иргэд бидний хувьд ашгийн бус үйл ажиллагааг өөрийн хяналтад, зохиогчийн болоод өмчлөгчийн эрхээ өөртөө хадгалан эрхлэх сонирхол, эрмэлзэл ихээхэн түгээмэл байдаг. Үүний илрэлийг 1990 оноос хойш өрнөсөн төрийн бус байгууллага байгуулах санаачилга, хөдөлгөөн маш хурдтай өргөжин тэлснээс харж болно. Тухайлбал,

Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдсаны дараахан 1997 онд 400 гаруй байсан ТББ-ын тоо 2005 онд 10 гаруй дахин (5077) нэмэгджээ. ОӨУБЕГ-ын 2017 оны 5 дугаар сарын статистик мэдээгээр хуулийн этгээдээр бүртгүүлсэн ТББ-ын тоо 16166 болжээ.

Статистикийн үндэсний хорооноос гаргасан мэдээгээр төрийн бус байгууллагын бүртгэлийг 2009 он хүртэл Хууль зүй, дотоод хэргийн яам хөтөлж байгаад Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т шилжүүлсэн. Монгол Улсын хэмжээнд 2008 оноос өмнө 9352, үүнээс хойш 2014 хүртэлх хугацаанд 3955 мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, сан, шашин, үйлдвэрчний эвлэл, сонин, сэтгүүл, телевизийн байгууллагууд шинээр бүртгүүлснээр нийт бүртгэгдсэн байгууллагын тоо 13307 болсон гэжээ¹³. Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2008 оноос өмнө бүртгүүлсэн төрийн бус байгууллагуудын талаарх мэдээллийн бааз хангалтгүй байснаас эдгээр байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох боломжгүй байснаас гадна 2009-2011 онд нийт ТББ-ын 2.3 хувь нь л жилийн тайлангаа ХЗДХЯ-нд ирүүлжээ. Түүнчлэн, 2008-

2011 онд Татварын ерөнхий газарт бүртгэлтэй ТББ-уудын 4.0 орчим хувь нь татварын тайлангаа ирүүлсэн байна (Хүснэгт 4-ийг харна уу.).

УБЕГ болон Татварын ерөнхий газарт бүртгүүлж байгаа ТББ-ын тоо аль аль нь 2008-2011 онд өссөн дүн харагдаж байна (Хүснэгт 5).

Дээрх тоон мэдээллээс харахад ТББ-ын бүртгэл, тайлагналыг сайжруулахад цаашид анхаарах шаардлагатай байна.

Хуулийн этгээдийг татан буулгах, бүртгэлээс хасахад тулгамдаж буй асуудал: Өнөөдрийн байдлаар ашгийн бус хуулийн этгээдийг татан буулгах харилцааг Хууль зүйн сайдын 2015 оны а/39 дүгээр тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-аар зохицуулж байна. Ашгийн бус хуулийн этгээдийг татан буулгахад тавигдах хамгийн чухал шаардлага бол тухайн байгууллагын хөрөнгийг хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагч, гишүүдэд хуваарилах ёсгүй. Харин ашгийн бус зорилготой бусад үйл ажиллагаа эрхэлдэг, эсхүл адил зорилготой хуулийн этгээдэд шилжүүлэх байдлаар шийдвэрлэдэг. Гэтэл улсын бүртгэлийн байгууллагаас зөвхөн ашгийн бус байгууллагын хүсэлтийн дагуу, дээрх журмын 6.2-т заасан баримт бичгийг бүрдүүлсэн тохиолдолд бүртгэлээс хасах зохицуулалтай байна.

¹³ ҮСХ (2014). *Төрийн бус байгууллагын секторын хүрээг тодорхойлох тухай*. 9 дэх тал (энэ материалыг англи хэлээр *Defining the non-for-profit sector in Mongolia* буюу “Ашгийн төлөө бус секторыг тодорхойлох нь” хэмээн гарчигласан нь ашгийн бус секторыг зөвхөн ТББ-аар төлөөлүүлэн үзсэний илэрхийлэл болжээ.)

Хүснэгт 4. ХЗДХЯ болон Татварын ерөнхий газарт ирүүлсэн тайлангийн статистик мэдээлэл

	2008 он	2009 он	2010 он	2011 он
Үйл ажиллагааны тайлангаа ирүүлсэн ТББ-ын тоо	Мэдээлэл байхгүй	185	218	1161
Санхүүгийн тайлангаа ирүүлсэн ТББ-ын тоо	67	72	100	213

Хүснэгт 5. ХЗДХЯ болон Татварын ерөнхий газарт бүртгүүлсэн байгууллагын тоо (2008-2011 он)

	2008 он	2009 он	2010 он	2011 он
УБЕГ-т бүртгүүлсэн ТББ-ын тоо	Мэдээлэл байхгүй	1285	2012	1961
Татварын ерөнхий газарт бүртгүүлсэн ТББ-ын тоо	2600	3338	4190	5562

Татварын байгууллагаас 2016 онд татвар төлөгчийн мэдээлэлд тулгалт хийж, татвар төлөгчийн бүртгэлгүй, мөн зургаа ба түүнээс дээш сарын хугацаанд татварын тайлан ирүүлээгүй нийт 11,786 ТББ-ыг татан буулгах саналыг ОӨУБЕГ болон Сангийн яаманд хүргүүлсэн ч одоог хүртэл эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Энэ нь нэг талаас 6709 ТББ нь татвар төлөгчийн бүртгэлгүй буюу анх байгуулагдсан цагаасаа эхлэн татвар төлөөгүй, татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, нөгөө талаас мөн татварын байгууллагын хяналт сул байгааг харуулж байна. Татварын байгууллага, Улсын бүртгэлийн байгууллагаас эцэслэн татан буулгах шийдвэр гараагүй байгаагийн шалтгаан нь хуулийн дагуу улсын бүртгэлийн болон татварын байгууллагууд нь улсын

бүртгэлээс хуулийн этгээдийг хасах, татан буулгах эрхгүй байх тул гацаанд орсон хэмээн албаны эх сурвалж тайлбарласан байдаг. Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн харилцаанд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг төрийн байгууллагууд болох Татварын ерөнхий газар, ОӨУБЕГ-ын ажлын уялдаа холбоо маш сул байна. Тухайлбал, Хуулийн этгээдийн мэдээлэл, статистик тоо баримт нь хоорондоо зөрдөг, Татварын ерөнхий газар улсын бүртгэлд байхгүй хэлбэрээр хуулийн этгээдийг бүртгэсэн мэдээлэл ч байгаа юм (Хүснэгт 6).

Дээрх мэдээ нь хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөлт төрийн байгууллагуудад ихээхэн ялгаатай явагдаж байгааг харуулахын зэрэгцээ хуулийн этгээдийн улсын бүртгэл болон татварын байгууллагад нэг байгууллага

Хүснэгт 6. Хуулийн этгээдийг бүртгэсэн мэдээ: 2017 оны байдлаар

	Төсөвт байгууллага	ТББ	Шашны байгууллага	ХМБ	БСБ	ОНБ
ТЕГ-ын бүртгэл	5,217	17,647	613	88	58	2,602
ОӨУБЕГ-ын бүртгэл	4,668	17,599	549	1,072	819	?
Зөрүү	-549	-48	-64	-984	-761	

өөр өөр статустайгаар бүртгэгдсэн байх ч магадлалтай. Хүснэгтээс харахад, бүртгэлийн хувьд улсын төсвөөс санхүүждэг байгууллагын тоо 549, хэвлэл мэдээллийн байгууллагын тоо 984, боловсролын сургалтын байгууллагын тоо 761-ээр зөрж байна. Ийм тохиолдолд аль байгууллага нийтэд ашиг тустай үйл ажиллагаа нэрийн доор ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгааг тогтооход ихээхэн бэрхшээлтэй юм.

2004 оны байдлаар ТББ-ууд нийт санхүүжилтийнхээ талаас илүүг (59.5 хувь) гадаадын донор байгууллагуудаас,

Бүлгийн дүгнэлт

Монгол Улс шинэ Үндсэн хуульдаа “иргэний ардчилсан нийгэм байгуулах” зорилтыг тунхаглаж, улс төр, эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй өөрчлөлтийг эхлүүлсэн 1990-ээд оны эхэн үеэс иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэж, төрийн бус байгууллага байгуулах, ашгийн төлөө бус зорилгоор нийтэд болон тодорхой хэсэг бүлэгт ашиг тустай үйл ажиллагаа эрхлэх, түүнийг дэмжих санаачилга хөдөлгөөн

гуравны нэг хүрэхгүйг (27.9 хувь) аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс бүрдүүлсэн бол, 12.6 хувийг өөрийн үйл ажиллагаагаараа тус тус олж байсан¹⁴ гэж ХЗДХЯ мэдээлсэн байна. Түүнээс хойш төрийн бус байгууллагууд олон улсын болон дотоодын эх үүсвэрээр хэдий хэмжээний хөрөнгө төвлөрүүлж, ямар зориулалт, чиглэлээр зарцуулж байгаа талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа байхгүй хэмээн Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны мэдээнд тэмдэглэсэн байна.

эрс идэвхэжжээ. Ийнхүү төрөөс гадна иргэд, байгууллагын санаачилгаар үүссэн байгууллагыг хуулийн этгээд болгон албажуулах зохицуулалтын шинэ зарчим, механизм шаардлагатай болсныг холбогдох хуулиудад тусгаж иржээ.

Харин Иргэний хуульд хуулийн этгээдийн ерөнхий шинжийг

¹⁴ ХЗДХЯ: 2004 оны ТББ-уудын үйл ажиллагааны тайлан

тодорхойлон төрөл, хэлбэрийг нь зөвхөн ашгийн төлөө, эсвэл ашгийн төлөө бус зорилготой байхаас нь хамааруулан шууд тодорхойлон зааж өгсөн нь зөрчил үүсгэж байна. Мөн Иргэний хуульд хуулийн этгээдийн таван үндсэн хэлбэрийг л хуульчилсан нь бодит байдалтай нийцэхгүй байгаа юм. Тэрчлэн, нийтийн ба холимог өмчийн хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тусгаагүй зэргээс шалтгаалан бүртгэлийн бусад шатанд хуулийн этгээдийн өөр өөр, шинэ хэлбэрийг үүсгэн бүртгэхэд хүргэж, эцэстээ хууль зөрчих, бүртгэлээр дамжуулан хяналт тавих боломжийг бууруулж иржээ. Ер нь холбогдох хуулиуд хоорондоо зөрүүтэй, бүртгэлийн практик нь ч хуулиасаа зөрүүтэй байгаа өнөөгийн нөхцөлд хуулийн этгээдийг төрөл хэлбэрийн хувьд ангилан бүртгэх оролдлого нь ч өөрөө ямар нэг практик ач холбогдолгүй болжээ. Хуулийн этгээдийн олон төрөл хэлбэрийг улсын бүртгэлд бүртгэхдээ ашгийн болон ашгийн бус зорилготой байгууллагыг нэг бүлэгт оруулан ангилсан байгаа нь үүний тод жишээ юм. Үүнээс харахад Төрийн бус байгууллагын тухай хууль (ТББтХ) нь ашгийн бус хуулийн этгээдэд холбогдох харилцааг бүхэлд нь зохицуулж чадахгүй байгаа бөгөөд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтлэг шинж, нэгдсэн зохицуулалтыг тогтоож чадаагүй байна. Нийтийн ашиг тусын тулд ашгийн бус зорилгоор

ажиллаж буй хуулийн этгээдийн харилцааг зохицуулсан бусад улс орны туршлагаас үзэхэд хуулийн этгээдийн хэлбэр нь зохион байгуулалтын хэлбэрийг илэрхийлэхээс бус, зорилгыг илэрхийлдэггүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн хэлбэрийг зорилгоос нь хамааруулан шууд ангилан тогтоодоггүй байна. Гэхдээ бүртгэлийн харилцаанд үүсэж байгаа хүндрэлийг 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар ерөнхийд нь шийдвэрлэхийг зорьсон боловч үүнийг бусад салбарын хуулиудад хэрхэн уялдуулан тусгах, практикт ямар өөрчлөлт авчрахыг хэлэхэд хараахан эрт байна.

Ашгийн бус салбарт төрөөс баримтлах бодлого одоогоор тодорхойгүй, энэ талаар тухайлан гарсан бодлогын баримт бичиг байхгүй нөхцөлд дээр дурдсан зөрчлүүдийг арилгах зорилгоор 2012 онд боловсруулсан “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал” өнөөг хүртэл батлагдаагүй төслийн хэмжээнд байсаар ажээ. Ашгийн төлөө бус байгууллагыг бүртгэх практик оновчтой бус, ашгийн төлөө бус байгууллагын мэдээлэл хаалттай, мөн хууль тогтоомж зөрчсөн, үйл ажиллагаа нь зогссон байгууллагыг татан буулгах, бүртгэлээс хасах механизм байхгүйгээс энэ асуудлыг хариуцсан төрийн байгууллага бүртгэлээс хасаж, мэдээлэл, хяналтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхэд хүндрэл үүсэж байна.

Хоёрдугаар бүлэг

АШГИЙН БУС САЛБАРЫН ТАТВАРЫН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Ашгийн бус салбарыг дэмжих зохицуулалт

Нийтийн эрх ашгийн тулд ашгийн бус зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих нь энэ чиглэлийн сайн туршлагатай улс орнуудын баримталдаг нийтлэг бодлого юм. Ийнхүү ашгийн бус зорилгоор ажиллаж буй болон түүнийг дэмжин хандив өгөх, тусламж үзүүлэх этгээд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах зэрэг таатай нөхцөл эдлэх

Ер нь улс орнууд нийтэд тустай үйл ажиллагааг нэг бүрчлэн жагсаах аргаас татгалзаж эхэлсэн бөгөөд нийгэмд ашиг тустай байж болох бүхий л үйл ажиллагааг нийтэд тустай гэж үзэх хандлага баримтлах болсныг энд тэмдэглэе.

хүсэлт гаргасны үндсэн дээр асуудлыг шийддэг нь түгээмэл зохицуулалт ажээ. Татварын таатай нөхцөл эдлэх этгээдэд хуулийн дагуу бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн, тухайн улсын холбогдох хуулиар тодорхойлсон нийтийн эрх ашиг, тусын төлөө ашгийн бус зорилготой үйл ажиллагаа явуулдаг, ногдол ашиг хуваарилдаггүй байх зэрэг нийтлэг үндсэн шалгуур

тавигддаг¹⁵ байна (Хавсралт 6-д АНУ, Япон, ХБНГУ болон Европын орнуудын зохицуулалтыг харьцуулан харуулсныг үзнэ үү).

Улс орнууд нийтэд тустай, ашгийн бус үйл ажиллагааг тодорхойлохдоо нийгмийн эрэлт хэрэгцээ, уламжлал, хууль зүйн бодлого зэрэг нь тухайн улсын ямар салбар, чиглэл, бүлэгт тустай болох, түүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн зохицуулахыг тодорхойлох шалгуур, хүчин зүйлс болгодог байна. Тухайлбал, АНУ-ын хувьд цэргийн ажиллагаанд оролцож амь үрэгдсэн болон шархадсан цэрэг, түүний ар гэрт тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг оруулдаг бол Японд газар хөдлөлт, цунами зэрэг байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах, хор хохирлыг бууруулах үйл ажиллагааг багтаадаг ажээ.

¹⁵ ХЗҮХ (2014 он) “Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудал”, 10 дахь тал. International Center for Not-for-Profit Law, *Survey of Tax Laws Affecting Non-Governmental Organizations in Central and Eastern Europe*, Second edition, 2003, p.11

Ер нь улс орнууд нийтэд тустай үйл ажиллагааг нэг бүрчлэн жагсаах аргаас татгалзаж эхэлсэн бөгөөд нийгэмд ашиг тустай байж болох бүхий л үйл ажиллагааг нийтэд тустай гэж үзэх хандлага баримтлах болсныг энд тэмдэглэе. Учир нь, нийтэд тустай үйл ажиллагааны төрлийг нэг бүрчлэн заах шийдэл нь нийтэд тустай үйл ажиллагааны хүрээг хэт хязгаарлах дутагдалтай гэж үзэж байна. Швейцар Улс нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлохдоо хуулиар шалгуурыг тогтоож, түүнийгээ удирдлага болгон шийдвэрлэдэг ажээ. Үүнд:

- ▶ Олон нийтийн зүгээс тухайн үйл ажиллагааг ашиг тустай гэж хүлээн зөвшөөрсөн байх;
- ▶ Байгууллагын үйл ажиллагаа нь нийтийн ашиг тусад ихээхэн хэмжээний хувь нэмэр оруулах;
- ▶ Байгууллагын үйл ажиллагаанаас гишүүд нь хувьдаа ашиг олохгүй, ашиг хуваарилдаггүй байх болон олон нийтийн үзэл бодол, дүгнэлтийг шууд хамааруулж шалгуур болгодог онцлогтой байна¹⁶.

Мөн зарим улс оронд энэхүү нийтэд ашиг тустай байх шинж чанарыг “Үндсэн зорилгын шалгуур тест”-ээр үнэлж тухайн байгууллагын зорилго,

үйл ажиллагаа нь арилжааны буюу ашгийн төлөө байна уу, эсвэл ашгийн төлөө бус байна уу гэдгийг тогтоодог. Хэрэв ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байвал нийтэд тустай үйл ажиллагаа явуулдаг буюу татварын хөнгөлөлт эдлэх статус олгохоос татгалзах үндэслэл болдог. Япон Улсын Ашгийн төлөө бус үйл ажиллагааг хөгжүүлэх тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дахь заалтад “ашгийн төлөө бус зарим байгууллагад орлого олох үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх бөгөөд харин олсон орлогоо ашгийн төлөө бус үйл ажиллагаанд хэрэглэнэ. Гэхдээ орлого олох үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус үйл ажиллагаатай холилдон хутгалдах ёсгүй” хэмээн зохицуулсан байдаг.¹⁷ Татварын таатай нөхцөл эдлэх статус олгоход “зорилго” гэх цорын ганц хатуу шалгуурыг хэрэглэдэг практик ч байдаг. Энэ шалгуурын дагуу хэрэв байгууллагын нийтийн ашиг сонирхлоос гадуурх зорилго нь түүний нийтийн төлөө зорилгын үнэмлэхүй хэсэг болж чадахгүй бол түүнийг нийтэд үйлчлэх байгууллагын шаардлагыг хангаагүй гэж үздэг.

Нийтэд тустай цорын ганц зорилго нь нийтийн ашиг сонирхолд чиглэж байсан ч түүний үйл ажиллагааны дотор аж ахуйн үйл ажиллагаа байж болохыг зөвшөөрөх тохиолдол байдаг. Энэ нь

¹⁶ ХЗҮХ (2013 он). “Нийтэд тустай үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт”, 6-8 дахь тал.

¹⁷ Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) “Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж” ННФ, 46, 101 дэх тал.

нийтийн ашиг сонирхолд нийцсэн зорилгыг хэрэгжүүлэхэд хамгийн үр ашигтай арга зам нь аж ахуйн үйл ажиллагаа байж болохыг харгалзан үзсэн хэрэг юм. Жишээлбэл, ашгийн төлөө бус эмнэлэг, сургууль, театр, музей нь төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг хэдий ч төлбөрийн чадваргүй хүмүүст үнэ төлбөргүй үйлчилдэг тохиолдол байдаг. Мөн олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах хамгийн үр ашигтай арга зам нь урлагийн болон байгаль, орчныг хамгаалах сэтгүүл гаргаж худалдах явдал байж болно. Өөрөөр хэлбэл, нийтэд тустай байгууллагын нийтийн ашиг сонирхлын төлөөх зорилгыг хангахад аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг, тэр нь нийт үйл ажиллагааны ихэнх, эсвэл дийлэнх нь болж байсан ч түүнийг нийтийн тусын төлөө бус байгууллага гэж үзэж болохгүй.

Татварын таатай нөхцөлд хамруулах нь тухайн байгууллагын хүсэлтээр, татварын таатай нөхцөл эдлэх шаардлагыг хангасан нөхцөлийг үндэслэн, сайн дурын үндсэн дээр хэрэгждэг байна. Ерөнхийдөө хүсэлт гаргаж буй байгууллага нь зорилгоо тодорхойлсон үндсэн баримт бичиг болон татварын хөнгөлөлт эдлэх шаардлага хангаснаа нотлох баримтын хамт холбогдох байгууллагад хүргүүлдэг байна. Ийнхүү татварын давуу нөхцөл эдлүүлэх, тусгай статус олгох нь ихэвчлэн татварын байгууллагын чиг үүрэгтэй холбоотой байдаг ч зарим

улсад энэ асуудлыг хариуцсан тусгай тогтолцоо бий болгосон тохиолдол байна. (Тухайлбал, Англид Уэльсийн “Charity Commission” хэмээх нийтийн тусын тулд ажилладаг ашгийн төлөө бус байгууллагын бүртгэл хяналтыг хэрэгжүүлдэг байгууллагыг Парламентын дэргэд байгуулсан байна.)

2.1.1. Ашгийн бус байгууллагад татварын таатай нөхцөл олгож буй АНУ-ын тогтолцоо

АНУ-д ашгийн бус байгууллага¹⁸ нийтэд тустай үйл ажиллагаа явуулах статустай болсноор татвараас чөлөөлөгдөх давуу эрхтэй болно. Татвараас чөлөөлөгдөх статустай болохын тулд Холбооны улсын болон Муж улсын хуулиар тогтоосон шаардлагыг хангасан байхыг шаарддаг.

Ашгийн төлөө байгууллага татвараас чөлөөлөгдсөнөөр сайн үйлсийн хандив, тусламжийг татварын хасалтгүй дүнгээр хүлээн авах, зарим ашгийн бус байгууллагын хувьд хөдөлмөрийн харилцаанаас үүдэлтэй орлогод татвар төлөхгүй байх боломж бүрддэг. Тиймээс АНУ-ын Татварын асуудал хариуцсан засгийн газрын байгууллага (ТАХЗГБ)¹⁹-аас тодорхой шаардлага хангасан ашгийн бус байгууллагад

¹⁸ Ашгийн төлөө бус компани, траст, хуулийн этгээдийн эрхгүй холбоо гэсэн хэлбэртэй байна.

¹⁹ Internal Revenue Service нь АНУ-ын Холбооны Засгийн Газарт харьяалагдах Засгийн газрын Агентлаг

“татвараас чөлөөлөгдөх статус”-ыг олгож, хэрэгжилтэд хяналт тавьдаг ажээ²⁰.

АНУ-д Татварын хууль²¹-ийн 501-530 дугаар зүйлийн дагуу сайн үйлсийн болон бусад сайн санааны байгууллагуудыг татвараас чөлөөлөх харилцааг зохицуулж байна. Ашгийн бус байгууллагад “татвараас чөлөөлөгдөх статус” олгоходоо 501.с.3²² заалтыг баримтална. Татварын хуулийн 501.с.3 заалтад “татвараас чөлөөлөгдөх статус” олгож болох ашгийн бус үйл ажиллагааг жагсаасан ба үүнд 29 төрлийн ангилалд нийт 645 үйл ажиллагаа²³ хамаарна. Татварын хуульд заасан эдгээр ашгийн бус байгууллага нь улс төр болон хууль тогтоох үйл ажиллагаанд оролцохгүй ба өөрийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой. Зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулж олсон орлого нь татвараас чөлөөлөгдөнө. Харин зорилгодоо үл нийцэх буюу өөрийн зорилгод хамааралгүй үйл

²⁰ Татвараас чөлөөлөгдөх статус бүхий ашгийн бус байгууллагуудыг бүртгэн авч, жил бүр ирүүлсэн тайлангаар нь хянах зарчмаар ажиллана.

²¹ Internal Revenue Code нь АНУ-ын хууль тогтоомжийн 26 дугаар бүлэгт хамаарах ба 1873 оноос тус хуулийн анхны үзэл санаа бүрэлдэж 1878, 1939, 1954, 1986 онуудад шинэчлэгдсэн. Одоогоор 1986 онд шинэчлэн батлагдсан 9834 зүйл заалт бүхий хувилбарыг мөрдөж байна.

²² Энэ зүйлд заасан татвараас чөлөөлөгдвөл зохих ашгийн бус байгууллагын дийлэнхийг сайн санааны, боловсролын болон шашны байгууллагууд бүрдүүлдэг.

²³ <http://nccs.urban.org/classification/national-taxonomy-exempt-entities>, www.councilofnonprofits.org/what-is-a-nonprofit

ажиллагаа явуулж орлого олсон тохиолдолд уг орлогоос татвар төлүүлж, цаашлаад “татвараас чөлөөлөгдөх статус”-ыг хүчингүй болгох хүртэл хариуцлага ногдуулна.

Дээр дурдсан “татвараас чөлөөлөгдөх статус” олгогдох 645 нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх ашгийн бус байгууллагыг дор дурдсан үндсэн хоёр төрөлд хуваадаг:

1. Нийтийн ашиг сонирхлын байгууллага²⁴
2. Хувийн сан

Эдгээр нь санхүүжилтийн эх үүсвэрээрээ өөр хоорондоо ялгагдах ба нийтийн ашиг сонирхлын байгууллага нь өргөн хүрээнд санхүүжилт олж байхад хувийн сангийн санхүүжилтийн эх үүсвэр харьцангуй хязгаарлагдмал байдаг.

“Татвараас чөлөөлөгдөх статус”-тай ашгийн бус байгууллага нь уг эрхийг олж авснаас хойш 6 дахь жилээсээ эхлэн жилийн тайлан гаргаж өгөх үүрэг хүлээнэ. Нийтийн ашиг сонирхлын байгууллага нь олон нийтийн дэмжлэг авах шаардлагыг хангахгүй болсон бол Хувийн сан гэсэн ангилалд шилжинэ.

Ашгийн бус байгууллага нь Татварын хуулийн дагуу санхүүгийн болон санхүүгийн бус бүх үйл ажиллагаанд бүртгэл хөтлөх үүрэгтэй. Татварын

²⁴ Сүм, сургууль, эмнэлэг зэрэг олон нийтийн дэмжлэг авсан байгууллага байна

хуулийн 501.с.3-д зааснаар сайн үйлсийн хандивын үйл ажиллагааны хувьд дараах баримт бичиг бүрдүүлнэ. Үүнд:

1. Хандивлагч хандив өгсөн тухай баримт
2. Хандив хүлээн авагч хандив хүлээн авсан тухай баримт заавал үйлдсэн байна.

Ашгийн бус байгууллага нь дээрх хоёр баримтад тулгуурлан үйл ажиллагааны бүртгэл хөтөлнө.²⁵ Энэхүү бүртгэлийн дагуу жилийн мэдээ тайлан болон жилийн цахим мэдэгдлийг Татварын асуудал хариуцсан засгийн газрын байгууллага (ТАХЗГБ)-д жил бүр хүргүүлнэ. Хэрэв ийнхүү хүргүүлээгүй бол тайлан хүргүүлээгүй хоног тутамд 20–100 ам.долларын²⁶ торгууль ногдуулах ба 3 жил дараалан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайлан хүргүүлээгүй бол “татвараас чөлөөлөгдөх статус” нь автоматаар цуцлагдана.²⁷

Ашгийн бус байгууллага нь тухайн жилийн тайлан мэдээгээ олон нийтэд ил болгох үүрэгтэй ба олон нийтэд ямар нэг төлбөргүйгээр саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь ил тод байх, цаашлаад олон нийтийн итгэлийг олж авах нөхцөлийг бүрдүүлдэг.

²⁵ *Applying for 501(c)(3) Tax-Exempt Status Manual* published on www.usa.gov/start-nonprofit

²⁶ Нийт хүлээн авсан хандивын хэмжээнээс хамаарна.

²⁷ Publication 557 – *Tax-Exempt Status for Your Organisation* published on www.usa.gov/start-nonprofit

Жилийн мэдээ тайланг олон нийтэд ил болгохдоо хандивлагч, санхүүжүүлэгч, болон бусад адилтгах этгээдийн хувийн мэдээллийг задруулахыг хориглоно.

Түүнчлэн ашгийн бус байгууллага нь өөрийн зорилгод үл хамаарах үйл ажиллагаа явуулснаас олсон 1000 ам.доллороос дээш үнийн дүнтэй орлогоо ТАХЗГБ-д улирал бүр мэдүүлж, тогтоосон хувь хэмжээгээр татвар төлөх үүрэгтэй. Тухайлбал, ашгийн бус үйл ажиллагаа явуулж буй байгууллага ажилтан авч цалинжуулсан тохиолдолд тухайн ажилтны цалинд ногдох албан татварыг суутган авч бүртгэх, тайлагнах, эрх бүхий байгууллагад төлөх үүрэг хүлээнэ.

Ашгийн бус байгууллага нь ашгийн төлөө байгууллагад тавигдах бусад шаардлагыг хангасан байхын зэрэгцээ татвар төлөгч байгууллагад тавигдах шаардлагыг давхар хангаж байх үүрэгтэй.

АНУ-д татвараас чөлөөлөгдөх статус олгох үйл явц дараах үе шаттай байдаг.

Өргөдөл хүлээн авах:

1. Холбогдох маягт бөглөх – Тухайн үйл ажиллагааны тухайн төрөлд хамаарах маягтын дагуу мэдээлэл өгч, татвараас чөлөөлөгдөх тухай албан хүсэлт, эрх бүхий этгээдэд олгосон итгэмжлэл, Татварын хуулийн 501.п.2-т заасан террорист байгууллагад үл харьяалагдах тухай

тодорхойлолт, үйлчилгээний хураамж төлсөн баримт зэргийг бүрдүүлнэ.

2. Шаардлагатай бол нэмэлт баримт бичиг гаргаж өгөх – Ашгийн бус байгууллагын үүсгэн байгуулагч болон ажилтнуудын мэдээлэл, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн дүрэм, дотоод журам, үйл ажиллагааны танилцуулга, сүүлийн 3 жилийн санхүүгийн мэдээллийг нэмэлтээр гаргаж өгч болно.

Өргөдлийг шийдвэрлэх:

1. ТАХЗГБ нь ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч хянаж үзээд шаардлага хангасан гэж үзвэл татвараас чөлөөлөгдөх статус олгох ба хэрэв шаардлага хангаагүй тохиолдолд уг статусыг олгохоос татгалзсан хариуг өгнө.
2. ТАХЗГБ шийдвэрээ албан бичгээр мэдэгдэнэ.

Татвараас чөлөөлөгдөх статус олгохоос татгалзсан шийдвэрийг хүлээн авсан этгээд нь дээд шатны захиргааны байгууллагад гомдол гаргаж болох ба дээд шатны бүх байгууллагад гомдол гаргаад тэдний шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шүүхэд хандах эрхтэй болно. Үүнээс үзэхэд татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж байгаа хуулийн этгээд нь нийтэд тустай үйл ажиллагааг тогтвортой эрхэлдэг, үүнтэй холбоотой шийдвэрийг хараат бусаар гаргадаг,

орлогоо хууль ёсны эх үүсвэрээс бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулдаг болохоо нотолсон мэдээ, мэдэгдлийг гаргаж өгсний үндсэн дээр ийм онцгой статус эдлэх эрхийг олж авна.

2.1.2 Ашгийн бус байгууллагад хамаарах Монгол Улсын татварын зохицуулалт

Монгол Улс 1997 онд ТББтХ-д ашгийн бус байгууллагад хамаарах ерөнхий зохицуулалтыг анх хуульчилжээ. Түүнчлэн, 1998 оноос татварын системийг оновчтой болгох бодлогын хүрээнд ТББ-ыг орлогын татвараас чөлөөлөх, дэмжигчдэд нь татварын хөнгөлөлт үзүүлэх заалтыг татварын хуульд тусгасан байна. Тухайлбал, Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн²⁸ (1992 оны) 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт:

- ▶ төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн татвар, хандив,
- ▶ нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого²⁹-ыг албан татвараас чөлөөлөхөөр заажээ.

Төрийн бус байгууллагыг татварын бодлогоор дэмжих арга замыг оновчтой

²⁸ Энэ хуулийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хууль батлагдсантай холбогдуулан хүчингүй болгосон байдаг.

²⁹ Энэ заалтыг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

тодорхойлох ажил цааш үргэлжилж, иргэний нийгмийн оролцоотой ажлын хэсэг байгуулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах ажил 2000-аад оны эхэн үед нэлээд идэвхэжжээ. Энэ талаар ННФ-аас 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт” сэдэвт хэлэлцүүлэгт ХЗДХ-ийн дэд сайд Ц.Мөнх-Оргил тавьсан илтгэлдээ “...2002 оны эхний улирлын байдлаар 2500 орчим ТББ бүртгэгдсэнээс 80 орчим хувь (2000) нь нийгэмд үйлчилдэг, 20 орчим хувь (400) нь гишүүддээ үйлчилдэг статустайгаар үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь татварын хуулиар нийгэмд үйлчилдэг ТББ-ын орлогыг татвараас чөлөөлөх зохицуулалттай шууд холбоотой гэж мэргэжилтнүүд үзэж байгаа тул үүнийг цаашид өөрчлөх шаардлагатай эсэхийг судална...” хэмээн хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, ТББ-ыг нийтээр нь орлогын албан татвараас чөлөөлж, давуу нөхцөл эдлүүлсэн нь оновчтой биш байсныг тэмдэглэжээ. Энэ талаар ХЗҮХ-ээс хийсэн судалгаанд³⁰ хуулиар төрийн бус байгууллагыг гишүүддээ үйлчилдэг болон олон нийтэд үйлчилдэг гэж ангилсан ч энэ ангилал нэг нь нөгөөгөөсөө илүү татварын таатай нөхцөл эдлэх үндэслэл болохгүй төдийгүй татвар ногдуулахад харгалзан үзэх нөхцөлд тооцогдох

³⁰ ХЗҮХ (2015 он). *Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудал*

эсэхийг хуулиар нарийн зохицуулаагүй байгааг тэмдэглэжээ. Ийнхүү уг асуудлыг зохицуулалтгүй орхисон нь гишүүддээ үйлчлэх, эсвэл нийтийн ашиг тусын төлөө үйлчлэхийн ялгаа, үүнээс хамааран татвар ногдуулах, татвараас хөнгөлөх, чөлөөлөхийн учир холбогдлыг алдагдуулахад хүргэж болзошгүй болжээ.

Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудлыг судалсан дээрх судалгаанд дараах ноцтой дүгнэлт хийсэн байна:

“Үндсэндээ Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай гэх зэрэг татварын голлох хуулиудаар төрийн бус байгууллагад татварын таатай дэглэм бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгоогүй буюу төрийн бус байгууллагын үйл ажиллагааны онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэгт ач холбогдол өгөөгүй байна. Энэ нь нэг талаас, төрийн бус байгууллагыг татварын дарамт бүхий нөхцөлд үйл ажиллагаа явуулахад хүргэж байгаа бөгөөд нөгөө талаас, хараат бус иргэний нийгмийн институц бүрэлдэн бий болох үйл явцыг сааруулах хүчин зүйл болж болзошгүйг харгалзан үзэх шаардлагатай.” (ХЗҮХ, 2015: 37 дахь тал)

Татварын таатай нөхцөлийг хэнд эдлүүлэхийг оновчтой зохицуулахгүй бол ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг арилжааны байгууллагууд татвараас зугтах, эсвэл ийм үйл

ажиллагааны халхавч болж ашиглагдах эрсдэлтэй тул ашгийн бус үйл ажиллагаа эрхэлж байгааг нь нотлох, үйл ажиллагаа нь нийтэд ашиг тустай, эсвэл зөвхөн гишүүддээ чиглэсэн эсэхийг тодруулах замаар зохих хязгаарлалт хийж байх шаардлагатай.³¹ Тухайн үеийн эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд Татварын байгууллага, ХЗДХЯ нь хяналт тавих чиг үүрэгтэй боловч ашгийн бус үйл ажиллагаа явуулж буй эсэх, зорилгоосоо өөрөөр ажиллаж ашиг олсон, түүнийг хуваарилах зэрэг зөрчил гарч байгаа эсэхэд хяналт тавих бодитой механизм бүрдээгүйгээс үр дүнтэй ажиллаж чаддаггүй.

Ашгийн бус үйл ажиллагааг татварын зохицуулалтаар хянах, дэмжихэд чиглэсэн зарим заалт 1997 онд ТББТХ-д, дараа нь 1998 онд татварын тухай хуулиудад тусгалаа олж ТББ-уудад 2002 онд 19.1 сая, 2003 онд 34.5 сая, 2004 онд 26.7 сая төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт тус тус эдлүүлж байжээ³². Харин 2006 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд ТББ-ын эдэлж байсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг хассан байдаг.

³¹ Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) "Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж" ННФ, 46 дахь тал.

³² Ардчиллын Боловсрол Төв (2005 он). *Монгол Улс дахь төрийн бус байгууллагуудын мэдээлэл: Судалгааны тайлан*

Ашгийн бус үйл ажиллагаанд ямар төрөл, чиглэлийн үйл ажиллагааг хамруулж болохыг улс орнууд янз бүрээр тодорхойлсон байдаг ч ихэвчлэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн гүйцэд эдлэх боломж нь хязгаарлагдсан хэсэгт хандсан, хүнлэг энэрэнгүй, буяны үйлс, нийтийн ашиг сонирхолд нийцсэн хэм хэмжээг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хамруулдаг байна. Харин энэ талаарх монголчуудын нийтлэг төсөөллийг тандан судлах

2006 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд төрийн бус байгууллагын эдэлж байсан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг хассан.

зорилготой “*ашгийн бус, нийтэд тустай үйл ажиллагаанд ямар үйл ажиллагааг хамааруулах вэ?*” гэсэн асуулгад судалгаанд оролцогчид дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

а. Дараах чиглэлийн үйл ажиллагааг бүхэлд нь нийтэд ашиг тустай гэж үзэх:

- ▶ Эрүүл мэндийн үйл ажиллагаа
- ▶ Хүүхэд залуучууд, өндөр настны аж амьдралыг дэмжих

б. Дараах үйл ажиллагааг шинж чанар, цар хүрээ, хүртээмжээс нь хамааран нийтэд ашиг тустай эсэхийг нэг бүрчлэн тодорхойлж:

- ▶ Боловсрол
- ▶ Нийгмийн халамж, асрамж
- ▶ Хүний хөгжлийг дэмжих
- ▶ Соёл, урлаг
- ▶ Биеийн тамир, спорт
- ▶ Байгаль орчныг хамгаалах, байгалийн аюул, гамшигтай тэмцэх
- ▶ Хүний эрхийг хамгаалах
- ▶ Шинжлэх ухаан, технологи
- ▶ Нийгмийн эмзэг, ядуу хэсэгт дэмжлэг, туслалцаа үзүүлэх
- ▶ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах
- ▶ Хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Үндэсний Статистикийн хороо, АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуультай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хийгдсэн “Төрийн бус байгууллагын секторын хүрээг тодорхойлох тухай” 2014 оны судалгаанд олон улсын ашгийн бус үйл ажиллагааны төрөлд багтдаг 16 төрлийн үйл ажиллагааг Монгол Улсад ашгийн бус үйл ажиллагаа гэж үздэггүй хэмээн дурджээ.

Эдгээрийг өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид “нийтэд ашиг тустай үйл ажиллагаа”-тай адилтгах утгаар тодорхойлсон заалтуудтай харьцуулбал дараах дүр зураг харагдаж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтаар дараах үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөхөөр заасан нь тэдгээрийг

“нийтэд ашиг тустай” хэмээн үзэж буйг илэрхийлж байна. Үүнд:

- боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ;
- эрүүл мэндийн үйлчилгээ;
- шашны байгууллагын үйлчилгээ;
- төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ. Үүнд: Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна гэжээ.

Хэдийгээр эдгээр үйлчилгээ шинж чанарын хувьд нийтэд ашиг тустай хэмээн үзэхүйц боловч түүнийг эрхэлж буй этгээд нь ашгийн төлөө зорилготой байж болохыг ялган авч үзээгүй байна.

НҮБ-ын олон улсын ашгийн бус байгууллагын ангиллыг³³ Хавсралт 7-д харуулав. Олон улсын ашгийн бус байгууллагын ангилалд 12 ерөнхий бүлэг, 63 нарийвчилсан үйл ажиллагааны төрлийг хамруулж авч үзсэн байдаг. Үүнээс Үндэсний Статистикийн хороо, АНУ-ын Жонс

³³ <https://www150.statcan.gc.ca/n1/pub/13-015-x/2009000/sect13-eng.htm>

Хопкинсийн их сургуультай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хийгдсэн “Төрийн бус байгууллагын секторын хүрээг тодорхойлох тухай” 2014 оны судалгаанд олон улсын ашгийн бус үйл

ажиллагааны төрөлд багтдаг 16 төрлийн үйл ажиллагааг Монгол Улсад ашгийн бус үйл ажиллагаа гэж үздэггүй хэмээн дурджээ.

2.2. Ашгийн бус хуулийн этгээдийг татварын бодлогоор дэмжих аргууд

Улс орнуудад ашгийн бус үйл ажиллагаа, түүнийг эрхэлдэг хуулийн этгээдийг дэмжихэд дараах нийтлэг татварын бодлого, арга хэлбэрийг ашиглаж байна. Үүнд:

- ▶ **Татварын чөлөөлөлт – tax exemption** (Татварын чөлөөлөлт нь ашгийн төлөө үйл ажиллагааны зардлыг татвараас чөлөөлөх)
- ▶ **Татварын хөнгөлөлт – tax credit** (Татварын хөнгөлөлт нь ашгийн төлөө бус үйл ажиллагаанд хандив өгсөн татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг багасгах)
- ▶ **Татварын хасалт – tax deduction** (Татварын хасалт нь хандивлагчийн татвар ногдох орлогын хэмжээгээр татварын суурийг багасгах)
- ▶ **Татварын зориулалтын схем/хууль – tax designation scheme/law** (Хувь этгээд өөрийн орлогын тодорхой хувийг тодорхой төрлийн ашгийн төлөө бус байгууллагад хандивлахыг дэмжих зохицуулалт. Энэ зохицуулалт анх Итали Улсад үүссэн бөгөөд татвар төлөгчдөд татварынхаа 1 хувийг сүмд зориулан

төлөхийг зөвшөөрч эхэлсэн байна. Унгар Улс энэ туршлагыг авч, хувь хүн татварынхаа 1 хувийг өөрийн сонгосон ашгийн төлөө бус байгууллагад, мөн 1 хувийг сүм, хийдийн байгууллагад зориулах эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ. Ингэхдээ татварын энэ дэглэм нь олон нийтэд үйлчилдэг байгууллагад үйлчилнэ)³⁴

Дээрхээс үзэхэд татвараар дэмжих зохицуулалтыг ашгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд зориулсан, энэ төрлийн үйл ажиллагааг дэмждэг татвар төлөгчдөд зориулсан хэмээн ангилж болохоор байна. Ерөнхийдөө татвараас чөлөөлөх аргаар ашгийн бус байгууллагыг дэмжиж, нийтийн ашиг тусын төлөө зориулсан хандив, буцалтгүй тусламж, гишүүнчлэлийн төлбөр, хураамжаас бүрдсэн орлого, аж ахуйн үйл ажиллагаа (худалдаа, ажил үйлчилгээ зэрэг)-аас болон идэвхгүй хөрөнгө оруулалт (засгийн газрын гэрээ, мөн хөрөнгө оруулалтаас олдог хүү, ногдол ашиг,

³⁴ ХЗҮХ (2014 он) *Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудал*, 10 дахь тал.

үл хөдлөх хөрөнгийн түрээс гэх мэт)-аас олсон орлого зэргийг тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд татварын чөлөөлөлтөд хамруулдаг байна.³⁵

Энэхүү тайлангийн 1.1 дэх хэсэгт дурдсанчлан ашгийн төлөө бус байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоо нийтийн эрх ашгийн төлөөх зорилготой үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулдаг. Гэхдээ ашгийн бус байгууллагын аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогод хэрхэн татвар ногдуулбал зохих талаар дараах нийтлэг хандлага байна. Үүнд:

- ▶ Бүх орлогод татвар оногдуулах;
- ▶ “Хамааралт байдлын сорил” (Relatedness test) ашиглах – Олсон орлого нь байгууллагын олон нийтэд үйлчлэх зорилгод хамааралгүй тохиолдолд татвар ногдуулах;
- ▶ “Орлогын зориулалтын сорил” (Designation income test) ашиглах – Ашгийн төлөө үйл ажиллагаанаас олсон бүх орлого нь байгууллагын олон нийтэд үйлчлэх зорилгоо хэрэгжүүлэхэд зарцуулагдаж байгаа бол бүхэлд нь татвараас чөлөөлөх;
- ▶ “Босго тогтоох”- Ашгийн төлөө үйл ажиллагаанаас олсон орлого нь тогтоосон босго, хязгаараас давсан

³⁵ International Center for Not-for-Profit Law (2003). *Survey of Tax Laws Affecting Non-Governmental Organizations in Central and Eastern Europe*, Second edition, p.11

тохиолдолд татвар ногдуулах;

- ▶ Гибрид буюу холимог сорил ашиглах.

Мөн ашгийн бус байгууллагын хандивлагчийг дэмжих татварын урамшууллын дэглэм (tax preference) байдаг. Үүнд татварын хөнгөлөлт болон хасалт, татварын зориулалтын схем/хуулийн арга хамаарна. Тухайлбал, олон оронд буяны өглөг, иргэдийн сайн үйлийг хөхиүлэн дэмжих үүднээс иргэд, бизнесийн байгууллагаас ашгийн бус байгууллагад өгсөн хандивт татварын зохистой хөнгөлөлт эдлүүлдэг. Их Британид татварыг эргүүлэн төлөх зарчим, Унгар, Словак, Латви, Польшид татварын хуваарилалтын систем үйлчилдэг.³⁶

Мөн зарим улс оронд НӨАТ болон Гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлэх, ашгийн бус байгууллагыг НӨАТ болон Гаалийн албан татвараас чөлөөлөх тохиолдол байдаг. Гаалийн татвараас хөнгөлж, эсхүл чөлөөлж, мөн

³⁶ Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) "Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж" ННФ, 105 дахь тал. (Зарим оронд албан хаагчдын цалингаас татварыг шууд суутгадаг. Ийм тохиолдолд ашгийн төлөө бус байгууллагад хандив өгснийхөө төлөө татварын хөнгөлөлт эдлэхэд хэцүү болдог. Харин зарим ийм оронд хандив өгсөн албан хаагч үүнийгээ удирлагадаа танилцуулж, татвар ногдох орлогоосоо хасуулдаг байна. Унгар Улсад албан хаагч өөрийн цалингийн 1 хувийг нийтэд үйлчилдэг аль нэг байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрдөг. Татварын энэхүү бүтэц нь нийт татвар төлөгчид ашгийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих боломжийг нээж өгдөг.)

нийтийн төлөөх зорилгод хэрэглэхээр импортолсон бараа, үйлчилгээг импортын НӨАТ-аас хөнгөлөх, эсхүл чөлөөлдөг байна. Тэрчлэн үл хөдлөх хөрөнгө болон хувийн өмчийн татвар, худалдааны татвар, өв болон газрын татвараас чөлөөлөх буюу хөнгөлөх тохиолдол байдаг. Тухайлбал, Их Британид буяны байгууллагуудын орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн татварыг 80 хүртэлх хувиар хөнгөлдөг. Мөн энэ дээр нэмэгдээд орон нутгийн захиргаа 20 хүртэлх хувийн нэмэлт хөнгөлөлт үзүүлэх эрхтэй байдаг.³⁷

Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлд татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх хэлбэрийг зохицуулж өгсөн. Үүнд:

- ногдуулсан татварыг хорогдуулах;
- татварын хувь, хэмжээг бууруулах;
- тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;
- татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;
- татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;
- хууль тогтоомжид заасан бусад хөнгөлөлт эдэлж болохоор зохицуулсан.

³⁷ Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) "Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж" ННФ, 68-71 дэх тал.

Гэхдээ ашгийн бус байгууллагад нийтлэг байдлаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, ашгийн бус байгууллагын хандивлагчид татварын хасалт эдлүүлэхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна. Зөвхөн тухай бүрт нь ашгийн төлөө бус зарим бараа, ажил, үйлчилгээ, байгууллагад хөнгөлөлт, чөлөөлөлт, давуу байдал эдлүүлэхээр зохицуулсан байдаг.

▶ **Татварын хөнгөлөлт:** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10-т “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийг ийнхүү хандивласан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцно” хэмээн заасан нь зөвхөн үүсгэн байгуулагчаас хамааралтай чөлөөлөлт бөгөөд ямар зорилготой, хэнд үйлчилдэг, хандивласан хөрөнгө болон бусад орлогоо зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг хэрхэн магадалж тогтоох нь тодорхойгүй үлдсэн байна.

▶ **Татварын чөлөөлөлт:** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасан дараах төрлийн барааг НӨАТ-аас чөлөөлдөг:

- гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа;
 - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэгсэл;
 - ▶ Мөн тус хуулийн 13.5-т заасан дараах төрлийн үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг:
 - боловсролын болон мэргэжлийн сургалт явуулах тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдийн эрхлэн гүйцэтгэж байгаа дүрэмд нь заасан боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ;
 - эрүүл мэндийн үйлчилгээ;
 - шашны байгууллагын үйлчилгээ;
 - төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ. Үүнд Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна.
 - ▶ Тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.12-т “Засгийн газрын бус байгууллагууд Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр санхүүжилт авч төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг бүрэн буюу хэсэгчлэн гүйцэтгэж байгаа үйлчилгээ 13.5.12-т хамаарахгүй” хэмээн тус тус зохицуулсан байна.
 - ▶ Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу газар эзэмших, ашигласны төлбөрөөс дараах үйл ажиллагаа чөлөөлөгдсөн байна.
 - Монгол Улсын иргэнийг түүнд байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалахад зориулан эзэмшүүлсэн газрын;
 - өмчийн хэлбэр харгалзахгүйгээр улсын бүртгэлтэй асрамжийн болон бүх шатны боловсролын байгууллагыг эзэмшиж, ашиглаж буй газрынх нь;
 - сууц өмчлөгчдийн холбоог түүнд гэрээгээр ашиглуулж байгаа орчны газрыг төлбөрөөс чөлөөлсөн зэрэг зохицуулалт байна.
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлд ашгийн төлөө болон ашгийн бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагад өмчийн хэлбэр харгалзалгүй нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээнд үндэслэн суралцагчдын тоогоор нь улсын төсвөөс санхүүжилт олгохоор заасан. Ингэснээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, өндөр төлбөртэй хувийн сургууль сурагчийн тоогоор төсвөөс санхүүжилт хуваарилуулан авдаг болсон. Ашгийн төлөө ажилладаг боловсролын сургалтын байгууллагад хувьсах зардал олгохыг хязгаарлах, төлбөрийн хэмжээнээс хамааруулан

төсвийн санхүүжилтийг бууруулах хувилбар³⁸ багагүй яригддаг ч шийдлээ олоогүй байна.

Мөн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн хувьд Эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын тодорхой хувийг авах боломжтой байна.

Дээр дурдсан хуулийн заалт, тэдгээрийн хэрэгжилтээс үзэхэд тухайн үйл ажиллагаа нь нийтэд ашиг тустай эсэх, тийм бол энэ ажлыг ашгийн бус зорилгоор хэрэгжүүлж байгаа

эсэхийг магадлах, хандивласан, шилжүүлсэн хөрөнгө, санхүүжилт нь ашгийн төлөө бус үндсэн зорилгын

Ашгийн төлөө ажилладаг боловсролын сургалтын байгууллагад хувьсах зардал олгохыг хязгаарлах, төлбөрийн хэмжээнээс хамааруулан төсвийн санхүүжилтийг бууруулах хувилбар багагүй яригддаг ч шийдлээ олоогүй байна.

дагуу зарцуулагдсан эсэхийг хянах, нотлох механизм байхгүй. Энэ тохиолдолд хандивлагч, хандив хүлээн авагч талуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллын механизмыг онож хэрэглэх боломжгүй болж байна.

Бүлгийн дүгнэлт

Ашгийн бус хуулийн этгээдийг төрөөс дэмжих хамгийн түгээмэл, үр дүнтэй аргын нэг нь татварын таатай нөхцөл эдлүүлэх байдаг. Гэхдээ улс орнууд татварын таатай нөхцөлийг хүсэлт гаргасан ашгийн бус бүх байгууллагад хавтгайруулан эдлүүлдэггүй ажээ. Харин ашгийн бус, нийтэд тустай гэж үзсэн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд хуулиар тодорхойлсон шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд тусгай статус олгон эдлүүлдэг байна.

Монгол Улсын хувьд ТББ-ын орлогыг зарим татвараас чөлөөлж байсан ч түүнийгээ хүчингүй болгосон байдаг. Үүний шалтгаан нь тухайн ТББ нийтэд ашиг тустай үйл ажиллагааг ашгийн бус зорилгоор эрхэлж байгааг тогтоох, хянах зохицуулалт байхгүй, үзүүлж байсан татварын чөлөөлөлт нь хавтгайруулсан шинжтэй байсанд оршиж байв. Өөрөөр хэлбэл, төр эрх зүйн орчныг боловсронгуй болгох өөрийн үүргээ биелүүлэхээс төвөгшөөж, хүчингүй болгох замаар ийнхүү хялбарчлан шийдсэн нь иргэний нийгмийн суурь тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх нөхцөлийг алдагдуулжээ.

³⁸ [www.zuvluguun.edu.mn/
file/2ff0eed1bb0f27aef7f994febe74982.pdf](http://www.zuvluguun.edu.mn/file/2ff0eed1bb0f27aef7f994febe74982.pdf)
2018.03.17-нд хандав.

Ашгийн бус хуулийн этгээдийг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, хасалт хийх зэрэг аргаар нэг талдаа ашгийн бус байгууллага, нөгөө талдаа түүний хандивлагчдыг татварын бодлогоор дэмждэг байна. Ингэснээр нийтэд тустай үйл ажиллагаанд олон нийтээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үзүүлсэн дэмжлэгтээ татварын хасалт, хөнгөлөлт эдлэхийн хамт үнэхээр нийтийн ашиг тусын төлөө үйл ажиллагаа явуулж буй эсэхийг нь сонголтоороо дамжуулан хянах үр нөлөөтэй механизм бүрдэх болно.

Монгол Улсын хувьд ААНОАТХ-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгуулсан ТББ-д хандив

өгсөн тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой, харин НӨАТХ-д зааснаар боловсрол, эрүүл мэнд, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд татвараас чөлөөлөгддөг. Мөн боловсролын сургалтын байгууллага нь ашгийн төлөө байсан ч улсын төсвөөс санхүүжилт авдаг, ашгийн төлөө эмнэлгүүд ЭМД-ын сангаас санхүүжилт авдаг зэрэг нь зөвхөн ашгийн бус хуулийн этгээдэд хамаарах зохицуулалтыг ашгийн төлөө бизнест хамааруулж, ашгийн бус зорилгоор ажиллах чин эрмэлзэл, хүчин чармайлтыг үгүйсгэх, ач холбогдолгүй болгоход хүргэж байна.

Гуравдугаар бүлэг

АШГИЙН БУС САЛБАРЫН ХЯНАЛТ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

3.1. Ашгийн бус хуулийн этгээдийн тайлагнах үүрэг

Ашгийн бус хуулийн этгээдэд татварын таатай нөхцөл эдлүүлэх шийдвэр нь олон нийтээс хөрөнгө санхүүгийн хандив тусламж үзүүлэх итгэлийг бүрдүүлдэг. Ийнхүү нийтэд ашиг тустай үйлсэд зориулан итгэж шилжүүлсэн мөнгө хөрөнгийг завшиж шамшигдуулах, эрх мэдлээ хэтрүүлэн зориулалтын бусаар зарцуулах, бусдын эрх ашгийг зөрчиж, хохирооход ашиглахаас сэргийлэх, хамгаалах зорилгоор ашгийн бус байгууллагаас тайлан авч, хяналт тавих шаардлага зайлшгүй үүсдэг байна.³⁹

Ашгийн бус хуулийн этгээд нь зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаагаа нотолсон тайланг дараах зорилгоор гаргаж, ил тод байлгавал зохилтой. Үүнд:

- ▶ Төрийн зохих байгууллагад тайлагнах
- ▶ Татварын байгууллагад тайлагнах
- ▶ Олон нийтэд тайлагнах
- ▶ Хандивлагч, ивээн тэтгэгчид тайлагнах байдлаар хяналт хэрэгжүүлэх боломжит нөхцөлийг бий болгодог.

³⁹ Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В.Саймон (2004 он) "Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж" ННФ, 53 дахь тал.

Ашгийн төлөө бус үйл ажиллагааг нь дэмжсэн олон нийтээс хөрөнгө хандив хуримтлуулдаг, төрөөс санхүүгийн дэмжлэг, татаас авдаг, татварын таатай нөхцөл эдэлдэг байгууллагын хувьд орлогоо үйл ажиллагааны зорилгодоо нийцүүлэн зарцуулж байна уу, эсвэл хэн нэгэн этгээдэд ногдол ашиг хуваарилж, хөрөнгө мөнгийг зориулалтын бусаар зарж, ашгийн төлөө бус байгууллагын статусыг ашиглан мөнгө угаах зэрэг гэмт үйлдлийн халхавч болгож байна уу гэдгийг хянаж, буруу үйлдлээс сэргийлэх зайлшгүй шаардлага үүсдэг. Иймээс ашгийн бус байгууллагын нийтэд тустай үйл ажиллагаа явуулах, татварын таатай нөхцөл эдлүүлэх зэрэгт өндөр шалгуур тавьж, түүнийгээ сайтар хянах нь чухал юм.

Монгол Улсад ашгийн бус хуулийн этгээд нь ашгийн төлөө бус зорилгынхоо хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавих, үнэлэх, хариуцлага тооцох нэгдсэн тогтолцоо байхгүй байна. ТББТХ-ийн 23 дугаар зүйлд заасны дагуу дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд

жилийн тайлан тэнцлийг гаргаж өгөх үүрэг хүлээдэг. Энэ тайланд орлого нь хууль ёсны эх үүсвэртэй, зарцуулалт нь ашгийн төлөө бус зорилгын дагуу байгаа эсэхийг харах байтугай, тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд мэдүүлэх нь туйлын хангалтгүй (Татварын албанд 2017 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 17,647 төрийн бус байгууллага бүртгэлтэй байсан атал 2016 онд зөвхөн 8,140 төрийн бус байгууллага цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо мэдүүлсэн татварын тайлан ирүүлсэн гэж Татварын ерөнхий газраас мэдээлжээ. Энэхүү мэдээллийн эх хувийг Хавсралт 4-өөс үзнэ үү) байгааг эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдээ харуулж байна.

Мөн ТББ нь дээрх хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй. Үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

- ▶ Төрийн бус байгууллагын хаяг
- ▶ Үйл ажиллагааны тухай товч мэдээлэл

- ▶ Жилийн орлого, зарлагыг дор дурдсан ангиллаар задалж мэдээлэх:
 - Хандивын
 - Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны
 - Өвлүүлсэн эд хөрөнгө.
- ▶ 700,000-аас дээш төгрөгийн хандив буюу өвийн хөрөнгө өгсөн байгууллага, иргэний нэр, эд зүйлсийн жагсаалт;
- ▶ Удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын нэр, хаяг.

Гэтэл энэхүү зохицуулалт амьдралд хангалттай хэрэгжихгүй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дунджаар татварын байгууллагад бүртгэлтэй нийт ТББ-ын 50 хүрэхгүй хувь нь тайлан ирүүлсэн бол ОӨУБЕГ-т бүртгэлтэй ТББ-уудын дөнгөж 60 гаруй хувь нь үйл ажиллагааны тайлангаа ирүүлсэн нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Ийнхүү тайлангаа ирүүлсэн цөөн тооны байгууллагын тайлан нь ч хуулиар шаардсан мэдээллийг бүрэн тусгаагүй байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 7. ТББ-ын тайлангийн мэдээ

Татварын тайлан ирүүлсэн ТББ-ын тоо			Улсын бүртгэлийн газарт үйл ажиллагааны тайлан ирүүлсэн ТББ-ын тоо
2014 он	2015 он	2016 он	Сүүлийн 3 жилд жил бүр дунджаар нийт бүртгэлтэй ТББ-ын зөвхөн 60 орчим хувь нь тайлан ирүүлсэн ⁴⁰
6437	7875	8140	

⁴⁰ ХЗҮХ-ийн ХЗСТ (2013 он). “Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” судалгаа, 16 дахь тал: 2011 оны байдлаар 6002 ТББ бүртгэгдсэн. Гэтэл Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2009 онд 185, 2010 онд 112 ТББ үйл ажиллагааны тайлан ирүүлсэн мэдээ байдаг.

Ашгийн бус байгууллага бүртгэлийн байгууллагад үйл ажиллагааныхаа тайланг гаргаж өгөх үүрэгтэй боловч энэхүү тайланд хэрхэн хяналт тавих асуудал нь ТББтХ болон бусад хуульд тодорхой тусаагүй байна. Мөн ТББтХ-ийн дагуу хүлээн авч буй тайлангийн агуулга хэт ерөнхий буюу ашгийн төлөө бус зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан, ашиг хуваарилаагүй (ТББтХ-ийн 20.1, 20.2, 20.3), ил тод нээлттэйгээр ажилласан (ТББтХ-ийн 5.5) эсэхийг хянаж тогтооход шаардлагатай мэдээллийг агуулдаггүй байна.

Дан ганц ТББтХ-иар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүй (энэ судалгааны 1.1 дэх хэсэгт тайлбарласан), түүнчлэн төрөөс санхүүжилт, хөрөнгө оруулалт авч, тодорхой хэмжээнд татварын хөнгөлөлт эдэлдэг боловсрол, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд үнэхээр ашгийн бус үйл ажиллагаа явуулж буй эсэхийг нотлон харуулсан тайланг гаргуулан авч, хяналт тавих зохицуулалт одоогоор байхгүй байна. Ийнхүү хүлээн авсан тайлангаа хянах зохицуулалтгүй атлаа бүх ТББ-д тайлагнах үүргийг хавтгайруулан ногдуулсан нь ач холбогдол багатай байгаа юм. Учир нь дөнгөж байгуулагдсан, орон тооны

ажилтан байхгүй, ашгийн бус үйл ажиллагаа явуулж эхлээгүй, орлого зарлага хийгээгүй буюу “Х-тайлан” гаргасан байгууллагууд, тэрчлэн төрөөс санхүүгийн дэмжлэг, туслалцаа аваагүй, татварын таатай нөхцөл эдэлдэггүй

Дан ганц ТББтХ-иар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүй (энэ судалгааны 1.1 дэх хэсэгт тайлбарласан), түүнчлэн төрөөс санхүүжилт, хөрөнгө оруулалт авч, тодорхой хэмжээнд татварын хөнгөлөлт эдэлдэг боловсрол, эрүүл мэндийн зэрэг байгууллагууд үнэхээр ашгийн бус үйл ажиллагаа явуулж буй эсэхийг нотлон харуулсан тайланг гаргуулан авч, хяналт тавих зохицуулалт одоогоор байхгүй байна.

байгууллагуудаас үйл ажиллагааны тайлан шаардахын учир холбогдол нь ойлгомжгүй байна.

ТББ-ын тайланг хянах чиглэлд 2000 онд Хууль зүйн яам, холбогдох дүүргийн татварын албатай хамтран дотоодын ТББ, олон улсын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрын зорилго, үйл ажиллагааны чиглэл, жилийн орлого, зарлага, дүрмийн зорилго хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаа, татвар төлөлтийн байдлыг санхүүгийн баримтад тулгуурлан шалгаж дүгнэлт гаргах, шалгалт хийх ажлыг хэсэг байгуулан тодорхой удирдамжийн дагуу ажиллуулжээ. Энэ хүрээнд ТББтХ-ийн дагуу хяналт тавьж,

хариуцлага хүлээлгэж байсан ч энэ ажилд баримталсан журмыг хүчингүй болгосноос хойш ийм төрлийн хяналт өнөөг хүртэл дахин хийгдээгүй байна.⁴¹

2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д дараах үйлдлийг Төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийн зөрчил гэж тооцохоор тогтоожээ. Үүнд:

- ▶ Ногдол ашиг хуваарилах
- ▶ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлсөн
- ▶ Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнаас тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн, эсхүл аж ахуйн үйл ажиллагаа явуулсан
- ▶ Хуульд заасан хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй⁴² үйлдлийг зөрчилд тооцохоор болсон байдаг.

Хуулийн зохицуулалтад амьдралд нийцэх, хэрэгжих боломжтой байх гэсэн үндсэн шалгуур тавигддаг. Ашгийн бус салбарын зохицуулалт ийнхүү тодорхойгүй байгаа, мөн ТББ-ын зохицуулалт ч хангалттай бус, тайланг ямар зорилгоор хүлээн авч,

түүний дагуу төрийн байгууллагаас ямар ажиллагаа хийх нь тодорхойгүй нөхцөлд Зөрчлийн тухай хуулийн дээрх зохицуулалтын дагуу тайлан ирүүлээгүй гэх үндэслэлээр хариуцлага хүлээлгэх нь хэр зохимжтой вэ? гэдэгт анхаарал хандуулах шаардлагатай. Ашгийн бус салбарын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож, ялангуяа хяналт, хариуцлагын оновчтой механизмыг бий болгосон нөхцөлд л Зөрчлийн тухай хуулийн дээрх зохицуулалтын үр нөлөө гарах болно.

Татварын байгууллагад тайлагнах: Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд “Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулсны татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна” хэмээн тодорхойлсон. Аливаа үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд татвар төлөгч болох тул татварын байгууллагад бүртгүүлэн, улирал, жилээр татварын болон санхүүгийн тайлан мэдээг хүргүүлэх үүрэгтэй.

Энэхүү судалгаанд оролцсон ашгийн бус байгууллагуудын хувьд татварын байгууллагын зүгээс бүрэн хяналт тавьж чадахгүй байгааг хүлээн зөвшөөрч, цаашид хийгдэх татварын хууль

⁴¹ Ж.Амарсанаа (2001он). “Эвлэлдэн нэгдэх эрх: Төрийн бус байгууллагын стандарт” гарын авлага. УБ хот, 68 дахь тал.

⁴² Зөрчлийн тухай хууль: 11.7-ийн 1-3 дахь заалт

тогтоомжийн шинэчлэлд ашгийн бус хуулийн этгээдийн татвар, санхүүгийн хяналтыг сайжруулах чиглэлд анхаарах шаардлагатай хэмээн үзэж буйгаа илэрхийлжээ. Ашгийн бус хуулийн этгээдийн орлогын эх үүсвэр хуулиар зөвшөөрөгдсөн бөгөөд ашгийн төлөө бус зорилгод зарцуулагдсан эсэхийг тогтоох нөхцөлийг хангасан тайлан мэдээг Татварын байгууллага авч, үнэлгээ шинжилгээ хийх шаардлагатай. Татварын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хариуцлага хэрхэн ногдуулахыг тусгасан зохицуулалт нэн шаардлагатай байна.

Хандивлагчдад тайлагнах: Ашгийн бус байгууллагад хандивлагч нь хандив хүлээн авагч ашгийн бус статусыг эдлэх шаардлагыг хангасан эсэх, мөн хандив, тусламжийг хэний шийдвэрээр хэрхэн зарцуулдаг талаар дүгнэлт хийхэд шаардлагатай мэдээллийг нээлттэй байлгахыг шаардах, энэ мэдээлэлд түшиглэн хандивыг зарцуулах зориулалт, нөхцөлийг тусгасан гэрээ байгуулах эрхтэй байх ёстой. Үүнд хамаарах зохицуулалтыг ТББТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Төрийн бус байгууллагад өгсөн хандивыг хэрхэн зарцуулсан тухай хандивлагчдад тайлагнах эсэхээ тэдгээртэй байгуулсан гэрээнд тусгана” хэмээн заасан байдаг. Кейс судалгаанд хамрагдсан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ, эмнэлэг, боловсрол, соёлын байгууллагуудын хувьд тодорхой

хэмжээнд хандив, тусламж авдаг ч үүний зарцуулалтыг хандивлагчдад эргэн тайлагнах тогтолцоо байдаггүй гэсэн байна. Гэхдээ цөөн тооны зарим ашгийн бус байгууллага орлого, зардлаа хандивлагчдадаа сайн дураар тайлагнаж, олон нийтэд мэдээлж хэвшсэн байна.

Дээрхээс харахад ТББ-аас бусад төрлийн ашгийн бус хуулийн этгээдийн хувьд хандивлагчид тайлагнах, гэрээ байгуулахтай холбоотой эрх зүйн ямар ч зохицуулалт байхгүй. Ялангуяа хандив, тусламж хамгийн их авдаг байх магадлалтай “шашны байгууллага”-ууд энэ талаар маш хаалттай байна.

Олон нийтэд үйл ажиллагаагаа тайлагнах: Олон нийтээс ихээхэн хэмжээний хөрөнгө хуримтлуулсан, төрөөс санхүүгийн дэмжлэг, татварын таатай нөхцөл эдэлж буй ашгийн бус хуулийн этгээдийн хувьд өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа хэвлэн нийтлэх замаар нийтэд нээлттэй байлгах үүрэгтэй байх ёстой. Гэхдээ энэхүү тайлан нь тайлан хүлээн авах үүрэг бүхий төрийн байгууллага, ялангуяа татварын байгууллагад өгдөг хувилбараас арай товч, ерөнхий байж болох юм. Ийнхүү өөрийн санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгаснаар итгэл төрүүлж, дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлдэг. Ашгийн бус байгууллагад олон нийтэд тайлагнах, мэдээллээ ил тод байлгах үүрэг оногдуулсан зохицуулалт Монгол

Улсын хууль тогтоомжид байхгүй байна. Байгууллагууд сайн дураар мэдээллээ ил тод болгох боломжтой ч, тийм туршлага маш ховор, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг ихэнх байгууллагууд олон нийтэд зориулан тайлан мэдээ гаргадаггүй байна. Хамгийн олон жилийн түүхтэй МУЗН, МҮЭ зэрэг байгууллагууд ч өөрийн орлого, зарцуулалтын мэдээллийг нийтэд хүртээмжтэй байдлаар түгээхгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тэдэнтэй адил урт түүхтэй, өргөн хүрээний гишүүнчлэлтэй, байгууллагын нэг болох Монголын Залуучуудын Холбоо (МЗХ) нь Үндсэн дүрэмдээ:

31.8. МЗХ-ны санхүүгийн тайлан, шагнал, хандив, дэмжлэг тусалцаа түүнтэй холбоотой мэдээлэл ил тод байна.

31.9. МЗХ, салбар холбоо, хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд санхүүгийн аудитыг гишүүн дэмжигчийн саналаар оруулж болно.

31.10. Төрөөс болон төсвийн санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд шилэн дансны тухай хуулийг мөрдөнө.

хэмээн заасан ч энэ байгууллагын санхүүгийн тайлан нь нийтэд ил тод бус бөгөөд гишүүд дэмжигчдийн саналаар санхүүгийн аудит хийлгэсэн тухай мэдээлэл алга. Түүнчлэн МЗХ-ны цахим хуудас дахь Шилэн дансны мэдээлэл түгээх хуудас нь ажиллахгүй байв.

Ийнхүү ашгийн бус хуулийн этгээдийг хянах, тайлагнахтай холбоотой

нэгдсэн тогтолцоо байхгүйгээс 2017 онд Ази-Номхон далайн орнуудын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан илтгэлд Монгол Улсад ашгийн бус хуулийн этгээдийн нэрээр халхавчилсан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр байгааг анхааруулсан байна.⁴³ Ашгийн бус байгууллагууд нь терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахад ашиглагдаж болзошгүй эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэг хомс, энэ талаар албан ёсоор үнэлгээ хараахан хийгдээгүй байна. Ашгийн бус байгууллагуудыг учирч болох эрсдэлийн талаарх мэдээллээр хангах, мэдлэг өгөх ажил хийдэггүй, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн эсрэг сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээ авахгүй байна. ТББ-ын санхүүгийн гүйлгээг зөвхөн зөвшөөрөгдсөн санхүүгийн сувгаар хийлгэх талаар зохицуулаагүй ба ТББ-ын хуулиар заасан хариуцлага ч үр нөлөөтэй биш байгаа юм. Иймд Монгол Улсад терроризмыг санхүүжүүлэх эрсдэл байгаа эсэх талаар үнэлгээ хийж, холбогдох талуудын мэдлэг ойлголтыг сайжруулах ажиллагааг яаралтай зохион байгуулж, үр дүнг үндэсний хэмжээний бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай

⁴³ The Asia/Pacific Group on Money Laundering (APG) (2017). *Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia: Mutual Evaluation Report*, p. 11.

хэмээн дүгнэж,⁴⁴ шаардлагатай эрх зүйн орчин бий болгох, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгсөн байдаг.

3.1.1. Нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагааг зохицуулж буй туршлага: Япон Улс

Өмнө дурдсанчлан Япон Улсад нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг ашгийн бус хуулийн этгээд нь байгууллага, эсхүл сангийн хэлбэртэй байх бөгөөд энэ статуст харгалзах шаардлагыг хангаж байгаа нөхцөлд магадлан итгэмжлүүлэх боломжтой. Гуравдагч этгээд болох өндөр мэдлэг бүхий иргэдээс бүрдэх хороо тухайн хуулийн этгээдийн гол үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхолд чиглэсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гаргасны дараа холбогдох захиргааны байгууллагаас (засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага) нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд болохыг нотолсон магадлан итгэмжлэл олгодог.

Магадлан итгэмжлэлийг ихэвчлэн тухайн мужийн өөрөө удирдах байгууллагаас олгодог. Харин хэд хэдэн мужид салбартай, нийтэд тустай үйл ажиллагааг хэд хэдэн мужид хэрэгжүүлдэг, эсхүл улсаас хэрэгжүүлдэг нийтэд тустай ажил, үүрэгтэй нягт уялдаа холбоотой үйл ажиллагаа

явуулдаг байгууллагыг Ерөнхий сайд магадлан итгэмжлэх зохицуулалттай.

Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шалгуур нь:

- ▶ Үйл ажиллагааны 50-иас илүү хувь нь нийтийн ашиг сонирхлын төлөө байх (Зарлагын 50-иас илүү хувь нь нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаанд зарцуулагдсан байх);
- ▶ Үйл ажиллагаанаас олох орлого нь зохистой хэмжээнд гарах зардлаас давахгүй байх;
- ▶ Нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй үйл ажиллагаа, ашиг олох үйл ажиллагаа болон хуулийн этгээдийн төлбөр тооцоонд одоогоор зарцуулагдаагүй, цаашид мөн зарцуулагдахгүй байж болох хөрөнгийн хэмжээ нь нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хөрөнгөөс хэтрэхгүй байх;
- ▶ Нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн үйл ажиллагаа бэхэжсэн болон технологийн чадвартай байх;
- ▶ Хоорондоо хамаарал бүхий гүйцэтгэгч, хянагчийн тоо нь нийт гүйцэтгэгч, хянагчийн тооны 1/3-ээс хэтрээгүй байх. “Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон санг магадлан итгэмжлэх

⁴⁴ APG(2017). *Anti-money laundering and counter-terrorist financing measures Mongolia: Mutual Evaluation Report*.

тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 1-18 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байгууллагыг нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд хэмээн бүртгэдэг байна.

Ийнхүү магадлан итгэмжлэгдсэн байгууллага татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болно.

3.2. Ашгийн бус хуулийн этгээдийн зохион байгуулалт, дотоод хяналтын тогтолцоо

Нийтэд ашиг тустай үйл ажиллагааг ашгийн бус зорилгоор эрхлэх, түүнийг дэмжих санаачилга, хүсэл эрмэлзлийг урамшуулан хамгаалах нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн “иргэд нийтлэг эрх ашиг, зорилго, үнэт зүйлсийнхээ төлөө сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, эсвэл

Байгууллагын эрх барих дээд байгууллага, эсхүл удирдах зөвлөлийг хэрхэн бүрдүүлэх, тэр нь ямар эрх хэмжээ эдлэх, шийдвэрээ хэрхэн гаргах, гүйцэтгэх удирдлагыг хэрхэн сонгох, томилох зэргээр эрх мэдэл хуваарилах, үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах хяналт, удирдлагын механизмыг ашгийн бус статуст нь тохируулан оновчтой тодорхойлох нь чухал.

дангаараа гэр бүл, төр, зах зээлээс гадуур үйл ажиллагаа явуулдаг талбар”-ыг⁴⁵ цогцлоон байгуулж, “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм”-ийн суурийг тавих үндсэн нөхцөл болно. Гэхдээ энэхүү үйл ажиллагааг чинхүү

хүсэл эрмэлзлээр эрхэлж буй этгээдийг тодруулан дэмжин хамгаалж, харин нийтийн ашиг сонирхол нэрээр халхавчлан нийгэм, хүмүүст хор хохирол учруулахаас сэргийлэхийн тулд зохистой хяналтын тогтолцоо, оновчтой эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх шаардлагатай байдаг. Үүний тулд ашгийн бус, нийтэд тустай үйл ажиллагааг магадлан баталгаажуулах, энэ статусыг эдлэх этгээдийн эрх мэдэл, түүнд тавих хязгаарлалтыг хуульчлан тогтоодог. Байгууллагын эрх барих дээд байгууллага, эсхүл удирдах зөвлөлийг хэрхэн бүрдүүлэх, тэр нь ямар эрх

хэмжээ эдлэх, шийдвэрээ хэрхэн гаргах, гүйцэтгэх удирдлагыг хэрхэн сонгох, томилох зэргээр эрх мэдэл хуваарилах, үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах хяналт, удирдлагын механизмыг ашгийн бус статуст нь тохируулан оновчтой тодорхойлох нь чухал. Өөрөөр хэлбэл, ашгийн бус

⁴⁵ “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал” (2012 онд УИХ-д өргөн барьсан төсөл)

хуулийн этгээд өөрөө өөрийгөө хянах зохистой тогтолцоог бий болгох ёстой. Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч хяналтын чиг үүрэг бүхий функц бий болгон ажиллавал илүү үр нөлөөтэй байх боломжтой.

3.2.1 Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: ХБНГУ-ын практик

ХБНГУ-д ашгийн бус байгууллагын удирдлагын ихэнх шийдвэрийг удирдах зөвлөлөөс гаргадаг ч зарим суурь шийдвэрүүдийн тухайд бусад байгууллагаас оролцож хяналт тавьдаг. Хувьцаат компанийн хэлбэртэй ашгийн бус байгууллагын удирдлагыг хэрэгжүүлэхэд мөрдөх тусгайлсан дүрэм журам байхгүй. Иймд Германд ашгийн төлөө хуулийн этгээд, эсвэл гадаадын хандивлагч байгууллага дангаараа ашгийн бус байгууллага байгуулж ажиллах боломжтой. Ашгийн бус байгууллагад татварын хөнгөлөлт эдлүүлэхтэй холбоотой нөхцөл, хязгаарлалтыг татварын хуульд заасан байна (Татварын хуулийн 4 дүгээр хэсэг, А-С хүртэл).

Нийгэмлэгийн тухайд ХБНГУ-ын Иргэний хуулийн 55 дугаар хэсэгт дотоод удирдлагын бүтцийг заасан байна. Нийгэмлэг нь дотоод удирдлагын хоёр бүтэцтэй байх ба үүнд захирлуудын зөвлөл болон гишүүдийн ерөнхий хурал багтана. Гүйцэтгэх удирдлагын зөвлөл нь нийгэмлэгийн менежментийг хариуцаж, үйл ажиллагааны ерөнхий

бодлогыг хэрэгжүүлэхээс гадна нийгэмлэгийг төлөөлж ажиллана. Мөн бүх гишүүдийн хурлыг хууль болон нийгэмлэгийн дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулна. Бүх гишүүдийн хурлаар гүйцэтгэх зөвлөлийн (удирдах зөвлөл) гишүүдийг томилох, чөлөөлөх, нийгэмлэгийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, нийгэмлэгийг татан буулгах, өөрчлөн байгуулах, нэгтгэх, хуваах зэрэг үндсэн асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.2. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: АНУ-ын практик

АНУ-д ашгийн бус байгууллагын удирдлагыг хэрэгжүүлэх этгээд нь Удирдах зөвлөл, түүний дэргэд ажиллах баг болон Гүйцэтгэх захирал байх ба байгууллагын бодлого, баримтлах дүрэм, журам, үндсэн зарчмыг тогтоож, хэрэгжүүлнэ. Удирдах зөвлөлийн гишүүд цалин хөлс авахгүйгээр сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд ашгийн бус байгууллагад санхүүжилт, хандив тусламж олох ажилд гол анхаарлаа хандуулна. Удирдах зөвлөл нь хөндлөнгийн аудитын байгууллагатай заавал хамтарч ажиллах ба хөндлөнгийн аудитын байгууллагыг жил бүр сольж ажиллах үүрэгтэй.

Гүйцэтгэх захирал нь ашгийн бус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг хүлээнэ. Удирдах зөвлөлийн гишүүн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг давхар хашиж

байгаа бол Гүйцэтгэх захирлын эрхлэх ажилтай холбоотой асуудалд саналын эрх эдлэхгүй.

Төрийн эрх бүхий байгууллагаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагын хувьд төрийн эрх, ашиг сонирхлыг төлөөлсөн нэг этгээдийг удирдлагын түвшинд заавал томилоно. Ашгийн бус байгууллагын удирдах албан тушаалтан нь тухайн байгууллагын ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж гарах үр дагаврыг бүрэн хариуцдаг. Ашгийн бус байгууллагын удирдлагыг хэрэгжүүлж буй аливаа этгээд нь дараах 3 үндсэн хууль зүйн үүргийг чанд биелүүлж ажиллана.

1. **Duty of care** –Байгууллагын эрх, ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахад судалгаатай хандаж үндэслэл бүхий шийдвэр гаргах, удирдлагын түвшний хуралд идэвх санаачилгатай оролцож, байгууллагын үйл ажиллагааг ямагт дэмжин шударгаар ажиллах.
2. **Duty of loyalty** - Хараат бус ажиллах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, эрх олгогдоогүй асуудлаар байгууллагыг төлөөлөхөөс татгалзах.
3. **Duty of obedience** – Холбогдох хууль тогтоомжид тухайн байгууллагын үйл ажиллагааг нийцүүлэн явуулах, хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх, зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулах.

Удирдах зөвлөл нь ашгийн бус байгууллагын дараах журмыг баталж, удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлнэ.

1. **Сонирхлын зөрчлийг тодорхойлсон журам** – удирдах албан тушаал бүхий этгээд тухайн ашгийн бус байгууллагатай хувийн ашиг сонирхлоор харилцах хэр хэмжээг тогтоосон байна.
2. **Баримт бичиг хөтлөх журам** (Ялангуяа эмнэлгийн байгууллагад зайлшгүй байх шаардлагатай гэж үздэг) – Энэ нь байгууллагын дүрэм, журам, удирдлагын шийдвэр, аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, татварын тайлан зэрэг шаардлагатай баримт бичиг хөтлөхөд баримтлах шаардлагыг тусгасан байна.
3. **Шүгэл үлээх журам** - Аль нэг ажилтан түүнд шударга бус хандсан тухай гомдол гаргах эрх, түүнийг шийдвэрлэх журмыг заасан байна.
4. **Бэлэг хүлээн авах журам** – Ямарваа бэлгийг байгууллагын үйл ажиллагаа ялангуяа санхүүгийн тайлан бүртгэлд оруулах шаардлагатай тул бэлэг хүлээн авахад баримтлах журмыг тогтоосон байна.
5. **Хөрөнгө оруулалтын бодлого** – Ашгийн бус байгууллагад санхүүгийн хэрэгсэл ашиглан хөрөнгө татан төвлөрүүлэх бодлогыг тодорхойлно.

Удирдах зөвлөл нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

1. Байгууллагын зорилго, алсын хараа, үнэт зүйлийг тодорхойлох;

2. Гүйцэтгэх захирлыг сонгох, томилох;
3. Гүйцэтгэх захирлын ажлыг үнэлж, дэмжлэг үзүүлэх;
4. Байгууллагын үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөөг хэлэлцэн батлах;
5. Байгууллагын зорилго, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэж дүгнэх;
6. Санхүү болон санхүүгийн эх үүсвэр олох хөтөлбөрийг батлах;
7. Байгууллагыг үр нөлөөтэй удирдлагаар хангах;
8. Байгууллагын нэр хүндийг хамгаалж, олон нийтэд эерэг төсөөлөл бий болгох;
9. Байгууллагын нэгдмэл байдлыг хадгалах;
10. Удирдах зөвлөл үр дүнтэй ажиллах боломжоор хангах.

Удирдах зөвлөл нь дараах эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ:

1. Санхүү болон байгууллагын бусад эд хөрөнгийг захиран зарцуулах бодлогыг боловсруулж батлах;
2. Байгууллагын зорилго, алсын хараа, үнэт зүйлд нийцүүлэн төсөв хуримтлуулах, хуваарилах, стратеги төлөвлөгөө боловсруулах;
3. Төсөв болон бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, сайн дурын болон бусад ажилчдын эрхлэх ажлын хүрээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх;
4. Байгууллагын санхүүгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хяналт хэрэгжүүлэх, санхүүгийн зорилго,

төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5. Хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэх.

Удирдах зөвлөл нь удирдлагын түвшинд тодорхой чиг үүрэг бүхий дор дурдсан хороодыг ажиллуулж болдог:

1. **Удирдлагын хороо** – Удирдах зөвлөлийн дарга болон уг хорооны гишүүнээр сонгогдсон этгээдээс бүрдэх ба нэн яаралтай асуудлаар шийдвэр гаргах чиг үүрэгтэй.
2. **Нэр дэвшүүлэх хороо** – Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, тэдгээрийг шалгаруулах, Удирдах зөвлөлийн өөрөө өөрийгөө үнэлэх, сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй.
3. **Санхүүжилт болон Дэмжлэг үзүүлэх хороо** – Байгууллагын санхүүгийн эх үүсвэр бий болгох ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй.
4. **Санхүүгийн хороо** – Санхүүгийн бодлогыг тодорхойлох, санхүүжилтийн эх сурвалжийг ашиглах, төсөв хуваарилах, зарцуулалтыг хянах чиг үүрэгтэй.
5. **Боловсон хүчний хороо** – Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.
6. **Үйл ажиллагааны хөтөлбөрийн хороо** – Байгууллагаас иргэд, олон нийтэд хүргэж буй үйлчилгээний чанарт хяналт тавьж, улам боловсронгуй болгох чиг үүрэгтэй.

Удирдах зөвлөл нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран аль тохирох чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллуулах нь ашгийн бус байгууллагын засаглал үр нөлөөтэй байх нөхцөл болно.

3.2.3. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: Япон Улсын практик

Ашгийн бус байгууллага болон санг санхүүжилтийн хэмжээнээс нь хамааран ердийн болон том гэж ангилдаг. Тухайн жилийн эргэлтийн хөрөнгө 200 сая иенээс дээш бол том байгууллага, санд тооцогдоно. Байгууллага, сан нь дараах удирдлагын бүтэцтэй байна.

Ашгийн бус байгууллага нь гүйцэтгэгч нарын зөвлөл, хянагч, аудитортай байхыг хуулиар зайлшгүй үүрэг болгоогүй ч гүйцэтгэгч нарын зөвлөлтэй (гүйцэтгэх удирдлагыг

багаар хэрэгжүүлэх), эсвэл аудитортай бол хянагчтай байх ёстой. Мөн томоохон байгууллагын хувьд зайлшгүй аудитортай байх ёстой. Сангийн хувьд аудитортай байхыг үүрэг болгоогүй ч томоохон сангийн хувьд зайлшгүй аудитортай байх шаардлагатай.

Сургуулийн хуулийн этгээд: Цэцэрлэг, бага, дунд, ахлах зэрэг ерөнхий боловсрол олгох сургууль байгуулах зөвшөөрлийг орон нутгийн засаг даргаас авна. Их сургууль, мэргэжлийн сургууль байгуулахад Боловсрол, шинжлэх ухааны сайд зөвшөөрөл олгоно. Сургуулийн хуулийн этгээдийг сан хэлбэрээр байгуулдаг. Сургуулийн хуулийн этгээдийн бүтэц буюу Гүйцэтгэгч нарын зөвлөл нь Гүйцэтгэгч, Хянагч, Зөвлөх хорооноос бүрдэнэ. Гүйцэтгэгч нарын зөвлөл нь шийдвэр гаргах дээд байгууллага бөгөөд гүйцэтгэгчийн

Хүснэгт 8. Япон Улсын ашгийн бус байгууллагын удирдлагын бүтэц

№	Байгууллага	Сан
1	Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч (хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй)	Зөвлөлийн гишүүн + Зөвлөл (3-аас дээш гишүүнтэй) + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч
2	Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Хянагч (Хуулийн этгээдийн хөрөнгө болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина.)	Зөвлөлийн гишүүн + Зөвлөл + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч + Аудитор
3	Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Хянагч + Аудитор	
4	Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч	
5	Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч + Аудитор	

үйл ажиллагаанд хяналт тавих ба таваас дээш хүний бүрэлдэхүүнтэй байна. Хянагчийг гүйцэтгэгч нарын зөвлөлийн дарга томилох бөгөөд хоёроос дээш хүний бүрэлдэхүүнтэй байх ба хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд хяналт тавина. Зөвлөх хороо нь гүйцэтгэгч нарын тооноос хоёр дахин олон хүний бүрэлдэхүүнтэй байна. Гүйцэтгэгч нарын зөвлөлийн дарга нь төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг гишүүдтэйгээ урьдчилан зөвлөлдөнө.

Ашгийн төлөөх үйл ажиллагаанаас олсон орлогоос бусад зүйлд татвар ногдуулахгүй. Үүнд үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын татвар гэх мэт хамаардаг. Татвар оногдуулахдаа 23.9 хувиас бага буюу 19 хувиар ногдуулдаг.

Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд: Ийм төрлийн хуулийн этгээд нь үйлчилгээний байгууллага болон сангийн хэлбэрээр байгуулагдаж болно. Гэхдээ эдгээр хуулийн этгээдийн 99.1 хувь нь үйлчилгээ эрхлэх байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Үйлчилгээний байгууллагын хэлбэрийн хуулийн этгээдийг хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхтэй болон эрхгүй гэж хоёр ангилна. Гэвч 2007 оноос хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхтэй эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн тогтолцоог халснаар зөвхөн хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхгүй

хуулийн этгээд байгуулах боломжтой болжээ. Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд удирдлагын дараах бүтэцтэй байдаг:

Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэх зөвлөл + Гүйцэтгэх зөвлөлийн дарга + Гүйцэтгэгч + Хянагч

Гүйцэтгэгчид гурваас дээш тооны этгээд багтах ба хянагч нь нэгээс илүү байхыг шаарддаг байна. Хөрөнгө оруулагч нь заавал гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байх, эсвэл гишүүн нь заавал хөрөнгө оруулагч байх шаардлага тавьдаггүй.

Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд бүр татварын хөнгөлөлт эдэлдэггүй. Харин Татварын тусгай зохицуулалтын тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан “Тусгай эмчилгээ эрхлэх хуулийн этгээд” ангилалд хамаарч байвал татварын хөнгөлөлт эдлэх боломжтой байдаг. Гол шалгуур нь хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхгүй эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд, мөн сангийн хэлбэрээр байгуулагдсан эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд байх шаардлагатай.

Захиргааны хуулийн этгээд болох улсын эмнэлэг, сургууль: Захиргааны бие даасан хуулийн этгээдийн тогтолцоо нь яам, засгийн газрын захиргааны чиг үүрэг, үйл ажиллагааны тодорхой хэсгийг хэрэгжүүлж буй бие даасан

хуулийн этгээдээс бүрддэг. Өөрөөр хэлбэл, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, идэвхжүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, бие даасан удирдлага, ил тод байдлыг хангах зорилгоор захиргааны зарим чиг үүргийг тодорхой хуулийн этгээдэд шилжүүлэн хариуцуулах тогтолцоо юм. 1999 онд батлагдсан Захиргааны бие даасан хуулийн этгээдийн ерөнхий хуулийн⁴⁶ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Захиргааны бие даасан хуулийн этгээд” гэдэгт иргэдийн амьдрал болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зэрэг нийтийн ашиг сонирхлын үүднээс баталгаатай хэрэгжүүлэх ёстой чиг үүрэг болон үйл ажиллагаа дундаас төр заавал өөрөө хэрэгжүүлэх шаардлагагүй үйл ажиллагааг хувийн секторт хариуцуулсан тохиолдолд заавал хэрэгжинэ гэсэн баталгаагүй чиг үүрэг, эсвэл нэг этгээд ганцаараа хэрэгжүүлэх шаардлагатай чиг үүргийг үр нөлөөтэй явуулахын тулд “дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэх хуулийн этгээд (Agency Managed under the Medium-term Objectives)”, “улсын судалгаа, хөгжлийн хуулийн этгээд (National Research and Development Agency)”, “захиргааны хэрэгжүүлэгч хуулийн этгээд (Agency Engaged in Administrative Execution)”-ийн хэлбэрээр энэ хууль болон бусад хуулийн дагуу байгуулагдсан хуулийн

⁴⁶ Act on General Rules for Incorporated Administrative Agencies / <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?vm=04&re=01&id=2754/>

этгээдийг ойлгоно” гэж заасан байна. Одоогоор захиргааны бие даасан 87 хуулийн этгээд байна.

Улсын сургууль: 2003 онд батлагдсан Улсын их сургуулийн хуулийн этгээдийн хууль (National University Corporation Act)-ийн 6 дугаар зүйлд зааснаар үндэсний хэмжээний улсын их сургуулиудад автономи эрхтэй хуулийн этгээдийн статус олгосон байна. Иймээс улсын их сургуулийг захиргааны бие даасан хуулийн этгээдийн нэг төрөл гэж үздэг байна. Улсын их сургуулийн удирдах бүтэц нь:

**Сургуулийн захирал + 2 хянагч +
Гүйцэтгэгч (сургуулийн хэмжээнээс
хамаараад 2-7 хүн байна.)**

Мөн их сургуулиуд удирдлагатай холбоотой асуудлыг хэлэлцдэг удирдлагын хороо, сургалт, судалгааны асуудлыг хэлэлцдэг сургалт, судалгааны хороотой байдаг. Их сургуулийн захирлыг тухайн сургуулиас санал болгосноор Боловсрол, шинжлэх ухааны сайд томилдог. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар “Захиралд тавих шаардлагыг их сургуулийн захирлыг сонгох хурлаас тогтоох ба нэр дэвшигчдэд хүнлэг чанар, шулуун шударга зан, эрдэм судлалаараа тэргүүлсэн, их сургуулийн сургалт, судалгааны ажлыг зохистой, үр дүнтэй удирдах чадвартай байх зэрэг шаардлагыг тавьдаг” гэжээ.

Улсын эмнэлэг: 2002 онд батлагдсан Захиргааны бие даасан хуулийн этгээд улсын эмнэлгийн байгууллагын хууль (Act on the National Hospital Organization, Independent Administrative Agency)-ийн 3 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан улсын бүх эмнэлгийг захиргааны бие даасан хуулийн этгээд болгосон байна. Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний туршилт, судалгаа болон дадлагажуулах үйл ажиллагааг нэгдмэл байдлаар явуулах гол байгууллага болгох зорилгоор ийнхүү хувиргажээ. Тус хуулийн этгээдийн удирдлага дараах бүтэцтэй байна:

Захирал + 2 Хянагч + Дэд захирал + 5
хүртэлх тооны Гүйцэтгэгч

3.2.4 Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага: Монгол Улсад

Ашгийн бус хуулийн этгээдийн төрөлд хамаарах байгууллагууд: Ашгийн бус хуулийн этгээдийн дотоод харилцааг зохицуулсан хуулийн зохицуулалт маш цөөн. ТББТХ-иас бусад хуульд энэ харилцааг зохицуулсан заалт бараг байхгүй гэж хэлж болох юм. Ашгийн төлөө бус зорилготой хуулийн этгээдийн дүрэм, дотоод бүтэц, зохион байгуулалтыг ТББТХ болон ОӨУБЕГ-аас гаргасан ТББ-ын жишиг дүрэмд⁴⁷ үндэслэн тогтоож байгаа гэж үзэж болно. Учир нь тусгай

хуультай Үйлдвэрчний эвлэл, сан, хэвлэл мэдээлэл, шашны байгууллагын удирдлагын бүтэц, хэлбэр, зохион байгуулалтын талаар холбогдох хуулиудаар нарийвчлан зохицуулаагүй орхижээ.

ТББТХ-ийн дагуу тухайн байгууллага хяналт, удирдлагын тогтолцоогоо өөрийн дүрмээр тодорхойлох боломжтой ч энэ нь зөвхөн үүсгэн байгуулагчийн хүсэл зоригоос шууд хамаарах сул талтай. Хуулиар тогтоосон албан ёсоор хэрэгжүүлэх хяналт удирдлагын механизм, удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага гэж байхгүй учраас хоорондоо харилцан хамаарал бүхий этгээд удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах боломжтой. Мөн гүйцэтгэх удирдлагыг ч үүсгэн байгуулагчаас хамаарал бүхий этгээд хэрэгжүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, үүсгэн байгуулагч хараат бусаар ажиллах чадвартай хяналт, удирдлагын зохистой механизмыг бий болгох хүсэл зориг байхгүй бол хуулиар нарийвчлан зохицуулаагүй учраас үүсгэн байгуулагч нь байгууллагын бүхий л эрх мэдэлд нөлөөлж, бүрэн хянаж, эсхүл хязгаарлах боломж бий.

Холбоо (ТББ): Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэг хэлбэр нь холбоо юм. Мөн хуулийн 36 дугаар зүйлд “Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн

⁴⁷ <http://burtgel.gov.mn/service/index.php>

дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ” гэж тодорхойлоод, 36 дугаар зүйлийн 36.3-т холбооны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно хэмээн шилжүүлжээ. Гэсэн ч “холбоо”-ны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулсан хууль өнөөг хүртэл гараагүй байна. Харин холбооны харилцааг ТББТХ-иар нөхөн зохицуулж байгаа бөгөөд уг хуульд гишүүдээ үйлчилдэг ТББ-ын зохицуулалт нь холбооны шинжид тодорхой хэмжээгээр тохирдог тул ийнхүү тохируулан хэрэглэсээр иржээ.

Монголын иргэний нийгмийн байгууллагын асуудлыг судалдаг зарим судлаачийн зүгээс “мэргэжлийн холбоо”-ны чиг үүргийг дараах гурван чиглэлд хуваан авч үзсэн байдаг. Үүнд:

- ▶ Мэргэжлийн холбоо нь мэргэжлийн үйл ажиллагааны стандарт, ёс зүй, хариуцлага, хяналтын чиг үүргийг гүйцэтгэх ёстой.
- ▶ Мэргэжлийн холбоо нь зах зээл рүү хэнийг оруулах эсэхийг шийднэ. Жишээ нь, тусгай зөвшөөрөл олгох эрх, цуцлах, лиценз олгох гэх мэт. Мөн мэргэжлийн хариуцлагаа хүлээж чадахгүй, стандартаа хангаж чадахгүй бол зах зээлээс хасах, тухайн хүнийг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч гэж үзэхгүй байх эрх нь мэргэжлийн холбоонд хадгалагдана. Дээрх хоёр чиг үүрэг нь мэргэжлийн холбоодын нийгмийн

өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай холбогдоно.

- ▶ Дээрх хоёр үндсэн чиг үүргийг дагалдаад мэргэжлийн хариуцлагыг өндөр байлгах сургалтын чиг үүрэг үүсдэг. Хэрэв сургалтад хамрагдахгүй бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх үүсэхгүй⁴⁸.

Монгол Улсад холбооны чиг үүрэг, статусыг нарийвчлан тогтоож, тусгайлан тодорхойлсон эрх зүйн баримт бичиг байхгүй бөгөөд төрийн зүгээс мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, ажлын хэсэг, зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцуулах зэрэг цөөн хэдэн харилцааг тусгасан 20 гаруй хуулийн заалт, УИХ, Засгийн газрын тогтоол (Монгол Улсын хууль 11, УИХ-ын тогтоол 4, Засгийн газрын тогтоол 8) үйлчилж байна.

Харин төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагуудаар хариуцуулан гүйцэтгүүлэх чиглэлээр тодорхой алхмууд хийгджээ. Тухайлбал:

1. ХЭЗБТХ (2012)-ийн хүрээнд хуульчийн мэргэжлийн эрх олгох, хязгаарлах, цуцлах гэх мэт 12 чиг үүргийг Хуульчдын холбоо гүйцэтгэх;
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай

⁴⁸ Ж.Алтайбаатар (зөвлөх Б.Энхбайгаль, Д.Төмөрпүрэв) (2015 он). "Мэргэжлийн холбоодыг нийгмийн хөгжилд үр өгөөжтэйгөөр ашиглах нь: Эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлууд бодлогын судалгааны тайлан", 8 дахь тал.

- хууль (2001)-ийн хүрээнд нягтлан бодох бүртгэл, хяналтын зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх;
3. Аудитын тухай хууль (1997)-ийн хүрээнд мэргэшсэн нягтлан бодогч, аудиторчуудын мэргэжлийн ёс зүйг баталж, үндэсний хэмжээнд мөрдүүлэх чиг үүргийг Мэргэшсэн нягтлан бодогчдын институт хэрэгжүүлэх;
 4. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль (2012)-ийн хүрээнд татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд, татварын мэргэшсэн зөвлөхүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх ашгийг нь хамгаалах, ёс зүйн дүрэм баталж хэрэгжилтэд хяналт тавих гэх зэрэг чиг үүргийг Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг гүйцэтгэхээр тус тус заажээ.

Өнөөдрийн байдлаар “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд” (НЭЗХЭ) гэсэн статусаар⁴⁹ нэг хуулийн этгээд (Монголын Хуульчдын холбоо-МХХ) бүртгэлтэй байгаа бөгөөд хуульчид заавал гишүүнчлэлтэй, мэргэжлийн

⁴⁹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт “хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага” (цаашид “Хуульчдын холбоо” гэх) гэж хуульчдын заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг ойлгоно” хэмээн заажээ.

өөрөө удирдах ёсны байгууллага байхаар тодорхойлсон. Хуулийн үзэл баримтлал, зохицуулалтыг харвал Хуульчдын холбоо нь Иргэний хуулиар зохицуулсан “холбоо”-ны шинжийг агуулсан хуулийн этгээд байх боловч нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна. Гэхдээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар МХХ нь нийт гишүүдийн төлөөллийг оролцуулсан “Их хурал”, “Удирдах зөвлөл”, “Ажлын алба” “Хяналтын зөвлөл” ба бие даан хараат бусаар ажиллах “Мэргэжлийн хариуцлагын хороо” гэсэн бүтэцтэй байх зэрэг сайн жишиг болохуйц дэвшилттэй зохицуулалтуудыг тусгасан байна.

“Үйлдвэрчний эвлэл” гэсэн статусаар Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, түүнд харьяалах аль нэг холбоонд гишүүнээр элссэн байгууллагуудыг бүртгэдэг. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т үйлдвэрчний эвлэлүүд болон тэдгээрийн холбоод хуулийн этгээдийн эрх эдэлнэ хэмээн заасны дагуу тэдгээр нь хуулийн этгээдийн тусгай статустайгаар бүртгэгддэг байна. Гэхдээ үйлдвэрчний эвлэлүүд нь нэг талаараа Монголын хуульчдын холбооны нэгэн адил холбооны шинжийг агуулж байгаа бөгөөд энэ утгаараа ТББ гэсэн статустайгаар ч бүртгэгдэх боломжтой харагдаж байна.

Холбооны эрх зүйн байдлын зохицуулалт тодорхойгүй байгаа нөхцөлд хууль тогтоогчоос “мэргэжлийн холбоо”-нд эрх олгосон, төрийн чиг үүргийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтуудыг салбарын хуулиудад тусгах болсон нь зарим нэг сөрөг үр дагавар үүсгэж эхэлжээ. Тухайлбал, 2012 онд Уул уурхайн сайдын тушаалаар Шатахууны тусгай зөвшөөрлийн нарийвчилсан журам батлахдаа тусгай зөвшөөрөл хүсэгч нь “мэргэжлийн холбоо”-нд заавал элсэж, энэ тухай тодорхойлолт авсан байхаар зохицуулсан нь газрын тосны чиглэлийн мэргэжлийн холбоо нэртэй маш олон байгууллага байгуулагдаж, тэдгээрийн яг аль нь тухайн салбарыг төлөөлж чадах мэргэжлийн холбоо болохыг хянах боломжгүйд хүргэжээ. 2017 оны 12 дугаар сарын байдлаар ашигт малтмалын салбарын 42 мэргэжлийн холбоо (ТББ) байна гэсэн мэдээ бий. Мөн байнгын маргаантай байдаг “Бөхийн холбоо”, “Сагсан бөмбөгийн холбоо”, “Хөл бөмбөгийн холбоо”-ны маргаанууд нь холбооны эрх зүйн байдлыг хангалттай зохицуулж өгөөгүйгээс шалтгаалсан болохыг эндээс харж болно.

Сан: Иргэний хуулийн 33 дугаар зүйлд ашгийн бус зорилготой байгууллага сангийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болохоор заажээ. Иргэний хуульд “Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай

нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан, гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Сангийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг нарийвчилсан хуулиар тогтоохоор шилжүүлсэн ч мөн л өнөөг хүртэл энэ асуудлыг зохицуулсан тусгай хууль батлагдаагүй байна. Иргэний хуулийн 36, 37, 38 дугаар зүйл, ТББТХ-ийн 25 дугаар зүйл болон холбогдох бусад хэсгүүдээр сангийн эрх зүйн харилцааг зохицуулж байна.

Шашны байгууллагын тухайд Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу сүм, хийд нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөхөөр байна. Үүний дагуу шашны байгууллага нь магадгүй “сан”-гийн статус, зохицуулалтаар үйл ажиллагаа явуулах ёстой болж байна. Гэтэл Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд “Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг (цаашид энэ хуульд “сүм хийд гэх) шашны байгууллага гэнэ” гэж зохицуулсны дагуу “шашны байгууллага” гэсэн тусгай статусаар бүртгэн ТББТХ болон ТСХХТХ-ийн заалтыг зэрэгцүүлэн баримталж байна.

Сангийн эрх зүйн байдал хангалттай тодорхой бус энэ нөхцөлд тусгайлсан хууль, Засгийн газрын тогтоолоор “тусгай сан” байгуулах тохиолдол нэлээд түгээмэл ажээ. Жишээ нь, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Боловсролын зээлийн сангийн журам, Ахмадын сангийн журам, Орон нутгийн хөгжлийг дэмжих сангийн журам зэрэг хууль, журмууд хэрэгжиж байна. Энэ тохиолдолд ямар нэг сан байгуулах бүрд түүний дотоод харилцааг зохицуулсан шинэ хууль, дүрэм журам гаргахаас өөр аргагүй нөхцөлд хүрдэг байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага (ХМБ): Улсын бүртгэлд ХМБ гэсэн тусгай статустайгаар, ашгийн бус зорилготойгоор бүртгэгддэг. ХМБ нь бүтэц, зохион байгуулалтын хувьд ерөнхийдөө ТББ-тай адил. Гэхдээ Редакцын зөвлөл гэх бүтэцтэй байдаг нь ерөнхийдөө Удирдах зөвлөлтэй адилтгаж болохоор чиг үүргийг хэрэгжүүлдэг ажээ. Хэдийгээр ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг дүрмээрээ хязгаарлах боловч үүнийгээ хэрэгжүүлж буй эсэхийг хянах тодорхой механизм байхгүй байна. ХМБ-ын ихэнх харилцааг ТББтХ-иар зохицуулж байгаа ч улсын бүртгэлд ТББ-аас өөр статусаар бүртгэдэг байна.

Төрийн өмчид түшиглэсэн ашгийн бус байгууллагуудын дотоод зохион байгуулалт: Төрийн өмчид түшиглэн ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг ихэнх байгууллага “Төрийн байгууллага” гэсэн статусаар бүртгэгдсэн байдаг бөгөөд бие дааж, хараат бусаар ажиллах боломжгүй. Гүйцэтгэх удирдлага болон Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнхийг салбарын яам, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн засаг дарга томилж, чөлөөлдөг. Ингэснээр тухайн ашгийн

ХМБ-ын ихэнх харилцааг ТББтХ-иар зохицуулж байгаа ч улсын бүртгэлд ТББ-аас өөр статусаар бүртгэдэг байна.

бус байгууллагын удирдлага тогтворгүй, сонгуулийн мөчлөгөөс хамаарч солигддог, мэргэжлийн бус, улс төрийн намаас хараат байх нь түгээмэл байна.

Энэхүү судалгааны хүрээнд соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Чойжин ламын сүм музей буюу “Төрийн байгууллага”-ыг нэгэн кейс болгон судалж үзэв. Байгууллагын үйл ажиллагаа 100 хувь (жилийн 250 сая төгрөг) төсвөөс санхүүждэг, Төрийн сангаас тогтоосон төлөвлөгөөний дагуу жил бүр үйл ажиллагааны орлого бүрдүүлдэг. Сүүлийн жилүүдэд дунжаар 60 гаруй сая төгрөгийн орлого олдог болжээ. Хэдий төсвөөс санхүүждэг ч музейн үйл ажиллагаанд шаардлагатай хэмжээний санхүүжилт

өгдөггүйгээс цалин хөлс, урсгал зардалд зарцуулагдаж, музейн хосгүй үнэт үзмэрийг сэргээн засварлах, сайжруулах ажил хөрөнгө мөнгөний хомсдолоос үүдэн хийгддэггүй. Музейн барилга эртнийх бөгөөд төвийн шугам сүлжээнд холбогдоогүйгээс өвлийн улиралд үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болох тул халаалтын асуудлыг цахилгаанаар шийдвэрлэдэг. Үүнээс шалтгаалаад дулааны төлбөр төсөвлөснөөс байнга хэтэрдэг. Мөн музей Улаанбаатар хотын А зэрэглэлийн бүсэд оршдог ба хамгаалалтын бүсийн газрыг нь хотын болон дүүргийн удирдлагын шийдвэрээр бусдад ихээхэн хэмжээгээр шилжүүлсэн тохиолдлууд гарч байжээ. Ийнхүү газар олгосон шийдвэр нь хууль бус болохыг Захиргааны хэргийн шүүх 5 удаа тогтоосон ч газраа эргүүлэн авч чадаагүй байна (Энэхүү тайланг боловсруулах явцад нөхцөл байдал өөрчлөгдсөн болно). Музей орлогоо нэмэгдүүлэх боломжтой ч шийдвэр гаргах ажиллагаа маш хүндрэлтэй буюу салбарын яамнаас хамааран удааширч, гацдаг байна. Үүний шалтгааныг улс төрөөс хараат байдалтай холбон үздэг байна.

Төрийн байгууллагуудаас боловсрол, эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг тусгайлан үзэх шаардлагатай байна. Учир нь эдгээр байгууллагын үйл ажиллагаа нь нийтэд нөлөөтэй, хамрах хүрээ хамгийн өргөн, улсын төсвөөс авч буй санхүүжилтийн

хувийн жин өндөр юм.

Эмнэлэг: Эрүүл мэндийн тухай хуулиар төрийн, хувийн, холимог өмчид түшиглэсэн эрүүл мэндийн байгууллага байхаар зохицуулсан. Төрийн болон орон нутгийн өмчит эмнэлэг нь ашгийн бус зорилготой үйл ажиллагаа явуулах ёстой. Харин өмчийн бусад хэлбэрт түшиглэн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хуулийн этгээд заавал ашгийн төлөө бус зорилготой байхыг хуулиар шаарддаггүй.

Төрийн өмчит эмнэлгийн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн (2016) дагуу салбарын сайдын баталсан сонгон шалгаруулалтын журмын дагуу шалгаруулж, нэг сарын дотор томилох зохицуулалттай. Гэтэл хууль батлагдаад 2 жил өнгөрсөн ч хэрэгжилгүй өнөөг хүрээд байна. Мөн Эрүүл мэндийн тухай хууль (2011)-иар эмнэлгийн удирдах зөвлөлийн эрх хэмжээг давхар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн зохицуулах харилцаа давхацсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь ихэнх санхүүжилтээ “Эрүүл мэндийн даатгал сан”-гаас авах боломжтой байдаг. Тухайлбал, Улсын нэгдүгээр эмнэлэг нийт санхүүжилтийнхээ 83

хувийг ЭМД-аас, үлдсэн 17 хувийг улсын төсвөөс авдаг, харин үйл ажиллагаанаас олсон орлогоо төрийн санд шилжүүлдэг. Эмнэлгийн өөрийн үйл ажиллагааны орлого нь улсын төсвийн санхүүжилтээс давдаг учир ЭМД-ын шилжүүлэгтэй нэгтгэх замаар эмнэлгийн үйл ажиллагааг бүрэн санхүүжүүлэх боломжтой гэж үздэг байна.

Боловсрол сургалтын байгууллага (БСБ): Боловсролын тухай хуулийн дагуу төрийн өмчид түшиглэсэн БСБ нь ашгийн бус байх бөгөөд хувийн өмчид түшиглэсэн БСБ нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байж болохоор зохицуулсан. БСБ нь дотроо сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллага гэсэн ангилалтай байхаар хуульчилсан.

Судалгааны хүрээнд хувийн өмчид түшиглэсэн ерөнхий боловсролын Шинэ Монгол сургуулийг кейс болгон судалж үзэхэд санхүүжилтийнхээ 80 хувийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлдэг бол 20 хувийг улсын төсвөөс хувьсах зардлын татаасаар тооцон авдаг ба зарим тохиолдолд 1 орчим хувийг сургууль өөрөө хандиваар бүрдүүлдэг байна.

Төрийн өмчид түшиглэсэн дээд боловсрол олгох байгууллагуудын хувьд улсын бүртгэлд “Төрийн байгууллага албан газар, улсын төсөвт үйлдвэрийн

газар” хэмээн бүртгэгдсэн байдаг. Иргэний хуульд хуулийн этгээдийг зорилгоор нь ашгийн төлөө ба ашгийн төлөө бус хэмээн ангилсан атал улсын бүртгэлд өөр өөр зорилготой этгээдийг нэг бүлэгт бүртгэж буйг эндээс харж болно.

Төрийн өмчит дээд боловсролын байгууллагын хувьд 1995 оноос Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуулиудаар удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрдмийн зөвлөлийн чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлон зохицуулж байсан боловч 1998, 2002, 2016 онд эдгээр хуульд агуулгын хувьд зарчмын ялгаатай өөрчлөлтүүд оруулсаар иржээ. Их, дээд сургуулийн Удирдах зөвлөлийн гишүүдийн 60 хүртэлх хувь болон захирлыг салбар хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилж, өөрчилж байгаа нь улс төрийн сонгуулийн үр дүнгээс хамааралтай болгож байна. Энэ нь төрийн өмчит их, дээд сургуулийн бие даасан байдал, өөрийгөө удирдах зарчим алдагдах үндсэн шалтгаан болдог. Учир нь улс төр, Засгийн газраас хэт их хамааралтай, удирдлагаа өөрөө томилох, чөлөөлөх эрхгүй байгаагаас Удирдах зөвлөл нь бодит эрх мэдэлгүй, хэлбэр төдий бүтэц болж хувирчээ. Их, дээд сургуулийн захирал сайдад ажлаа шууд тайлагнадаг болсноос гадна Засгийн газраас томилогддог улс төрчдийн төлөөлөл

давамгайлсан Удирдах зөвлөлийн⁵⁰ улмаас Засгийн газрын давхар хяналтад⁵¹ орсон байна:

“...Их сургуулиудын Удирдах зөвлөл нь ихэнх тохиолдолд зөвхөн нэр төдий (хэлбэр төдий), удирдах зөвлөлд байх ёстой эрх мэдэл, бие даасан байдал, үйл ажиллагааны залгамж чанар байхгүйгээс хараат бус байдал, эрх мэдлийн хомсдолд орсон сул институт болж хувирсан байдаг. Ингэснээр их сургуулийн захиргаа, удирдах зөвлөлийн хоорондын харилцаа үндсээрээ өөрчлөгдөж, шатлан захирах шинжээ алдаж, тохиролцооны шинж чанартай болж хувирсан гэж судлаачид дүгнэсэн байдаг. Удирдах зөвлөл нь сургуулийн жилийн тайланг хэлэлцэж, төсвийг нь батлан, сургалтын төлбөрийн хэмжээг л тогтоох үндсэн үүрэгтэй болж хувирсан. Үүнээс үндэслээд захиргаа, удирдах зөвлөлийн хооронд зөрчил үүсдэг...

...Удирдах зөвлөл Боловсролын тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагч, багш нар, төгсөгчид, оюутны төлөөллөөс бүрддэг. Үүний 51-60 хувийг үүсгэн байгуулагчийн төлөөлөл бүрдүүлэх ёстой. Боловсролын тухай хуульд үүсгэн байгуулагчийг тусгайлан тодорхойлоогүй тул төрийн өмчид тулгуурласан их дээд сургуулийн үүсгэн байгуулагчийг Засгийн газар гэж ойлгодог. Иймээс Засгийн газрыг

⁵⁰ Л.Мөнх-Эрдэнэ (2008 он) “Төрийн өмчит их сургуулийн удирдлага шинэчлэл: Олон нийтийн статус хамтын удирдлага” Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр гүйцэтгэсэн Бодлогын судалгааны тайлан

⁵¹ Мөн тэнд

төлөөлөн боловсролын асуудал эрхэлсэн сайд удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг томилдог. Улс төрийн сонголтоор томилогддог албан тушаалтнууд ихэвчлэн албан тушаалынхаа дагуу удирдах зөвлөлд орж ирдэг. Ингэснээр Засгийн газраас томилогдсон албан тушаалтнууд Удирдах зөвлөлд олонх болж, гол шийдвэрүүдийг гаргагч болдог байна” (Л.Мөнх-Эрдэнэ, 2008).

Энэхүү судалгааны хүрээнд ХААИС-ийг кейс болгон судалсан. ХААИС нь 12 бүрэлдэхүүн сургуультай, мөн үүнээс гадна лаборатори, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагуудтай. Нийт санхүүжилтийн 95 хувийг өөрийн үйл ажиллагааны орлого буюу оюутны төлбөрөөс бүрдүүлдэг бол үлдсэн 5 хувийг улсын төсвөөс авч урсгал зардлаа (цахилгаан, дулаан) санхүүжүүлдэг байна. Үл хөдлөх хөрөнгө нь улс төрчдийн шийдвэрээр бусдад шилжсэн тохиолдол олонтаа гарсан. Тухайлбал, ХААИС-ийн эзэмшлийн нэлээд газрыг Нийслэл, дүүрэг, сургуулийн удирдлага тохиролцон бусдад худалдсан, шилжүүлсэн тохиолдууд гарч байжээ. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит их, дээд сургуулийн удирдлага, зохион байгуулалт бүх түвшиндээ Засгийн газар, Боловсролын сайдаас шууд хамаарч байдаг учир хараат бусаар, бие даан ажиллах ямар ч нөхцөл бололцоо байдаггүй ажээ. Ингэснээр чадварлаг мэргэжлийн багш, судлаачдыг татах,

дэлхийн жишигт нийцсэн сургалт явуулж, оюутанд чанартай мэдлэг олгох, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар тогтвортой бодлогыг тууштай хэрэгжүүлэх боломжгүйд хүрдэг.

Ийнхүү төрийн өмчид түшиглэсэн ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаа нь дараах эрсдэлийг бий болгож байна. Үүнд:

1. Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага мэргэжлийн бус болох, байгууллагын үндсэн зорилго, ашиг сонирхлоос өөр ашиг сонирхолд хөтлөгдөх (Тухайлбал, удирдлагын хувийн ашиг сонирхол гэх мэт);
2. Байгууллагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэх чадавх, чадамж алдагдах;
3. Ашиг сонирхлын зөрчилд автах, тэгш бус өрсөлдөөн үүсгэх зэргээр салбарын хөгжлийг боомилох;
4. Төрөөс шилжүүлж авсан чиг үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй, эсвэл ашиг сонирхлын зөрчлийн улмаас нийт ард иргэдэд тэгш үйлчлэхгүй байх, улмаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар үүсгэж, хохирол учруулах;
5. Авлигын холбоо, сүлжээнд автах;
6. Улс төр, ашиг сонирхлын бүлгийн нөлөөнд автах.⁵²

⁵² Ж.Алтайбаатар (зөвлөх Б.Энхбайгаль, Д.Төмөрпүрэв) (2015 он). "Мэргэжлийн холбоодыг нийгмийн хөгжилд үр өгөөжтэйгөөр ашиглах нь: Эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлууд бодлогын судалгааны тайлан", 7 дахь тал

Түүнчлэн ашгийн бус салбарын зохицуулалт хангалтгүй байгаагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдах эрсдэл нэмэгдэж, энэ хэмжээгээр иргэний нийгэмд итгэх итгэл алдагдаж, нийтэд ашиг тустай үйл ажиллагааг үр нөлөөтэй хэрэгжүүлэх институц сулрах үр дагавартай тухай өмнө өгүүлсэн билээ.

Судалгааны хүрээнд оролцогчдоос ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн шинж, түүнийг ямар шалгуураар тодорхойлж болох талаар асуусан юм. Судалгаанд оролцогчдын хариултад хамгийн олон удаа давтагдсан зүйлсийг жагсаавал (Хариултыг бүрэн эхээр нь хавсралт 2-оос дэлгэрүүлэн харах боломжтой):

- ▶ Нийтийн эрх ашгийн төлөө ажиллах;
- ▶ Шийдвэр гаргах процесс нь ил тунгалаг байх;
- ▶ Хараат бус байдлаар бие даан ажиллах;
- ▶ Орлогын эх үүсвэр, зарцуулалт нь ил тунгалаг байх;
- ▶ Удирдах Зөвлөл болон бусад хувь хүн, хуулийн этгээдэд ашиг хуваарилахгүй байх;
- ▶ Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- ▶ Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадамжтай байх;
- ▶ Улс төрийн үйл ажиллагаа

явуулахгүй байхыг зайлшгүй биелүүлэх шаардлага болгох ёстой гэж үзсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, өмчийн хэлбэрээс үл хамааран (төрийн, хувийн, холимог өмчийн аль нь ч байж болно) ашгийн бус үйл ажиллагаа явуулах үндсэн нөхцөл нь ашгийн бус, нийтэд тустай

Бүлгийн дүгнэлт

Ашгийн бус үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь нийтэд ашиг тустай үйл хэргийнхээ төлөө дэмжлэг урамшуулал авах, эрсдэлээс хамгаалагдах нь зүй ёсны хэрэг билээ. Гэвч ийнхүү дэмжлэг туслалцаа, хамгаалалт авахын

ТББтХ, Зөрчлийн тухай хууль, бусад хуулийн зохицуулалт уялдаа холбоо муугаас гадна хуулийг хэрэгжүүлэх шатанд бүртгэл, тайлагналтын практик нь зөрчилтэй, үр дүнгүй байгаа юм.

тулд ашгийн бус үндсэн зорилгынхоо төлөө нийтэд тустай үйл ажиллагааг тууштай эрхэлж байгаа эсэхийг нь төрийн захиргааны болон татварын байгууллага, олон нийтийн зүгээс хянаж, зорилгоосоо гадуур, хувийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах зохицуулалт зайлшгүй шаардлагатай болдог.

зорилгоо хараат бусаар хэрэгжүүлж ажиллах, үр ашигтай дотоод хяналтын тогтолцоог бий болгохтой холбоотой байна. Харин манай өнөөгийн эрх зүйн орчин эдгээр нөхцөлийг бүрдүүлэх чадваргүй хэмээн дүгнэж болохоор байна.

Өнөөдөр Монгол Улсын хувьд ашгийн бус салбарын оновчтой зохицуулалт хараахан бүрдээгүй, нийтэд ашиг тустай үйл ажиллагааг тайлагнах, хянах механизм тогтоогүй, энэ чиглэлийн ажил эрхэлдэг хуулийн этгээдэд болон

тэднийг дэмжигчдэд татварын таатай нөхцөл олгох систем тогтоогүй байна. ТББтХ, Зөрчлийн тухай хууль, бусад хуулийн зохицуулалт уялдаа холбоо муугаас гадна хуулийг хэрэгжүүлэх

шатанд бүртгэл, тайлагналтын практик нь зөрчилтэй, үр дүнгүй байгаа юм. Үүний нэг жишээ нь ТББ-аас бусад ашгийн бус хуулийн этгээдэд тайлан гаргах, хариуцлага хүлээлгэх ямар нэг зохицуулалт байхгүй, мөн ТББ-д ямар ч тодорхой шалгуур тавилгүйгээр тайлан гаргах, хэрэв үгүй бол шууд торгох хариуцлага ногдуулахаар байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Монгол Улсын ашгийн бус хуулийн этгээдийн хяналт, удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтад юуны өмнө үүсгэн байгуулагчийн хүсэл зоригоос шууд хамаарах хараат байдлыг засах, өөр өөр төрлийн хуулийн этгээдийн онцлогийг тусгасан удирдлага, хяналтын уян хатан, үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлэх боломж олгох, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ил тунгалаг байдлыг хангаж олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Үүнд, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар бий болгосон нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын хуульчдын холбооны удирдлагын эрх мэдлийн хуваарилалт, тусгай хяналтын зөвлөл, гишүүдэд тайлан гаргах тогтолцооны онцлог туршлагыг харгалзан үзвэл зохино.

Төрийн өмчит байгууллагуудын хувьд дээд шатны байгууллага, салбарын сайд,

орон нутгийн засаг даргаас удирдлага нь шууд хараат байх нөхцөлд байгууллагын өөрийн удирдлагын механизм ач холбогдолгүй болж байна. Иймд эдгээр байгууллагын бие даасан байдлыг хангах бэхжүүлэх замаар үйл ажиллагааны чанар, үр ашгийг сайжруулах чиглэлээр эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Бусад улс орны туршлагаас үзэхэд ашгийн бус байгууллагад дотоод хяналтын зохион байгуулалт, удирдлагын зохистой бүтцийг бүрдүүлэх зохицуулалтыг хуулиар нарийвчлан тогтоож өгдөг байна. Иргэний нийгмийн үр нөлөөтэй тогтолцоо бүхий улс орнууд энэ талаар баялаг туршлага хуримтлуулсан нь манай орны хувьд зохистой шийдэл сонгох, зохицуулалтыг боловсронгуй болгоход ихээхэн ач холбогдолтой юм.

Дөрөвдүгээр бүлэг

ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

4.1 Ашгийн бус салбарын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгын хэрэгжих суурь нь иргэний нийгмийн институт билээ. Энэхүү иргэний нийгэм нь олон улсын хэмжээнд “ашгийн төлөө бус”, “сайн дурын”, “нийгмийн”, “буяны”, “гурав дахь хэвшил” хэмээн нэрлэдэг нийтийн ашиг тусад чиглэсэн зорилготой, ашгийн төлөө бус үйл ажиллагаа, түүнийг эрхэлдэг байгууллагын тогтолцоо юм. Харин иргэдийн нийтлэг сайн сайхан, ашиг тусын төлөө иргэдийн үүсгэл санаачилга, хүсэл зориг оролцоо, дэмжлэгтэйгээр бүрэлдэн бэхжих энэ тогтолцоонд шаардлагатай эрх зүйн зохицуулалт манай улсад хараахан бүрэн төлөвшөөгүй байна.

Манай оронд “ашгийн бус” үйл ажиллагаа, хуулийн этгээдийн тухай ойлголт төсөөлөл зөвхөн төрийн бус байгууллагын дүр төрхөөр тогтож, үүнд хамаарах харилцааг 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулж иржээ. Харин нийгмийн хөгжлийн явцад ашгийн бус үйл ажиллагаа, үүнийг эрхлэх

байгууллага буюу хуулийн этгээдийн төрөл, хэлбэр ихээхэн өргөжин тэлж төрөөс хараат бус, нийтийн эрх ашгийн төлөө бие даан ажилладаг байгууллагууд бий болжээ. Эдгээр байгууллагын зарим үйл ажиллагааг тухайлбал, ашгийн бус боловсролын сургалтын байгууллагад хамаарах зохицуулалтыг Боловсролын тухай хуульд хэсэгчилсэн байдлаар тусгасан авч бүрэн гүйцэд зохицуулалт болж чадаагүй байна. Төрийн бус байгууллагуудын тухайд ч нийтийн ашиг тусын төлөө үйлчлэх нээлттэй, эсвэл зөвхөн гишүүдийнхээ ашиг сонирхолд үйлчлэх “хаалттай” байгууллагад хамаарах зохицуулалт өөр өөр байдаг.

Ашгийн бус зорилгыг гурван төрлийн хуулийн этгээдэд хамааруулан тодорхойлсон Иргэний хуулийн зохицуулалт нь дээрх нөхцөл байдлыг тусгаагүй, агуулгын хувьд дотоод зөрчилтэй байна. Энэ зөрчил нь салбарын бусад хууль тогтоомжид нөлөөлж, бүртгэлээр болон тайлангаар хянах, үнэлэх чиг үүрэг эзэнгүйдэж, эцсийн дүндээ ашгийн төлөө бус салбарын хөгжлийг хязгаарлан үр нөлөөг бууруулах болжээ. Иргэний

нийгэм өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас үзэхэд хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг ашгийн төлөө болон ашгийн бус зорилгоор нь хашиж хайрцаглах бус, харин засаглал, удирдлага, хяналтын үр нөлөөтэй механизм бүрдүүлэх замаар дэмжиж, бас хяналт тавьдаг байна.

Улсын бүртгэлд бүртгэгдсэн ашгийн төлөө бус зорилготой 19 төрлийн хуулийн этгээдийн харилцааг цогцоор нь зохицуулсан эрх зүйн систем байхгүй, дан ганц Төрийн бус байгууллагын тухай хуулиар ашгийн төлөө бус салбарын харилцааг бүхэлд нь зохицуулах боломжгүй юм. Иргэний хуулиар тогтоосон ашгийн төлөө бус зорилготой хуулийн этгээд болох “холбоо”, “сан”-гийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоохоор шилжүүлсэн ч энэхүү дагалдах хуулийн зохицуулалт хийгдээгүй байна. Эрх зүйн орчинд гарсан энэхүү хийдлийг дан ганц Төрийн бус байгууллагын тухай хуулиар нөхөн зохицуулах боломжгүйд хүрээд байна. Үүнээс шалтгаалж ашгийн төлөө бус зорилго, шинж чанартай хуулийн этгээдийн дотоод зохицуулалтыг салбарын хуулиудад хэсэгчилсэн байдлаар зохицуулахыг оролдож ирсэн нь хэрэгжилтийн шатанд тодорхойгүй байдал, зөрчил үүсгэж байна. Улсын бүртгэл нь хуулийн этгээдийн албан ёсны статусыг

тодорхойлж, түүнтэй харилцагчдад итгэлцэл төрүүлэх мэдээллийн гол эх сурвалж байх үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. Өнөөдөр хөтөлж буй бүртгэл нь хэрэглэгчдэд ач холбогдол багатай, мэдээний хэмжээнээс хэтрэхгүй байна.

Иргэний нийгэм өндөр хөгжсөн улс орнуудын туршилагаас үзэхэд хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг ашгийн төлөө болон ашгийн бус зорилгоор нь хашиж хайрцаглах бус, харин засаглал, удирдлага, хяналтын үр нөлөөтэй механизм бүрдүүлэх замаар дэмжиж, бас хяналт тавьдаг байна.

2018 онд шинээр батлагдсан Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар бүртгэлийн харилцаанд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийг зорьсон ч салбарын бусад хуулийг шинэ хуулийн үзэл баримтлалд нийцүүлж хэрэгжих нөхцөлийг хангасан тохиолдолд л дээр дурдсан тулгамдсан асуудлууд бүрэн шийдвэрлэгдэх болно.

Ашгийн бус байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны болон орлого, зарлагын тайлагнал, ил тод байдал нь нийгэм, төр засаг, хандивлагчдын зүгээс итгэл өгч, дэмжлэг үзүүлэх хөрс болдог. Гэтэл татвар, улсын бүртгэл гэх зэрэг ашгийн бус хуулийн этгээдийн бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн байгууллагад ч энэ чухал мэдээлэл байхгүй байна.

Ашгийн бус хуулийн этгээдийн харилцаанд хамаарах хамгийн нарийвчилсан зохицуулалт бүхий хууль нь ТББТХ хэдий ч байгууллагын дотоод хяналт, удирдлагын харилцааг дүрмээр тогтоохоор шилжүүлсэн нь үүсгэн байгуулагчаас бүрэн хамааралтай болгож байна. Гэхдээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн бүтэц, дотоод хяналтын механизмыг бүрэлдүүлсэн байдал нь судалгааны явцад сонирхол татсан, дэвшилтэт зохицуулалтын нэг байлаа. Өөрөөр

Улсын төсөв, ЭМД-ын сан болон тусгай зориулалтын бусад сангаас санхүүжилт авч буй байгууллага ашгийн бус үйл ажиллагаа явуулдгийг тодорхойлох шалгуур, хяналт байхгүй байгаа зэрэг олон тулгамдсан асуудал байсаар байна. Энэ байдлыг Монгол Улсын ашгийн бус салбар “мөнгө угаах”, “авлига”, “хээл хахууль”, “терроризм”-ыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болзошгүй өндөр эрсдэлтэй болсон байна хэмээн олон улсын байгууллагаас дүгнэжээ.

хэлбэл, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монголын хуульчдын холбоог “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” хэмээх статустайгаар байгуулсан ба энэ нь мэргэжлийн хүрээнд тохируулагч агентлагийн чиг үүрэг, бүрэн эрхийг ашгийн бус байгууллага хэрэгжүүлж болохыг харуулсан жишээ юм.

Төрийн өмчид түшиглэсэн, холимог болон хувийн өмчид түшиглэсэн

зэрэг өмчийн аль ч төрлийн ашгийн төлөө бус байгууллага нь хандивлагч, үүсгэн байгуулагч, төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, бусад этгээдээс бүрэн хараат бусаар ажиллах, зөвхөн нийтэд тустай, ашгийн бус зорилгоор үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах эрх зүйн орчин манай улсад байхгүй байна. Энэ байдал нь ашгийн бус байгууллагууд олон нийт, дэмжигчдэд өөрийгөө таниулах, нийтийн ашиг тусын тулд ажиллаж буйгаа нотлох хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтыг сулруулж, үүнээс хамааран өргөн олон нийтийн дэмжлэгийг татах бус, харин тодорхой ашиг сонирхолд үйлчлэн санхүүжилт, хандив тусламж авах замаар оршин тогтноход хүргэж байна. Ийм байдлаар ажиллаж буй байгууллагыг нийтийн тусын тулд ашгийн бус зорилгоор ажиллаж байгаа хэмээн үзэх, итгэх боломжгүй билээ.

Харьцуулсан судалгаанаас харахад ашгийн бус байгууллагын өөрөө өөрийгөө хянах дотоод хяналт, удирдлагын тогтолцоог зөв бүрдүүлэх замаар тэднийг үндсэн зорилгодоо харшлах ашиг сонирхолд хөтлөгдөх, хараат бус байдлаа алдахаас сэргийлж чаддаг байна. Тэрчлэн татварын болон төрийн эрх бүхий бусад байгууллага, олон нийт, хандивлагчдад үйл ажиллагаа, орлого, зарлагаа ил тод тайлагнах замаар

тэдний итгэлийг олж авдаг харилцан хамаарал бүхий тогтолцоог бий болгох шаардлагатай байгаа юм.

Монгол Улсын хувьд ашгийн бус хуулийн этгээдэд татварын таатай нөхцөл олгох оновчтой зохицуулалт одоогоор байхгүй байна. Татварын хуулиудад төрийн өмчийн бус хуулийн этгээдийн нийтэд зориулсан ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалт тусгагдсан ч эдгээр нь зөвхөн нийтийн ашиг тусын тулд явуулж буй ашгийн бус үйл ажиллагааг дэмжих зорилготой биш юм. Түүнчлэн улсын төсөв, ЭМД-ын сан болон тусгай зориулалтын бусад сангаас санхүүжилт авч буй байгууллага ашгийн бус үйл ажиллагаа явуулдгийг тодорхойлох шалгуур, хяналт байхгүй байгаа зэрэг олон тулгамдсан асуудал байсаар байна. Энэ байдлыг Монгол Улсын ашгийн бус салбар “мөнгө угаах”, “авлига”, “хээл хахууль”,

“терроризм”-ыг санхүүжүүлэхэд ашиглагдаж болзошгүй өндөр эрсдэлтэй болсон байна хэмээн олон улсын байгууллагаас дүгнэж, ашгийн бус салбарын харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох ЗӨВЛӨМЖ өгчээ.

Нэгтгэн дүгнэвээс, өнөөдөр манай орны хувьд ашгийн бус үйл ажиллагааг тодорхойлох оновчтой шалгуур гаргаж, ашгийн бус байгууллагын үндсэн зорилго, түүнийг удирдан чиглүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, хянах эрх мэдлийг хэн хэрхэн хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь бүрхэг хэвээр байна. Түүнчлэн, ашгийн бус үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хөрөнгө санхүүжилтийг ямар эх үүсвэрээс бүрдүүлж, хэрхэн зарцуулж байгааг ил тунгалаг болгох, цаашлаад энэ салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн хууль, эрх зүй, бүртгэл, татвар, тайлагналын цогц систем хараахан бүрдээгүй байна.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Тулгамдаж буй асуудал	Зөвлөмж болгох шийдэл	Гол үр дүн
Ашгийн бус салбарын талаарх цэгцтэй төсөөлөл ойлголт дутмагаас энэ салбарт хамаарах эрх зүйн нэгдсэн зохицуулалт бүрдээгүй.	Ашгийн бус салбарт ямар үйл ажиллагааг хамааруулах, үүнийг эрхлэх болон түүнд дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлж, энэ салбарын талаар баримтлах төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчмыг тусгасан албан ёсны баримт бичгийг боловсруулан УИХ-аар батлуулах. Үүний нэг хувилбар болгон УИХ-д 2012 онд өргөн барьж байсан “Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал”-ын төслийг хянан үзэх.	Ашгийн бус салбарыг бэхжүүлэх, иргэний нийгмийн институцийг хөгжүүлэх албан ёсны бодлого тодорхой болж, үүнд нийцүүлэн эрхзүйн зохицуулалтыг нэг мөр болгох нийгмийн зөвшилцөл, нөхцөл бүрдэнэ.
Ашгийн бус хуулийн этгээдийн статус бүрхэг, үүнд хамаарах хуулийн заалт зохицуулалт дотоод зөрчилтэй, практик үр өгөөж багатай байна.	Иргэний хууль дахь зөрчлийг арилгах: Аль ч төрлийн хуулийн этгээд “ашгийн төлөө”, эсвэл “ашгийн төлөө бус” үйл ажиллагаа явуулах боломжийг нээлттэй болгож, “ашгийн төлөө бус” үйл ажиллагаанд хамаарах зохицуулалтыг тодотгох. Төрийн бус байгууллагын тухай хуулийг үзэл баримтлалын хувьд бүхэлд нь шинэчлэн найруулах: ТББ гэсэн ойлголтыг иргэний эрх зүйн онол, үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлох замаар Иргэний хуулийн зохицуулалттай нийцүүлж хуулиудын зөрчилдөөнийг арилгах Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг Иргэний хуулийн зохицуулалтад нийцүүлэх: Ашгийн бус хуулийн этгээдийн удирдлага, шийдвэр гаргах механизм, үйл ажиллагааны тайлан, мэдээний ил тод байдлыг хангуулах, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хяналтын процессыг тодорхой болгох	Хуулийн этгээдийн бүртгэлийн харилцаанд үүсээд байгаа зөрчил, тодорхойгүй, хяналтгүй байдал арилж, ашгийн төлөө бус байгууллагын хараат бус байдал хангагдах нөхцөл бүрдэнэ. Ашгийн бус хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулснаар иргэд, үнэн бодит мэдээллээр хангагдаж, ашгийн бус байгууллага хууль бус зорилгод ашиглагдах эрсдэл буурна.

Тулгамдаж буй асуудал	Зөвлөмж болгох шийдэл	Гол үр дүн
<p>Ашгийн бус хуулийн этгээд нь үүсгэн байгуулагч, санхүүжүүлэгч, улс төрийн эрх мэдэлтнээс хамааралтай байхаас гадна хэсэг бүлгийн ашиг сонирхолд хөтлөгдөх, хууль зөрчсөн зорилгод ашиглагдах эрсдэл өндөртэй байна.</p>	<p>Ашгийн бус хуулийн этгээдийн бие даасан, хараат бус байдлыг хангах засаглал, хяналтын тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой зохицуулалтыг холбогдох салбарын хууль тогтоомжид тусгах: Удирдах зөвлөл, түүний бүтцийн байгууллагыг бүрдүүлэх, гишүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр холбогдох хуулийн зохицуулалтыг шинэчилж, мэргэжлийн удирдамж, аргачлал боловсруулж хэрэгжүүлэх.</p> <p>Эхний ээлжид бүртгэлийн харилцаанд ашгийн бус хуулийн этгээдийн бүртгэлд нэгдсэн стандарт тогтоох: Цаашид ашгийн бус хуулийн этгээдтэй холбоотой үндсэн харилцааг зөвхөн Иргэний хуулиар, бүртгэлийн харилцааг Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар зохицуулах замаар салбар хуулиар хуулийн этгээдийн шинэ хэлбэр үүсгэдэг практикийг халах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Хууль тогтоогчийн зүгээс салбарын хуульд хуулийн этгээдийн хэлбэрийг тусгасан нөхцөлд Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн аль төрөл, хэлбэрт хамаарах талаар тодорхой зааж байх. – Хэрэв хуулийн этгээдийн шинэ хэлбэр үүсгэх бол зайлшгүй шаардлагатай эсэх, одоогийн хуулийн хүрээнд зохицуулах боломжтой эсэхийг урьдчилан судалж байх. Үнэхээр хуулийн этгээдийн шинэ хэлбэр үүсгэх шаардлагатай гэж үзвэл шинжлэх ухааны үндэслэлтэй, суурь судалгаанд үндэслэж бий болгох шаардлагатай байна. 	<p>Хуулийн этгээдийн удирдлага нь ашгийн бус зорилгын төлөө хараат бусаар, түүштай ажиллаж, байгууллагын бодлогыг тодорхойлох, удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага нь нэмэгдэж, хууль, ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөх эрсдэл буурна.</p>

Тулгамдаж буй асуудал	Зөвлөмж болгох шийдэл	Гол үр дүн
<p>Ашгийн бус хуулийн этгээд, түүний нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих иргэд, байгууллагын санал, санаачилгыг дэмжин урамшуулах татварын бодлого, зохицуулалт хангалтгүй, одоо мөрдөж буй төсвийн санхүүжилт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалт оновчтой биш байна.</p>	<p>Ашгийн бус байгууллагад татварын таатай нөхцөл эдлүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтэд тустай үйл ажиллагаанд зориулсан хандив тусламжийг урамшуулах чиглэлээр татварын хууль тогтоомжийг шинэчлэх: Нийтэд тустай, ашгийн бус үйл ажиллагаанд хамаарах чиглэл, шалгуурыг тодорхой болгож, татварын таатай нөхцөл эдлүүлэх нөхцөлийг тодорхойлж, шаардлага, хяналт, үнэлгээ хийх бүтэц бий болгох (“нийтэд тустай үйл ажиллагааг тодруулах тусгай тест” ашиглах гэх мэт), ашгийн бус байгууллагын санхүүгийн тайлагналтыг нийтэд ил тод болгох, сайн дурын үндсэн дээр мөнгөн болон эд хөрөнгийн хандив, дэмжлэг үзүүлэх, цагаа зориулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр нийтэд тустай үйл ажиллагаанд иргэд, байгууллагын оруулсан хувь нэмрийг үнэлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах.</p> <p>Ашгийн бус хуулийн этгээд, түүний нийтэд тустай үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих механизмыг боловсронгуй болгоход дараах алхмуудыг нэн тэргүүнд хийх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Нийтэд ашиг тустай үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох. Ингэхдээ НҮБ-ын ашгийн бус үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэх. <ul style="list-style-type: none"> ▶ Соёл боловсрол ба амралт, зугаалга ▶ Боловсрол ба судалгаа шинжилгээ ▶ Эрүүл мэнд ▶ Нийгмийн халамж ▶ Хүрээлэн буй орчин ▶ Хөгжил ба барилгажилт ▶ Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ▶ Буяны үйл ажиллагаанд зуучлах ▶ Шашны байгууллага ▶ Бизнесийн болон мэргэжлийн холбоо, үйлдвэрчний эвлэл ▶ Бусад 	<p>Ашгийн бус үйл ажиллагааг дэмжигчдийн итгэл нэмэгдэж, иргэний нийгмийн институцийн үйл ажиллагааны чанар, цар хүрээ, үр нөлөө өргөжин дээшилнэ.</p>

Тулгамдаж буй асуудал	Зөвлөмж болгох шийдэл	Гол үр дүн
	<ul style="list-style-type: none"> – Ашгийн бус хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл явцыг нарийвчлан зохицуулах: <ul style="list-style-type: none"> ▶ Ашгийн бус хуулийн этгээд нийтийн ашиг тусын төлөө үйл ажиллагаа явуулж байгааг тодорхойлох шалгуур, аргачлалыг (тусгай тест гэх мэт) нарийвчлан тогтоох ▶ Нийтэд тустай үйл ажиллагаа явуулж буйг үнэлэх, хараат бус хөндлөнгийн институт (зөвлөл, хороо гэх мэт) бий болгох ▶ Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж буй нөхцөлд үйл ажиллагааны тайланг татварын алба болон эрх бүхий бусад байгууллагад гаргаж, олон нийтэд тогтмол мэдээлж байх. 	

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Иргэний хууль 1994, 2002 он
3. Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хууль, 1991 он
4. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1995 он
5. Төрийн бус байгууллагын тухай хууль, 1997 он
6. Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоол, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”
7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2003, 2015, 2018 он
8. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль, 1994
9. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 он
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2006 он
11. Боловсролын тухай хууль 2006 он
12. Татварын ерөнхий хууль 2006 он
13. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012 он
14. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль 2016 он
15. Зөрчлийн тухай хууль 2017 он
16. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (Долдугаар бүлэг “Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал” 65¹⁻⁶ зүйл)
17. Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлалын төсөл, (2012 онд УИХ-д өргөн мэдүүлсэн)
18. Франц Улсын Иргэний хуулийн 1832-1873 дахь зүйл: Хуулийн этгээдийн эрх зүйн харилцаа.
19. МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн танхим (2017 он). ХБНГУ-ын Иргэний хууль, (Кодификацийн бүрэн эх), орчуулсан Б.Буянхишиг
20. МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн танхим (2016 он). Японы Иргэний хууль, орчуулсан Б.Урангоо

Хуулийн хэлэлцүүлэг

1. ННФ-аас зохион байгуулсан “Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт” сэдэвт хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Мөнх-Оргилын тавьсан илтгэл, 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр.
2. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2005 оны 2 дугаар сарын 7-ны өдөр http://forum.mn/pdf/public_meeting/NNF%20Uragiin%20zuvlul.pdf
3. Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийн мэдээлэл, 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр. https://www.forum.mn/p_pdf.php?obj_id=3726

Судалгааны тайлан

1. Леон Е. Айриш, Роберт Кушен, Карла В. Саймон (2004 он). “Иргэний нийгмийн байгууллагад холбогдох хууль тогтоомж” ННФ, Улаанбаатар хот
2. Ж.Алтайбаатар (зөвлөх Б.Энхбайгаль, Д.Төмөрпүрэв) (2015 он). “Мэргэжлийн холбоодыг нийгмийн хөгжилд үр өгөөжтэйгөөр ашиглах нь: Эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудлууд” бодлогын судалгаа
3. Ж.Амарсанаа (2001 он) “Эвлэлдэн нэгдэх эрх: Төрийн бус байгууллагын стандарт” гарын авлага, УБ хот
4. Ардчиллын төлөө Олон улсын иргэний нийгмийн чуулган (2005). *Монголын иргэний нийгмийн өнөөгийн байдал: Иргэний Нийгмийн Индексийг боловсруулахуй*
5. APG (2017). “Anti-money laundering and counter-terrorist financing measures” Mongolia Mutual Evaluation Report
6. Л.Мөнх-Эрдэнэ (2008 он) “Төрийн өмчит их сургуулийн удирдлага шинэчлэл: Олон нийтийн статус хамтын удирдлага” Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр гүйцэтгэсэн Бодлогын судалгааны тайлан
7. МННХ/ННФ (2003 он) “Боловсролын салбарын өөрчлөлт, хувьчлалын кейс судалгаа” https://forum.mn/res_mat/final_report.pdf 2018.03.09-нд хандав.
8. Productivity Commission (January 2010) *Contribution of the Not-for-Profit Sector, Research Report*
9. ХЗҮХ (2015 он) “Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн асуудал”
10. ХЗҮХ (2013 он) “Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” судалгаа
11. ХЗҮХ (2013 он) “Нийтэд тустай үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт”
12. ХЗҮХ (2013) “Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нь”
13. ХЗҮХ (2011 он) “Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөлтэй холбоотой судалгаа”
14. Удирдлага, Эдийн Засгийн Сургалт, Эрдэм Шинжилгээний Байгууллагуудын Консорциум (2004 он) ННФ-ын санхүүжилтээр гүйцэтгэсэн “Нийгмийн салбарын хувьчлал: Соёл, урлагийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалын кейс судалгаа”
15. Үндэсний Статистикийн Хороо (2014) Төрийн бус байгууллагын секторын хүрээг тодорхойлох тухай
16. Эдийн засгийн Бодлого судлал Нийгэмлэг (2004 он). “Нийгмийн хувьчлал туршилт” Эрүүл мэндийн салбарын хувьчлал судалгаа (Монголэмимпекс, Эмийн үйлдвэр, Клиникийн III эмнэлэг, Шаргалжуут, Хужирт рашаан сувиллын туршлага)

Онлайн эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn
2. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын вэб сайт дахь 2018 оны 1 дүгээр сард татан буугдсан хуулийн этгээдийн жагсаалт: www.burtgel.gov.mn/index.php/cancelles/1940-2018-1
3. “Тогтвортой хөгжил – Ерөнхий боловсрол” Улсын II зөвлөгөөн: Ерөнхий боловсролын зардлын норм, норматив, санхүүжилтийн шинэчлэлт: www.zuvluguun.edu.mn/file/2ff0eed1bb0f27aef7f994febe74982.pdf
4. АНУ дахь ашгийн бус байгууллагын төрөл, түүнийг байгуулах журам: www.usa.gov/start-nonprofit
5. Tax-Exempt Status for Your Organization, АНУ-ын татварын байгууллагын вэб хуудас (Internal Revenue Service, US Department of the Treasury) www.irs.gov/pub/irs-pdf/p557.pdf
6. Applying for Tax Exempt Status, АНУ-ын татварын байгууллагын вэб хуудас (Internal Revenue Service) www.irs.gov/charities-nonprofits/applying-for-tax-exempt-status
7. Apply for licenses and permits, АНУ-ын Жижиг бизнесийн захиргааны вэб хуудас (US Small Business Administration): www.sba.gov/business-guide/launch/apply-for-licenses-permits-federal-state#section-header-0
8. АНУ-ын Засгийн газрын санхүүжилт авах журам: Grants.gov: www.grants.gov/web/grants/home.html
9. America’s Nonprofits, National Council of Non-profits: www.councilofnonprofits.org/what-is-a-nonprofit
10. Charitable trust, Wikipedia: https://en.wikipedia.org/wiki/Charitable_trust
11. 501(c)(3) organization статусын тухай, Wikipedia: [https://en.wikipedia.org/wiki/501\(c\)\(3\)_organization](https://en.wikipedia.org/wiki/501(c)(3)_organization)
12. U.S. Code § 501 - Exemption from tax on corporations, certain trusts, etc. Корнеллийн их сургуулийн Хуулийн сургуулийн вэб сайт: www.law.cornell.edu/uscode/text/26/501
13. 私立学校法（昭和二十四年法律第二百七十号）
14. 国立大学法人法（平成十五年法律第一百十二号）
15. 地方独立行政法人法（平成十五年法律第一百十八号）
16. 独立行政法人通則法（平成十一年法律第三百三号）
17. Японы Сангийн яамны вэб хуудас: www.mof.go.jp/tax_policy/summary/corporation/251.htm
18. Японы Хууль зүйн яамны вэб хуудас www.moj.go.jp/MINJI/minji153.html#01
19. Японы Засгийн газрын танхимын вэб хуудас: www.cao.go.jp/others/koeki_npo/koeki_npo_seido.html
20. Японы Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны вэб хуудас: www.mext.go.jp/a_menu/koutou/shinkou/07021403/003.htm
21. ХБНГУ дахь ашгийн бус байгууллагын тухай мэдээлэл, Council on Foundations: www.cof.org/content/germany

Хавсралт 1: АШГИЙН БУС САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

А.ХБНГУ–ын ашгийн бус салбарын эрх зүйн зохицуулалт⁵³

ХБНГУ дахь ашгийн бус байгууллагын төрөл

ХБНГУ нь эх газрын буюу иргэний эрх зүйн бүлд хамаарах холбооны улс бөгөөд ашгийн бус байгууллагын дараах үндсэн гурван хэлбэр байдаг. Үүнд:

- Нийгэмлэг
- Сан
- Хязгаарлагдмал хариуцлагатай компани.

Ашгийн бус байгууллагууд энэхүү гурван хэлбэрээс ихэвчлэн ХХК-ийн хэлбэрийг сонгож үйл ажиллагаа явуулдаг ажээ.

Нийгэмлэг, сангийн хувьд албан болон албан бус гэсэн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж болох ба албан ёсны нийгэмлэг, сан нь хуулиар олгогдсон эрх зүйн чадамжтайд тооцогддог. Харин албан бус нийгэмлэгийн эрх зүйн чадамжгүй гэж үздэг байсан боловч сүүлийн үед эрх зүйн чадамжтайд тооцох хандлага ажиглагдах болжээ. Албан бус сангууд нь нэг талаар эрх зүйн чадамжгүй хэдий

ч бэлэглэл, итгэлцлийн гэрээний дагуу байгуулагддагаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, тодорхой эрх зүйн харилцаанд оролцож, эрх эдэлж болдог байна.

Герман Улсад ашгийн бус байгууллагууд нь ерөнхийдөө холбооны хуульд захирагддаг бол сангуудын хувьд мужийн хуульд зарим талаар хамаардаг. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллага татварын эрх ямба эдлэх эсэхийг Холбооны хуулиар тодорхойлдог бол эцсийн шийдвэрийг орон нутгийн татварын байгууллага гаргадаг.

Татварын хуулийн зохицуулалт

Ерөнхийд нь авч үзвэл зөвхөн нийтийн ашиг сонирхлын болон шашны зорилгоор үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагууд Германд аж ахуйн нэгжийн, худалдааны, бэлэглэл болон өв залгамжлалын татваруудаас чөлөөлөгддөг. Энэ талаар Германы Санхүүгийн хуулийн 52-54 дэх зүйлд тодорхой зохицуулсан байдаг.

Германы хувьд ихэнх төрлийн худалдаа, үйлчилгээнд нэмүү өртгийн албан

⁵³ Мэдээллийг <http://www.cof.org/content/germany> нийтлэлээс сийрүүлэн бэлтгэсэн ба 2016 оны 12 дугаар сарын байдлаар судалсан болно.

татвар (НӨАТ) оногдуулдаг ч эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээрх нийтийн ашиг тусад зориулагдсан үйл ажиллагаанд энэ төрлийн татварын хөнгөлөлт үзүүлдэг байна. Татвар төлөгчийн үйл ажиллагааны зорилгоос хамаарч НӨАТ-ын хэмжээ 19-өөс 7 хувь болж буурна. Хэрэв ашгийн бус байгууллагад олгосон тэтгэлэг нь НӨАТ ногдох үйлчилгээ байвал тухайн төслийн зарлагад багтсан НӨАТ-ыг буцаан олгоно. Энэ тохиолдолд ашгийн бус байгууллагыг тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн хэрэглэгч гэсэн байр сууринаас авч үзнэ.

Нийгэмлэг: Нийтлэг зорилгынхоо төлөө нэгдэж, байнгын үйл ажиллагаа явуулж буй гишүүнчлэлтэй байгууллагыг нийгэмлэг гэнэ. Нийтийн, эсвэл зөвхөн гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажиллах эсэхээс үл хамааран нийгэмлэг байгуулахад заавал зөвшөөрөл авна.

Нийгэмлэгийг эдийн засгийн ба эдийн засгийн бус нийгэмлэг гэж ангилах ба зөвхөн эдийн засгийн нийгэмлэг нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Нийгэмлэгийн тухай хуулийн 4 дүгээр хэсэгт худалдааны үйл ажиллагаанаас бусад төрлийн, хуульд нийцсэн зорилготой байж болно гэж заасан байдаг ч энэ нь ерөнхий зохицуулалтын шинжтэй байна.

Эдийн засгийн бус нийгэмлэгийн эрх зүйн чадамж орон нутгийн шүүхэд бүртгүүлснээр үүсэх (Иргэний хууль 21-р

зүйл) ба ийнхүү бүртгүүлснээр Иргэний хуулийн 55-р зүйлийн дагуу “e.V” гэсэн тэмдэглэгээ авдаг. Иргэний хуулийн 59-р зүйлд заасны дагуу нийгэмлэг нь бүртгүүлэх үедээ дор хаяж 7 гишүүнтэй байх ба нэгэнт бүртгүүлсний дараа гишүүдийн тоо цөөрч болох ч гурваас бага байж болохгүй.

Нийгэмлэг байгуулагдсаны дараа төрийн оролцоо нэлээд бага байдаг. Нийтийн захиргааны байгууллагууд Нийгэмлэгийн хуульд заасан цөөн тооны үндэслэлээр нийгэмлэгийн үйл ажиллагааг зогсоож болох ч ийм тохиолдол маш ховор гардаг

Сан: Германы Иргэний хуулийн 80-88 дугаар зүйлийн хүрээнд байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд зөвхөн үүсгэн байгуулагчаас тодорхойлсон зорилгын дагуу орлогоо зарцуулдаг онцлогтой. Одоогийн Иргэний хууль дахь зохицуулалтыг 2002 оны Сангийн хуулийг шинэчлэх тухай хууль, 2013 оны Сайн дурын үйл ажиллагааг дэмжих хуулиар нарийвчлан зохицуулжээ. Иргэний хуульд заасны дагуу сан нь төв оффисынхоо оршин байгаа газрын зохих эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр эрх зүйн чадамжтай болно. (ИХ 80-р зүйл). Сангийн бүртгэлд баримтлах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд зохих эрх бүхий байгууллага батална. Хувь хүн, хуулийн этгээдийн аль нь ч сан үүсгэн байгуулж болно. Сан нь гэр бүлийнх ч байж болох ба гагцхүү хуульд нийцсэн зорилгоор ажиллах ёстой.

Сан байгуулахад шаардагдах мөнгөн хөрөнгийн дүнг хуулиар зохицуулаагүй ч, байнгын үйл ажиллагаа эрхлэх, тогтвортой дэмжлэгтэйгээ нотлох ёстой. Ийм учраас орон нутгийн эрх бүхий байгууллагууд өөр өөр дүн бүхий мөнгөн хөрөнгө шаарддаг бөгөөд энэ нь хамгийн багадаа 50,000 евро байдаг ажээ. Түүнчлэн сан нь зөвхөн тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулахаар байгуулагдаж болох ба энэ нь 10 жилээс багагүй байх талаар Иргэний хуулийн 80.2-т заажээ. Мужуудын сангийн хуулийн дагуу тухайн мужийн яам, захиргааны байгууллагууд сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ба сан нь жилийн тайлангаа мужийн удирдлагад гаргаж өгөх үүрэгтэй. Зарим тохиолдолд холбооны түвшний сангийн хууль тогтоомж нь сан байгуулсны дараа мужийн түвшний удирдах газраас зөвшөөрөл авсан байхыг шаарддаг байна. Түүхээс үзвэл, олонх мужид санд зөвшөөрөл олгоход маш олон шаардлага тавьдаг байсан нь үр дүн багатай, өртөг, хүнд суртал ихтэй байсан тул 1990-ээд оны эхнээс цөөрүүлжээ. Санг татан буулгах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахад мужийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах боловч энэ нь мужийн зүгээс тулгаж буй үйлдэл байх ёсгүй ба тэд хууль болон сангийн үүсгэн байгуулагчийн хүсэл зоригийг дагах ёстой. Хэрэв шаардлагатай бол мужийн засаг захиргаа нь Холбооны хуульд заасан нэмэлт лавлагаа мэдээллийг авч болно. Үйл ажиллагаанд нь ноцтой

зөрчил гарсан тохиолдолд дээд шатны төрийн эрх бүхий байгууллагаас сангийн удирдах зөвлөлийн гишүүнийг татгалзан гаргаж, сангийн нэрийн өмнөөс ажиллах шинэ гишүүн томилдог. Сангийн үйл ажиллагааны доголдлоос шалтгаалан төр ийнхүү хөндлөнгөөс оролцох нөхцөл үүсэх боловч зарим тохиолдолд уг асуудлыг шүүхээр хянах нь бий. Сан хэмээх герман үг нь зөвхөн ашгийн бус үйл ажиллагаатай байгууллагад хамаардаггүй бөгөөд ашгийн төлөөх нийгэмлэг, хувьцаат компани, ХХК хэлбэрийн байгууллагууд ч нэрийнхээ ард “сан” гэсэн үг залгаж хэрэглэдэг. Жишээлбэл, Германдаа нэлээд томд тооцогддог Роберт Бош Сан хэмээх байгууллага нь ХХК-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани: Ашгийн төлөө бус зорилготой ХХК нь “GmbH” хэмээх аж ахуйн нэгжийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болох ба энэ нь тусгай хуулийн дагуу бүртгэгдэж зохицуулагдана. GmbH гэдэг нь аж ахуйн үйл ажиллагааг компанийн хэлбэрээр хэрэгжүүлж байгаа эрх зүйн чадамжтай хуулийн этгээд бөгөөд хувьцаа эзэмшигчдээс бүрдүүлсэн хөрөнгөтэй байна. Гэхдээ хувьцаа эзэмшигчид нь компанийн өрийг хариуцахгүй. Ашгийн бус байгууллага нь аливаа үйлчилгээг нөхөн төлбөргүйгээр хүргэх зорилготой тул хуулийн этгээдийн энэ хэлбэрийг ихэвчлэн сонгож хэрэглэдэг байна.

Нийтийн ашиг тусын төлөө ажиллах статус: Нийтийн ашиг тусын төлөө ажиллах зорилготой ашгийн бус байгууллагын тусгайлсан хэлбэр гэж Германд байдаггүй. Харин дээр дурдсанчлан сан, нийгэмлэг, аж ахуйн нэгжийн аль нь ч хувийн болон нийтийн тусын тулд ажиллаж болохоор байна. Иргэдийн нийтлэг ашиг сонирхлын төлөө нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага татварын хуулийн шаардлагыг хангасан тохиолдолд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болно.

Татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд тавих шаардлага: “Нийтэд тусгай үйл ажиллагаа”-г Санхүүгийн хуулиар (Abgabenordnung, or AO) тодорхойлдог. Харин үүнийг татварын хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг Орлогын болон Аж ахуйн нэгжийн татварын, Худалдааны болон НӨАТ-ын, Өв залгамжлал болон Бэлэглэлийн татварын хуулиудаар тус тус зохицуулжээ. Санхүүгийн хуулиар хуулийн этгээдийн ямар үйл ажиллагаа татварын хөнгөлөлтөд хамаарахыг зохицуулснаас гадна тэдгээр байгууллагад тавигдах тусгай шаардлагыг мөн тогтоожээ. Үүнд дараах 3 төрлийн үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт эдлүүлэхээр заажээ.

1. Нийтийн ашиг тусын төлөө зорилготой - Санхүүгийн хуулийн 52-р зүйл,
2. Буяны ба сайн санааны төлөөх зорилготой- Санхүүгийн хуулийн 53-р зүйл,

3. Сүмтэй холбоотой үйл ажиллагаа - Санхүүгийн хуулийн 54-р зүйл.

Санхүүгийн хуулийн 52-р зүйлийн нэгдүгээр дэд хэсэгт зааснаар нийтэд тустай үйл ажиллагаа гэж “олон нийтийг эд материал, оюун санаа, ёс суртахуунаар дэмжих зорилготой үйл ажиллагаа” хэмээн заажээ. Гэхдээ дэмжлэг хүлээн авагч этгээд нь нэг гэр бүлийн гишүүд, нэгэн байгууллагын ажилтнууд гэх мэт цөөн хүнээс бүрдсэн бүлэг байж болохгүй.

Санхүүгийн хуулийн 52-р зүйлийн хоёрдугаар дэд хэсэгт дээр дурдсан нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх салбаруудын жагсаалтыг хуульчилсан байна. Энэхүү жагсаалт 2007 оноос хойш өөрчлөгдөөгүй бөгөөд дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1. Шинжлэх ухааны үйл ажиллагаа;
2. Шашны үйл ажиллагаа;
3. Олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ;
4. Залуус, өндөр настнуудад зориулсан үйл ажиллагаа;
5. Урлаг, соёлын үйл ажиллагаа;
6. Түүхийн өвийг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа;
7. Боловсролын үйл ажиллагаа;
8. Хүрээлэн буй орчныг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа;
9. Нийгмийн хамгаалал;
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хохирогч, болон улс төрийн хавчлагад өртсөн иргэдэд туслах үйл ажиллагаа;
11. Авран хамгаалах үйл ажиллагаа;

12. Гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
13. Олон улсын ойлголцол, харилцан зөвшилцлийг бий болгохтой холбоотой ажиллагаа;
14. Амьтан хамгаалах үйл ажиллагаа;
15. Хөгжлийн тусламжийн ажиллагаа;
16. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа;
17. Ялтныг нийгэмшүүлэх үйл ажиллагаа;
18. Хүйсийн эрх чөлөө, өсвөр насныханд туслах үйл ажиллагаа;
19. Гэрлэлт, гэр бүлтэй холбоотой үйл ажиллагаа;
20. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;
21. Бүх төрлийн спорт, шатартай холбоотой үйл ажиллагаа;
22. Орон нутгийн түүх, газар зүйтэй холбоотой үйл ажиллагаа
23. Мал-амьтан ба ургамал үржүүлэг, түрээсийн газар дээрх тариалангийн үйл ажиллагаа;
24. Герман Улсад улс төрийн ардчилсан тогтолцоог дэмжих үйл ажиллагаа;
25. Олон нийтийн тусын тулд үүссэн иргэний нийгмийн үйл ажиллагаа.

Гэхдээ захиргааны тусгай зорилгын хүрээнд өөр бусад үйл ажиллагааг нэмж болдог байна. Ийнхүү нэмэхтэй холбоотой тайлбарыг Санхүүгийн тухай хуулийг хэрэгжүүлэх дүрмүүдэд нарийвчлан заажээ. (Anwendungserlass zur Abgabenordnung)

Буяны, сайн санааны үйл ажиллагаа

эрхэлдэг байгууллага гэдэгт эдийн засаг, бие, сэтгэл санаа, сэтгэцийн нөхцөл байдалтай нь холбоотойгоор хүмүүсийг дэмжих, туслах чиглэлээр ажилладаг байгууллагыг ойлгоно (Санхүүгийн хуулийн 53-р зүйл). Сүмтэй холбоотой үйл ажиллагааны зорилгод шашны үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн байгууллага, мөргөлийн үйл ажиллагаанд зориулсан барилгын ажил, оюун санааны хөгжлийн болон шашны боловсролын үйл ажиллагаа багтана (Санхүүгийн хуулийн 54-р зүйл).

Татварын хөнгөлөлт эдлэх статус олгоход тавих бусад шаардлага

Нийтэд тустай үйл ажиллагааг ийнхүү дэмжихээс гадна татварын хөнгөлөлт эдлэх байгууллагад хэд хэдэн нэмэлт шаардлага тавьдаг.

Санхүүгийн хуулийн 56-р зүйлийн дагуу татварын хөнгөлөлт эдлэх байгууллага нь зөвхөн нийтийн тусын тулд үйлчлэх зорилгыг дүрэмдээ тусгасан байна. Ийм учраас татварын хөнгөлөлт эдлэх байгууллага нь гишүүд, захирал болон бусад хүмүүст хариу төлбөргүйгээр хөрөнгө хуваарилах боломжгүй. Мөн байгууллага татан буугдахад хөрөнгийг татварын хөнгөлөлт эдлэх өөр байгууллагад шилжүүлнэ. Үүнд захиргааны зардлыг тооцохгүй боловч тухайн зардлын үндэслэлийг нотлох шаардлагатай. Санхүүгийн хуулийн 58.5-д заасны дагуу сангийн үүсгэн байгуулагч,

эсвэл түүний гэр бүлийн гишүүн нь жилийн цэвэр орлогынхоо гуравны нэг хүртэлх хувийг авч болох ба ийнхүү авч байгаа хөрөнгийн үнийн дүн нь хэт их бөгөөд үндэслэлгүй байж болохгүй. Санхүүгийн тухай хуулийн 55-р зүйлд дараах зүйлийг мөн тусгажээ. Үүнд:

1. Үнэнч байх үүрэг. Үүнд хувь хүнд хөрөнгө түгээхгүй байхтай холбоотой шаардлага, хориглолтууд багтана.
2. Зохих цаг хугацаанд нь зарцуулах. Энэхүү журамд зааснаар татварын хөнгөлөлт эдэлдэг байгууллага нь татварын өмнөх орлогынхоо гуравны нэгийг, татварын дараах орлогын аравны нэгийг хуримтлуулж болно. Түүнчлэн тодорхой шалгуурыг хангасан нөхцөлд санд өгсөн хандив тусламжийг хадгалан хуримтлал үүсгэж болдог.
3. Татварын хөнгөлөлт эдэлдэг байгууллага нь өөрийн болон гишүүдийнхээ эдийн засгийн ашиг сонирхлыг тэргүүнд авч үзэж болохгүй. Гэхдээ энэхүү зохицуулалт төдийлөн тодорхой бус учраас практикт хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсдэг. Жишээ нь, бүс нутгийн аялал жуулчлалыг дэмжих зорилготой нийгэмлэг нь Санхүүгийн хуулийн дагуу (52.22) татварын хөнгөлөлт эдлэх байгууллагад тооцогдоно. Гэтэл нийгэмлэгийн гишүүн нь зочид буудал, аялал жуулчлалын бизнес эрхлэгч этгээд бол нийгэмлэг гишүүнийхээ эдийн засгийн ашиг сонирхлыг дэмжсэн болж таарах

ба энэ нь Санхүүгийн хуулийн 55-р зүйлийг зөрчсөн хэрэг болно.

Санхүүгийн хуулийн 56-р зүйлд зааснаар татварын хөнгөлөлт эдлэх байгууллага нь зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааг өөрөө явуулж болохоос гадна гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж болно.

Татварын хөнгөлөлт эдлэх байгууллага нь дүрэмдээ татварын хуульд заасан албан ёсны шаардлагыг заавал тусгах бөгөөд үүнд татан буугдах үед хөрөнгөө татварын хөнгөлөлт эдлэх өөр ашгийн бус байгууллагад шилжүүлнэ гэх мэт заалт хамаарна.

Орон нутгийн хуулийн зохицуулалт

Ашгийн бус хуулийн этгээдийн хязгаарлалт: Татварын хууль ба Санхүүгийн хуулийн 55-р зүйлийн дагуу ашгийн бус байгууллагын хувийн хэрэглээний зарцуулалтад дараах хориг тавьдаг.

1. Ашгийн бус байгууллага нь зөвхөн татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд хөрөнгөө зарцуулна.
2. Нийгэмлэг, сан гэх мэт ашгийн бус байгууллагын гишүүд, үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч, өв залгамжлагчид нь ямар нэг байдлаар ногдол ашиг хэлбэрээр хөрөнгө хуваарилан авах ёсгүй. Гэхдээ Санхүүгийн хуулийн 58.5-д заасан тохиолдолд сан нь орлогынхоо

гуравны нэг хүртэлх хувийг үүсгэн байгуулагч, түүний ойрын төрлийн хүнийг дэмжих, аль эсвэл бүр булшны чулууг нь бүтээх гэх мэт тодорхой зориулалтаар олгож болдог. Түүнчлэн, орлогынхоо гуравны нэг хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг хандивт зориулан хадгалж болно.

3. Ашгийн бус байгууллагаас хэн ч хувьдаа ашиг хуваарилж, эсхүл үндэслэлгүйгээр цалин хөлс, орлого авч болохгүй.
4. Байгууллага татан буугдах тохиолдолд хөрөнгийг нь татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий, ашгийн бус зорилготой нийтийн эрх зүйн байгууллагад шилжүүлнэ.
5. Аж ахуйн нэгжийн хэлбэрээр байгуулагдсан ашгийн бус байгууллагын хувь эзэмшигчид нь гишүүнчлэлээсээ, эсвэл аж ахуйн нэгж татан буугдсан үед оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр нөхөн олговор авч болох ба нөхөн олговрын хэмжээг зах зээлийн дундаж үнэлгээг харгалзан тооцно. Үлдэгдэл хөрөнгийг татварын хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд зориулан хандивлана.

Татан буулгах: Хэрэв татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий байгууллага татан буугдвал үлдэж буй хөрөнгө нь зөвхөн ойролцоо төрлийн ашгийн бус үйл ажиллагаанд зориулагдах ёстой. Энэхүү шаардлага нь хөрөнгийг татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий өөр байгууллагад шилжүүлснээр, эсвэл ийм

зорилгын хүрээнд төрийн байгууллагад шилжүүлснээр хэрэгжсэнд тооцно. (Санхүүгийн хуулийн 55-р зүйл) Сан нь хэд хэдэн сан болж хуваагдах боломжтой бол аж ахуйн нэгжийн хэлбэртэй ашгийн бус байгууллагын хувьд үүсгэн байгуулсан хувь эзэмшигч нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр нөхөн олговор авч болох ба үлдсэн хөрөнгийг мөн л татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий үйл ажиллагаанд зориулан шилжүүлнэ.

Үйл ажиллагааны хэлбэр

А. Ерөнхий үйл ажиллагаа -Дээр дурдсанчлан Герман Улсад ашгийн бус байгууллага нь хуулийн этгээдийн эрхтэй, эсхүл хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хэлбэрээр ажиллаж болно. Хуулийн этгээдийн эрхтэй ашгийн бус байгууллага нь дээр дурдсан хуулиудын хүрээнд бүх төрлийн нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж болно.

Б. Нийтэд тустай үйл ажиллагаа – Энэ үйл ажиллагаа нь байгууллагын үүсгэн байгуулагдсан хэлбэрээс үл хамаарах ойлголт юм. Өөрөөр хэлбэл, нийтэд тустай үйл ажиллагааг сан, нийгэмлэг, аж ахуйн нэгж зэрэг аль ч хэлбэрийн байгууллага эрхэлж болно. Харин үйл ажиллагааных нь “нийтэд тустай” байх шинжийг Санхүүгийн хуулиар тодорхойлсон байдаг.

В. Аж ахуйн буюу эдийн засгийн үйл ажиллагаа - Германд ашгийн бус байгууллагууд хуульд заасан

хязгаарлалтын дотор аж ахуйн үйл ажиллагаа явуулж болдог. Өөрөөр хэлбэл, дүрмийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагааных нь орлогыг ашгийн татвараас чөлөөлж, НӨАТ-ыг 7 хүртэл хувиар бууруулна. Харин дүрмийн зорилгод хамааралгүй үйл ажиллагааны жилийн орлого нь 35000 еврогоос хэтэрсэн тохиолдолд ердийн журмаар татвар ногдуулна (Санхүүгийн хууль 64-р зүйл).

Г. Улс төрийн үйл ажиллагаа- Германы татварын хуулиар улс төрийн үйл ажиллагаанд зарим хязгаарлалт тогтоосон байдаг. Нэгдүгээрт, татварын хөнгөлөлтөд хамаарах үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд улс төрийн намд зориулан шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулах боломжгүй. Жишээлбэл, намын компанит ажил гэх мэт (Санхүүгийн хууль, 55.1 зүйл).

Санхүүгийн хуулийн 52-р зүйлийг хэрэгжүүлэх дүрэмд улс төрийн зорилго гэдгийг нийтэд тустай үйл ажиллагаанаас зааглаж тайлбарласан байдаг. “Улс төрийн” хэмээх нэр томъёо нь тухайн нийгмийн нэг хэсэг болсон олон нийтийн үзэл бодлын дагуу өрнүүлсэн үйл ажиллагаа гэсэн агуулгатай гэжээ. Гэхдээ ашгийн бус байгууллага тодорхой тохиолдолд улс төрийн асуудлаар байр суурь илэрхийлэх, хуулийн төслийн талаар хууль тогтоогчтой санал солилцохыг зөвшөөрдөг ба татварын эрх эдлэх статусаа алдахааргүй нөхцөлд ийм

үйл ажиллагаа явуулж болно. Улс төрийн боловсрол олгох, ардчиллыг дэмжих зэрэг ерөнхий зорилготой үйл ажиллагаа татварын хөнгөлөлтөд хамаарна. Гэхдээ ашгийн бус байгууллагаас явуулсан улс төрийн шинжтэй үйл ажиллагаа нь татварын хөнгөлөлтөд хамаарах эсэхийг тохиолдол тус бүрээр нарийвчлан тогтоодог. Жишээлбэл, Аттак хэмээх байгууллагын санхүүгийн гүйлгээний татвар болон баялгийн татварын хууль сурталчлахад чиглэсэн үйл ажиллагааг нийтийн тусын тулд хийсэн улс төрийн үйл ажиллагаа гэж үзсэн ба аль нэг улс төрийн намыг дэмжсэн хэрэг биш учраас татварын хөнгөлөлт эдэлж болно гэж Хессиа мужийн Санхүүгийн шүүхээс шийдвэрлэсэн байна.

Байгууллагын дотоод хяналт: Ашгийн бус байгууллагын удирдлагын гол шийдвэрийг удирдах зөвлөл нь гаргах боловч зарим тодорхой шийдвэрт төр оролцож хяналт тавьдаг. Хувьцаат компанийн хэлбэрээр ашгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын удирдлагад хамаарах тусгайлсан дүрэм журам байхгүй. Мөн хувьцаа эзэмшигчийн тоо хэд байж болох талаар хуулийн нарийвчилсан шаардлага байхгүй бөгөөд тэдгээр нь хувь хүн болон хуулийн этгээд байж болно. Иймд Германд ашгийн төлөө хуулийн этгээд, эсвэл гадаадын хандивын байгууллага дангаараа ашгийн бус байгууллага байгуулан ажиллах боломжтой. Татварын хөнгөлөлт эдлэхийг хүсэж буй ашгийн

бус байгууллагын үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг Татварын хуулийн дөрөвдүгээр бүлгийн А-С хэсэгт заажээ.

Нийгэмлэгийн удирдлагын бүтцийг Иргэний хуулийн 55-р хэсэгт тодорхойлжээ. Нийгэмлэгийн удирдлагын тогтолцоо нь захирлуудын зөвлөл болон бүх гишүүдийн хурлаас бүрдэнэ. Ашгийн бус байгууллагад хамаарах татварын хөнгөлөлтийн хувь хэмжээг татварын үнэлгээнд суурилан, нэмэлт дүрэм журмын дагуу тогтоодог байна.

Захирлуудын зөвлөл нь менежментийг хариуцаж, үйл ажиллагааны ерөнхий бодлогыг хэрэгжүүлэхээс гадна нийгэмлэгийг төлөөлж ажиллана. Мөн хууль болон нийгэмлэгийн дүрэмд заасны дагуу бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах үүрэгтэй. Бүх гишүүдийн хурлаар гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх, нийгэмлэгийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, нийгэмлэгийг татан буулгах, нэгтгэх, хуваах гэх мэт өөрчлөн байгуулахтай холбоотой шийдвэрийг гаргана.

Татварын хөнгөлөлт: Германд Аж ахуйн нэгжийн татварын хуулийн 5.1.9 дүгээр зүйл, Санхүүгийн хуулийн 14 ба 65-р зүйлийн дагуу ашгийн бус байгууллагын хуримтлалыг эх сурвалжаар нь 4 ангилжээ.

1. Биет бус хуримтлал. Гишүүнийн татвар, хандивын орлого. Эдгээр нь татварын хөнгөлөлтөд хамаарна.

2. Хөрөнгийн удирдлагын үр дүнд бий болсон идэвхгүй орлого. Жишээлбэл бонд, хувьцаа, үл хөдлөх хөрөнгөөс орж буй орлого үүнд хамаарах ба ашгийн бус байгууллагын энэ төрлийн орлогыг мөн татварын хөнгөлөлтөд хамруулна.
3. Татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий байгууллагын дүрэмд тусгасан зорилгынхоо хүрээнд явуулсан аж ахуйн үйл ажиллагааны орлого. Энэ төрлийн орлогыг татварын хөнгөлөлтөд хамааруулж болох ба хамгийн гол нь тухайн үйл ажиллагаа нь Өрсөлдөөний хууль тогтоомжийг зөрчөөгүй байх ёстой. Харин эмнэлэг, залуучуудад зориулсан нийтийн байр байгуулах гэх мэт үйл ажиллагааны орлогыг өрсөлдөөний хуулийг зөрчсөн эсэхээс үл хамааран татварын хөнгөлөлтөд хамааруулна.
4. Татварын хөнгөлөлт эдлэхээс бусад үйл ажиллагаанаас олсон орлого. Жишээлбэл, татварын хөнгөлөлт эдэлдэг нэгэн ашгийн бус байгууллага гоймон үйлдвэрлэгч компанийн хяналтын хувьцааг эзэмшдэг ба хэдийгээр үүнээс олох ногдол ашиг нь татвар ногдох орлого мөн боловч жилд 35000 хүртэлх евротой тэнцэх хэмжээний орлогыг татвараас чөлөөлдөг байна.

Герман Улсад бүртгэлтэй ашгийн бус байгууллагад тухайн улсын иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивыг татвараас

чөлөөлөх: Татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий байгууллагад хувь хүн, аж ахуйн нэгжээс хандивласан хөрөнгийг татвараас хасаж тооцохыг Германы Орлогын болон Аж ахуйн нэгжийн татварын хууль, Худалдааны татварын хуулиудаар зөвшөөрдөг. Ашгийн бус байгууллагад хандив өгсөн бол татвар ногдох орлогоо 20 хүртэл хувиар хасуулах боломжтой. Аж ахуйн нэгжийн хувь эргэлтийн нийт хөрөнгө, цалин хөлсний 0.4 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр татварын хасалт хийлгэж болно. Энэхүү хэмжээнээс хэтэрсэн бол дараа жилийн санхүүгийн тайландаа тусган хасалт хийлгэж болно. Түүнчлэн, хандивлагч хувь хүн 1 сая хүртэлх еврогийн хандивт татварын суутгал, хасалт хийлгэж болох ба гагцхүү уг хандив нь хуульд заасан шаардлага хангасан санд зориулагдсан байх ёстой. Татварын хасалт, суутгал нь тухайн хандив өгсөн жилд хэрэгжихээс гадна дараагийн 9 жилийн туршид хэсэгчлэн хийгдэж болно.

Орлогын татварын хуулийн 106 хэсэгт заасны дагуу хандив хүлээн авагч нь Герман болон Европын холбооны гишүүн аль нэг улсад үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй байх ёстой. Мөн энэхүү шаардлага нь Аж ахуйн нэгжийн татварын хууль болон Худалдааны татварын хуульд тусгагджээ.

Бэлэглэл болон Өв залгамжлалын татвар: Герман Улсад бүртгэлтэй санд үе шаттайгаар хөрөнгө шилжүүлсэн

тохиолдолд нийт шилжүүлсэн хөрөнгийн дүнд үндэслэн татвар ноогдуулна. Бэлэглэл болон өв залгамжлалын татварын хөнгөлөлт нь давхар татварын гэрээ бүхий гадаад улсын байгууллагад хандивласан хөрөнгөд мөн адил хамаарна. Өв залгамжлалын татвараас бүрэн хөнгөлөх хугацаа нь өвийн зүйлийг татварын хөнгөлөлт эдлэх эрх бүхий санд шилжүүлснээс хойш хоёр жил байна.

НӨАТ: Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны үйл ажиллагааг нийтийн тустай хэмээн тодорхойлбол НӨАТ-ын хөнгөлөлт олгогдоно. Үүнээс гадна ашгийн бус байгууллагын дүрэмд тусгагдсан зорилгынхоо хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө түрээслэх, зохиогчийн эрх ашиглуулсны төлбөр зэрэг үйл ажиллагааны орлогод 7 хувийн НӨАТ ногдуулдаг. Харин тэтгэлэгт НӨАТ ногдуулахгүй.

Бусад татвар: Санхүүгийн хуулийн 51-68 дахь хэсэгт заасан ашгийн бус байгууллагын нийтэд тустай үйл ажиллагааны орлогод худалдааны татвар ногдуулахгүй.

Ашгийн бус салбарын харилцааг зохицуулж буй хуулиуд

- ХБНГУ-ын Үндсэн хууль,
- ХБНГУ-ын Иргэний хууль (Нэгдүгээр дэвтэр - Ерөнхий зүйл, Нэгдүгээр дэд хэсэг - Хүн, Хоёрдугаар хэсэг- Хуулийн этгээд, Нэгдүгээр бүлэг

- Холбоо, Хэсэг 21-79, Хоёрдугаар бүлэг- Сан, Хэсэг 80-88, Гуравдугаар бүлэг - Нийтийн эрх зүйн хуулийн этгээд, Хэсэг 89)
- ХБНГУ-ын Нийгэмлэгийн тухай хууль, 1964 он
- Сангийн тухай хууль, 16 муж тус бүрийн хууль
- ХБНГУ-ын Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухай хууль
- ХБНГУ-ын Санхүүгийн хууль, 1976, нэмэлт өөрчлөлт, Гуравдугаар хэсэг - Татвараас чөлөөлөх зорилго, үйл ажиллагаанууд
- ХБНГУ-ын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, 1999, нэмэлт өөрчлөлт, Тавдугаар хэсэг- чөлөөлөгдөх байгууллагууд, 9 дүгээр хэсэг – Хандивлагчдад хамаарах татварын суутгал
- Орон нутгийн худалдааны татвар, нутгийн захиргаанаас тогтоосон татвар
- ХБНГУ-ын Орлогын албан татварын хууль, 1997, нэмэлт өөрчлөлт, 10б хэсэг, Хандивлагч хувь хүнд зориулсан татварын урамшуулал
- Орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлэх дүрмүүд,
- Өв залгамжлал болон Бэлэглэлийн татварын хууль, 1997, хэсэг 13 ба 29, татварын хөнгөлөлт
- НӨАТ-ын хууль, 1999 он

Б. АНУ дахь ашгийн бус байгууллагын зохицуулалт

АНУ-д ашгийн бус байгууллагын тухай ойлголт анх 1600 оноос эхлэн улс төрийн эргэлт болон нийгэм, эдийн засгийн шаардлагаар хэлбэржиж эхэлсэн ба Дэлхийн II дайны дараа буюу 1950-1970 онд иргэний нийгмийн хөдөлгөөн идэвхжиж, нийтэд тустай, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг олон төрлийн байгууллага бий болсноор ашгийн бус байгууллагын тухай өнөөгийн ойлголт бүрэлдэн хөгжжээ.

Өнөөдрийн байдлаар АНУ-д ашгийн бус байгууллага, төрийн бус байгууллага гэх нэр томъёо бараг ижил утгаар хэрэглэгддэг ба үүнд ашиг олох зорилгогүйгээр олон нийт болон нийгэмд тустай үйл ажиллагаа явуулдаг

байгууллагыг ойлгож байна. Ашгийн бус байгууллага гэдэгт дараах төрлийн байгууллага хамаарна:

1. Буяны байгууллага буюу шашны байгууллага
2. Нийгмийн халамжийн байгууллага
3. Хөдөлмөр, хөдөө аж ахуйн байгууллага
4. Мэргэжлийн холбоод
5. Цэргийн байгууллага

Дээрх ашгийн бус байгууллагууд нь **Internal Revenue Service (IRS)** байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байх ба тус бүр өөр өөр төрлийн шаардлага, шалгуурыг хангасан байх ёстой.

IRS хуулийн 501(c)(3) дахь хэсэгт ашгийн

бус байгууллагын нийт 29 төрлийг жагсаасан ба тэдгээрийг татвараас чөлөөлөх үндсэн нөхцөлийг тус бүрт нь тодорхойлсон байдаг.

Ашгийн бус байгууллагыг үүсгэн байгуулах

АНУ-д ашгийн бус байгууллага байгуулах үйл явц нэлээд энгийн, компани үүсгэн байгуулах үйл явцтай төстэй боловч татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэхтэй холбоотой зарим нэг нэмэлт шаардлага тавьдаг. Ашгийн бус байгууллага үүсгэн байгуулахад дор дурдсан үндсэн алхмыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын нэрийг сонгох;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох – Удирдах үйл ажиллагааны үндсэн дүрмийг боловсруулах;
3. Байгууллагын хууль зүйн хэлбэрийг сонгох (Publication 557):
 - ▶ Хөрөнгө итгэмжлэгч (Trust)
 - ▶ Компани
 - ▶ Холбоо;
4. Дор дурдсан баримт бичгийг харьяалах мужийн эрх бүхий байгууллагад хүргүүлнэ:
 - ▶ Байгууллагын дүрэм
 - ▶ Үйлчилгээний хөлс төлсөн баримт;
5. Дараах байгууллага татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно (тусгай маягтын дагуу):
 - ▶ Буяны байгууллага буюу шашны байгууллага
 - ▶ Нийгмийн халамжийн байгууллага
 - ▶ Хөдөлмөр, хөдөө аж ахуйн байгууллага
 - ▶ Ажил хэргийн холбоод
 - ▶ Цэргийн байгууллага;

6. Дараах 3 түвшинд холбогдох зөвшөөрлийг авсан байх:

- ▶ Холбооны
- ▶ Мужийн
- ▶ Орон нутгийн.

Ашгийн бус байгууллагын удирдлагын тогтолцоо

АНУ-д ашгийн бус байгууллагын удирдлагыг бүх гишүүд, эсхүл зөвхөн Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

1. Гишүүд + Удирдах зөвлөл + Гүйцэтгэх удирдлага
2. Зөвхөн Удирдах зөвлөл + Гүйцэтгэх удирдлага

Гэхдээ Удирдах зөвлөл хэрэгжүүлэх тохиолдол практикт зонхилж байна. Энэ тохиолдолд гишүүдээс УЗ-ийг сонгох ба байгууллагын дүрэм, бусад дотоод баримт бичгээр УЗ-ийн эрх хэмжээг тодорхойлон тухайн байгууллагыг удирдах бүрэн эрхийг олгодог. УЗ-өөс гүйцэтгэх удирдлагыг томилно.

Ашгийн бус байгууллагын татвараас чөлөөлөгдөх статус

IRS хуулийн 501(c)-ийн дагуу дор дурдсан шаардлагыг хангасан дараах

байгууллагууд татвараас чөлөөлөгдөх эрх⁵⁴ эдэлж болно. Ийнхүү ашгийн бус байгууллага нь татвараас⁵⁵ чөлөөлөгдөх статустай болсноор жил бүр санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээнэ. Хэрэв ашгийн бус байгууллага хууль тогтоомж зөрчсөн, эсхүл ашиг олох үйл ажиллагаа явуулсан тохиолдолд татвараас чөлөөлөгдөх статусаа алдаж, татвараа нөхөн төлөх үр дагаварт хүрдэг.

1. Буяны болон шашны байгууллагад тавих шаардлага

- a. IRS хуулийн 501(c)(3)⁵⁶-г⁵⁷ заасан ашгийн бус зорилгоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг байх;
- b. Хувьцаа эзэмшигч, эсхүл хувь хүнд ямар нэг ашиг хуваарилахгүй байх;
- c. Улс төрийн, эсхүл хууль тогтоогч байгууллага биш байх (тухайлбал, улс

⁵⁴ Татвараас чөлөөлөх статус нь бүхий л татвараас чөлөөлөх баталгаа болохгүй.

⁵⁵ Татвар гэдэгт холбооны улсын орлогын албан татварыг ойлгох ба хөдөлмөрийн харилцаа, худалдаа, аливаа хөрөнгийн татвар үүнд хамаарахгүй.

⁵⁶ Шашны, буяны, шинжлэх ухааны, олон нийтийн аюулгүй байдлыг шалгах, утга зохиол, боловсрол, үндэсний болон олон улсын хэмжээнд спортын дугуйлан, тэмцээн, хүүхэд амьтан эзэнгүй орхигдохоос урьдчилан сэргийлэх гэх мэт зорилготой.

⁵⁷ Дээр дурдсан байгууллагуудыг олон нийтийн буяны байгууллага, хувийн сан гэсэн хоёр төрөлд ангилж, татвараас чөлөөлөх зохицуулалтыг хэрэглэнэ. Ийнхүү ангилах гол үндэслэл нь үйл ажиллагааныхаа санхүүжилтийг олон нийтээс татан төвлөрүүлж байна уу, эсхүл тодорхой хэсэг бүлэг хүмүүсээс хүлээн авч байна уу гэдэгт оршино.

төрийн компанит ажилд оролцохгүй, хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байх);

- d. Хувийн ашиг сонирхолд үйлчилдэггүй байх:
 - ▶ Буяны болон шашны байгууллага нь зөвхөн зөвшөөрөгдсөн хүрээнд улсын төрийн болон хууль тогтоох үйл ажиллагаанд оролцож болно.
 - ▶ Буяны болон шашны байгууллагын ашиг олох зорилгоор байгуулсан гэрээ хэлцэлд татвар ногдуулна.
 - ▶ Олон нийтийн аюулгүй байдлыг хангахаас бусад чиглэлээр ажилладаг буяны байгууллагын хөрөнгийг IRS хуулийн 170 дугаар хэсэгт заасны дагуу татварын хөнгөлөлтөд хамруулна.

2. Нийгмийн халамжийн байгууллагад тавих шаардлага:

- a. IRS хуулийн 501(c)(4)-г⁵⁸ заасны дагуу зөвхөн нийгмийн халамжийн чиглэлээр ашгийн бус үйл ажиллагаа эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан, уг зорилгоо хэрэгжүүлдэг байх;
- b. Ямар нэг хувьцаа эзэмшигч этгээд, эсхүл хувь хүнд ашиг хуваарилахгүй байх;
- c. Нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах тухайгаа IRS-д урьдчилан мэдэгдсэн байх;
- d. Хувийн ашиг сонирхлоос ангид байж зөвхөн нийгэмд үйлчлэх;

⁵⁸ Нийгмийн халамж, ажилчдын холбоог дэмжих зорилготой иргэний эрхийн байгууллага

- ▶ Нийгмийн халамжийг дэмжих үйл ажиллагааг ашиг олох зорилгоор ашиглахгүй байх. Тухайлбал, орон сууцны түрээслэгчдийн гишүүнчлэлтэй байгууллагыг нийгмийн халамжийн байгууллага гэж үзэхгүй боловч гишүүдээсээ гадна нийт орон сууц түрээслэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой бол нийгмийн халамжийн байгууллага гэж үзэж болно.
- ▶ Тухайн ашгийн бус байгууллагын дотоод дүрэм журмаар хориглоогүй бол Нийгмийн халамжийн хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоох ажиллагаанд лобби хийж болно. Хэрэв хууль тогтоох ажиллагаанд нөлөөлөл хийх бол гишүүддээ мэдэгдсэн байх ёстой.
- ▶ Буяны буюу шашны байгууллага хууль тогтоох ажиллагаанд оролцсоны улмаас татвараас чөлөөлөгдөх статусаа алдсан бол 501(с)(4)-т заасан нийгмийн халамжийн байгууллага болох өргөдөл гаргах эрхгүй.
- ▶ Олон нийтийн байгууллагын нэрийн өмнөөс, эсхүл олон нийтийн байгууллагын эсрэг чиглэсэн улс төрийн кампанит ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохгүй, нөлөөлөхгүй.
- ▶ Нийгмийн халамжийн байгууллага нь зөвхөн тодорхой тохиолдолд улс төрийн үйл ажиллагаанд оролцож болох боловч энэ нь тухайн байгууллагын нэн тэргүүний зорилго,

үйл ажиллагаа байх ёсгүй.

- ▶ Улс төрийн үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд тус хуулийн 527(f)-д заасны дагуу татвар ногдуулна.

3. Хөдөлмөр, хөдөө аж ахуйн болон хүлэмжийн судалгаа, тариалалтын үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тавих шаардлага

- a. IRS хуулийн 501(с)(5)-⁵⁹ заасан хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, хүлэмжийн судалгаа тариалалтын байгууллага байх;
 - b. Байгууллагын хөрөнгө, орлогоос гишүүддээ ашиг хуваарилдаггүй байх;
 - c. Байгууллагын үндсэн зорилго нь хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, хүлэмжийн судалгаа тариалалт, бүтээгдэхүүнийг боловсронгуй болгох, бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;
 - d. Хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, хүлэмжийн судалгаа тариалалтын нөхцөлийг дээрдүүлэх зорилготой тодорхой хөтөлбөрийн хүрээнд хууль тогтоох ажиллагаанд оролцож нөлөөлөл хийх эрхтэй;
- ▶ Хэрэв хууль тогтоох ажиллагаанд нөлөөлөл хийх тохиолдолд өөрийн гишүүддээ мэдэгдэнэ;
 - ▶ Улс төрийн үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд IRS хуулийн 527(f)-д заасны дагуу татвар ногдуулна.

⁵⁹ Хөдөлмөр эрхлэлт, хөдөө аж ахуй, хүлэмжийн судалгаа, тариалалтын байгууллага

4. Мэргэжлийн холбоонд⁶⁰ тавих шаардлага

- a. Зөвхөн IRS хуулийн 501(c)(6)-т⁶¹ заасан ашгийн бус зорилгоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг байх;
- b. Үйл ажиллагаа нь тодорхой нэг этгээдэд бус ижил түвшний бүх мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжих, сайжруулахад чиглэсэн байх;
- c. Ямар ч тохиолдолд байгууллагын хөрөнгөөс аливаа этгээдэд ашиг хуваарилахгүй байх;
- d. Худалдааны танхим болон худалдааны зөвлөлийг ижил төрлийн мэргэжлийн холбоо гэж үзэх ба тэдгээр нь худалдаа, эдийн засаг, аж үйлдвэрлэлийн нийтлэг ашиг сонирхлыг дэмжих, хамгаалах зорилготой.

5. Цэргийн байгууллагад тавих шаардлага

- a. IRS хуулийн 501(c)(19) болон (23)-т заасны дагуу 501(a)-д дурдсан АНУ-ын зэвсэгт хүчний албан хаагчдад зориулсан байгууллага байх;
- b. Өмнө нь Үйл ажиллагаа явуулж байсан болон одоо үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын зэвсэгт хүчний

шуудан, эсхүл ямар нэг байгууллага байх:

- i. Тухайн байгууллага, эсвэл шуудангийн нэгж, эсхүл нийгэмлэг байх
 - ii. Тухайн байгууллага, эсхүл шуудангийн хөрөнгө итгэмжлэгч, эсхүл сан байх;
- c. АНУ-д, эсхүл түүний эзэмшлийн нутаг дэвсгэр дээр үүсгэн байгуулагдсан байх
 - d. Нийт гишүүдийн 75 хувь нь чөлөөнд гарсан болон одоо цэргийн алба хааж байгаа хүмүүс, амь үрэгдсэн цэргийн албан хаагчийн ар гэр байх;
 - e. Нийт гишүүдийн 97,5 хувь нь:
 - i. АНУ-ын зэвсэгт хүчинд алба хааж байсан, эсхүл одоо алба хааж байгаа
 - ii. АНУ-ын цэргийн сургуулийн сонсогч
 - iii. Тэргүүн болон 2 дугаар шугамын цэрэг, бэлэвсэрсэн эхнэр, нөхөр, өв залгамжлагч;
 - f. Дор дурдсан нэг буюу түүнээс дээш зорилгыг агуулсан:⁶²
 - i. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг дэмжих
 - ii. Хөдөлмөрийн чадваргүй болсон цэргийн алба хаагчдад туслах
 - iii. Амь насаа алдсан цэргийн алба хаагчдын дурсгалыг хүндэтгэх үйл

⁶⁰ Үүнд бизнесийн нийтлэг ашиг сонирхолтой этгээдүүдийн нэгдлийг ойлгох ба ашиг олох зорилгогүйгээр зөвхөн гишүүдийн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих зорилготой байна.

⁶¹ Ажил хэргийн холбоод, худалдааны танхим, үл хөдлөх хөрөнгийн зөвлөл, худалдааны зөвлөл, мэргэжлийн хөл бөмбөгийн холбоо.

⁶² Энэ тохиолдолд 501(c)(4) - social welfare organizations, 501(c)(7) - social clubs, 501(c)(8) - fraternal beneficiary societies, 501(c)(10) - domestic fraternal societies, 501(c)(2) - title holding corporations зэрэг заалтын дагуу татвараас чөлөөлөгдөх боломжтой.

- ажиллагааг зохион байгуулах;
- iv. Шашны, буяны, шинжлэх ухааны, утга зохиолын, боловсролын (төрөлжилт) гэх мэт.

Ашгийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх ажиллагаа

Ашгийн бус салбарын ёс зүй ба хариуцлагын тухай хууль (An Ethics and Accountability Code for the Nonprofit Sector)-ийн дагуу IRS Хуулийн 501 (c) (3)⁶³, 501 (c) (4)⁶⁴, 501 (c) (6)⁶⁵-д заасан ашгийн бус байгууллагыг “Standards for Excellence Institute” байгууллагаас магадлан итгэмжилнэ. Standards for Excellence Institute нь ашгийн бус байгууллагын удирдлагыг түүний тогтолцоо, бодлого, үйл ажиллагаа, практикийг стандарт, ёс зүй, үр нөлөө, хуульд үндэслэсэн байдлаар нь шалгуур үзүүлэлт болгон үнэлнэ.

Ашгийн бус байгууллага нь дээрх асуудлаар өөрөө дүн шинжилгээ хийхгүй. Ийнхүү хөндлөнгийн байгууллагаар дүн шинжилгээ хийлгэх нь ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх зорилго агуулдаг байна.

Ашигласан эх сурвалж

1. <https://www.councilofnonprofits.org/what-is-a-nonprofit>
2. <https://www.grants.gov/web/grants/home.html>
3. <https://www.irs.gov/charities-non-profits/applying-for-tax-exempt-status>
4. <https://www.irs.gov/pub/irs-pdf/p557.pdf>
5. <https://www.irs.gov/pub/irs-pdf/p557.pdf>
6. <https://www.law.cornell.edu/uscode/text/26/501>
7. <http://www.proselex.net/Documents/NON-PROFIT.pdf>
8. <https://www.sba.gov/business-guide/launch/apply-for-licenses-permits-federal-state#section-header-0>
9. <https://www.usa.gov/start-nonprofit>
10. [https://en.wikipedia.org/wiki/501\(c\)\(3\)_organization](https://en.wikipedia.org/wiki/501(c)(3)_organization)
11. [https://en.wikipedia.org/wiki/501\(c\)\(3\)_organization](https://en.wikipedia.org/wiki/501(c)(3)_organization)

⁶³ Буяны буюу шашны байгууллага

⁶⁴ Нийгмийн халамжийн байгууллага

⁶⁵ Мэргэжлийн холбоод

В. Япон Улсын ашгийн бус хуулийн этгээдийн зохицуулалт

1. Хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалт

Япон Улсад хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг Иргэний хуулиар зохицуулдаг. Хуулийн этгээдийг хэлбэрээр нь хүмүүсийн нэгдэл болох хуулийн этгээд (Incorporated Associations /Цаашид “байгууллага” гэх), хөрөнгийн нэгдэл болох хуулийн этгээд (Incorporated Foundations /Цаашид “сан” гэх) гэж ангилдаг. Үүнээс гадна хуулийн этгээдийг зорилгоор нь ашгийн төлөө болон нийтийн ашиг сонирхлын төлөө хуулийн этгээд гэж ангилж ирсэн. 2006 оноос өмнө Япон Улсын Иргэний хуулийн 34-р зүйлийн 34.1 дэх хэсэгт “Тахилга, шашин шүтлэг, хандив тусламж, шинжлэх ухаан технологи, урлаг уран сайхан зэрэг нийтийн эрх ашигтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн болон хөрөнгийн нэгдэл болох ашиг олох зорилгогүй байгууллага нь захиргааны байгууллагын зөвшөөрлийг авч хуулийн этгээд болж болно” хэмээн хуульчилсан байв. Энэ заалтын дагуу нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдийг тодорхойлдог байжээ.

Гэхдээ энэ нь тухайн үед оршин тогтнож байсан хуулийн этгээдийн төрлийг бүгдийг бүрэн гүйцэд хамран ангилж чадахгүй байжээ. Тухайлбал, гишүүддээ үйлчилдэг байгууллагын үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлын төлөө бус, бас ашгийн төлөө ч биш байж болохоор байв.

Цаашлаад “Дундын хуулийн этгээд” гэсэн нэр томъёо ч үүссэн байна. Энэ нь шинээр бий болсон дээрх шиг байгууллагуудын статусыг тодорхойлж, бүртгэх тусгайлсан хууль гаргахад нөлөөлжээ. Жишээ нь, төрөл бүрийн хоршооны үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хуулиудыг энд дурдаж болно. Мөн нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд байгуулахад төрийн байгууллагаас зөвшөөрөл авдаг тогтолцоо үйлчилж байсан ч “нийтийн ашиг сонирхол”-ыг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байсны улмаас хуулийн этгээдийн эрх олгох эсэх нь захиргааны үзэмжээс шууд хамаарч байв.

Иймээс хуулийн шинэчлэл хийх шаардлагатай болж, Иргэний хуулийн агуулгыг ерөнхий зохицуулалтын шинжтэй болгон шинэчилж, нарийвчилсан харилцааг тусгай хуулиар зохицуулах болжээ. Иргэний хуульд орсон 2006 оны нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 33-р зүйлийн 33.2 дахь хэсэгт “Шинжлэх ухаан, технологи, урлаг, уран сайхан, хандив, тусламж, тахилга, шашны зэрэг нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд гэх мэтээр хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, удирдлага, дотоод зохион байгуулалт, хяналтыг энэ хууль болон бусад хуулиар зохицуулна” гэж заажээ. Ийнхүү энэ шинэ зохицуулалтын дагуу

хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хэмээн ангилах болсон байна.

2. Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалт

Япон Улсад ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн харилцааг дээр дурдсанчлан ерөнхий ба тусгай хуулиар зохицуулж байна.

2.1 Ерөнхий хуулийн зохицуулалтад хамаарах ашгийн бус хуулийн этгээд

2006 онд ашгийн бус хуулийн этгээдийн харилцааг нарийвчлан зохицуулах тусгай хууль болох “Ашгийн бус байгууллага болон сангийн тухай хууль” (Act on General Incorporated Associations and General Incorporated Foundations) батлагдсан байна. Энэ хуулийн дагуу ашгийн бус хуулийн этгээд нь нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд гэсэн статус авахын тулд магадлан итгэмжлэлд хамрагдана. Өөрөөр хэлбэл, ашгийн бус байгууллагын хоёр шатлалт тогтолцоо бий болжээ.

Шинэ хуулийн дагуу ашгийн бус хуулийн этгээд байгуулахад төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авдаг тогтолцоог халж, хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэл хийлгэх боломжтой болжээ. Энэ нь төрийн хяналтыг багасгаж, иргэдийн бие даасан чөлөөт үйл ажиллагааг дэмжих чиглэлээр

Япон Улсад өрнөж буй шинэчлэлийн нэг хэсэг юм. Өөрөөр хэлбэл, ашгийн бус хуулийн этгээдийг эхлээд байгуулахад заавал нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулах зорилготой байхыг шаардахаа больсон байна. Харин ийнхүү байгуулагдсан ашгийн бус хуулийн этгээд нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд болохыг хүсвэл нийтийн ашиг сонирхлын төлөө явуулж буй үйл ажиллагаагаа магадлан итгэмжлүүлнэ. Түүнчлэн төрийн хяналтыг багасгаж, чөлөөт байдлыг нэмэгдүүлэх концепцийн хүрээнд 2005 онд Компанийн хуулийг шинэчлэн баталснаар ашгийн бус хуулийн этгээдийн дотоод хяналтын тогтолцоог компанийн тогтолцоотой адил байдлаар хуульчилжээ. Япон улсад ашгийн бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулах болон түүний удирдлагын бүтцийг нарийвчлан авч үзье.

Ашгийн бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулах: Аливаа ашгийн бус байгууллага болон санг үүсгэн байгуулахад дараах шаардлага тавьдаг. Юуны өмнө дүрмээ баталж, нотариатаар баталгаажуулсан байх ёстой. Дүрэмд Ашгийн бус байгууллага болон сангийн тухай хуулийн 11-р зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан дараах зүйлийг заавал тусгана. Үүнд: үйл ажиллагааны зорилго, байгууллагын нэр, оршин байгаа газар, үүсгэн байгуулагчдын овог нэр, хаяг, гишүүнээр элсэх болон гишүүнчлэлээ алдах нөхцөл, мэдэгдэл хүргүүлэх арга, үйл ажиллагааны хугацаа. Сангийн хувьд

үндсэн хөрөнгийн хэмжээг мөн тодорхой тусгасан байх ёстой. Хоёр буюу түүнээс дээш тооны үүсгэн байгуулагчтай сан нь 3 сая иенээс дээш үндсэн хөрөнгөтэй

байхыг шаардана. Мөн гишүүддээ ашиг болон үлдэгдэл хөрөнгө хуваарилах тухай заасан дүрэм байвал хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

2006 оноос өмнөх тогтолцоо

Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд (Иргэний хуулийн 34-р зүйлд заасан байгууллага, эхсүл сангийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.)

Дундын хуулийн этгээд
(Дундын хуулийн этгээдийн тухай хууль)

Шинэчлэлийн агуулга

- Ашгийн бус хуулийн этгээдийг бүртгэх болон нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдийг тодорхойлох асуудлыг заагласан
- Эрх олгох, бүртгэх, хяналт тавих захиргааны байгууллагыг өөрчилсөн
- Ил тод байдлыг хангасан шинэ бүтэц бий болгосон

2006 оноос хойших тогтолцоо

Ашгийн бус байгууллага болон сан

- Бүртгүүлснээр хуулийн этгээд болно.
- Нийтийн ашиг сонирхлын төлөө байхыг шаардахгүй.
- Бие даасан засаглалтай байхыг баталгаажуулсан.

Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон сан

- Өндөр мэдлэг, туршлагатай иргэдээс бүрдсэн хорооны саналыг үндэслэн ашгийн бус хуулийн этгээдийн зорилго, үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг тогтооно.
- Захиргааны үзэмжийг аль болох багасгах үүднээс харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг илүү тодорхой болгосон.
- Засаглал, мэдээллийн нээлттэй байдлыг сайжруулсан, зохистой хяналтын арга хэмжээг бий болгосон.

Ашгийн бус хуулийн этгээдийн бүтэц:

Ашгийн бус байгууллага болон санг 200 сая иенээс дээш эргэлтийн хөрөнгөтэй бол том гэж үздэг. Байгууллага, сан нь дараах бүтэцтэй байна.

Байгууллага	Сан
Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч (хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй)	Зөвлөлийн гишүүн + Зөвлөл (3-аас дээш гишүүнтэй байна) + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч
Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Хянагч (Хуулийн этгээдийн хөрөнгө болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина)	Зөвлөлийн гишүүн + Зөвлөл + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч + Аудитор
Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Хянагч + Аудитор	
Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч	
Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэгч + Гүйцэтгэгч нарын зөвлөл +Хянагч + Аудитор	

Ашгийн бус байгууллагын хувьд заавал гүйцэтгэгч нарын зөвлөл, хянагч, аудитортай байхыг хуулиар шаардахгүй боловч гүйцэтгэгч нарын зөвлөлтэй, эсвэл аудитортай бол заавал хянагчтай байна. Мөн том байгууллагын хувьд зайлшгүй аудитортай байх ёстой. Сангийн хувьд зайлшгүй аудитортай байхыг үүрэг болгоогүй ч том сангийн хувьд зайлшгүй аудитортай байх шаардлагатай.

Зөвлөлийн гишүүн нь зөвлөлийг бүрдүүлэх боловч тухайн сантай бие даасан даалгаврын гэрээ байгуулна. Энэ үед Иргэний хуулийн 644-р зүйлд заасан мэргэжлийн түвшинд анхаарал болгоомжтой байх үүрэг хүлээх ба энэ үүргээ биелүүлээгүй бол сан болон гуравдагч этгээдийн өмнө хохирол нөхөн төлөх үүрэг хүлээдэг тул зөвлөлөөс тусдаа бие даасан бүрэлдэхүүн гэж үздэг.

Гүйцэтгэгч нь мөн зөвлөлийн гишүүний адилаар сантай бие даасан даалгаврын гэрээ байгуулна. Мөн Иргэний хуулийн 644-р зүйлд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд хохирол нөхөн төлөх үүрэгтэй бие даасан бүрэлдэхүүн юм.

Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага, санг магадлан итгэмжлэх

Өмнө дурдсанчлан, ашгийн бус хуулийн этгээд нь нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага, сан гэсэн статус авахын тулд магадлан итгэмжлэлд орох ёстой. Үүний тулд эхлээд магадлан итгэмжлэх эрхтэй хөндлөнгийн этгээд болох өндөр мэдлэгтэй иргэдээс бүрдэх хороо тухайн хуулийн этгээдийн гол үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхолд чиглэсэн эсэхийг шалгана. Үүний дараа

захиргааны байгууллага (засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага) нь нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд гэсэн магадлан итгэмжлэл олгодог. Орон нутагт хэд хэдэн салбартай, эсхүл орон нутагт хэд хэдэн үйл ажиллагаа явуулах зорилготой, эсвэл нийтийн ашиг сонирхлын чиглэлээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг бол Ерөнхий сайд магадлан итгэмжилнэ. Бусад тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллага буюу засаг дарга нь магадлан итгэмжлэх эрхтэй. Ийнхүү магадлан итгэмжлэгдсэн байгууллагад татварын хөнгөлөлт эдлэх боломж нээгдэнэ. Магадлан итгэмжлэлийн шалгуур нь:

- Үйл ажиллагааны 50-иас илүү хувь нь нийтийн ашиг сонирхлын тусын тулд байх (Зарлагын 50-иас илүү хувь нь нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаанд зарцуулагдсан байх).
- Ердийн боломжит хэмжээнд гарсан зардлаас нь үйл ажиллагаанаас олсон орлого нь давахгүй байх (Энэ нь нэг талаас үндэслэлгүйгээр зарлага гаргахаас зайлсхийх зорилготой, нөгөө талаас орлого олохгүй байгаа бодит нөхцөлийг харгалзан үзэх тухай юм).
- Нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа, ашиг олох үйл ажиллагаа болон хуулийн этгээдийн төлбөр тооцоонд зарцуулагдаагүй үлдсэн, цаашид зарцуулагдахгүй хөрөнгийн хэмжээ нь нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаанд зарцуулагдаж буй хөрөнгөөс хэтрэхгүй байх.
- Нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн болон технологийн чадвартай байх. Өөр хоорондоо хамаарал бүхий гүйцэтгэгч, хянагчийн тоо нь нийт гүйцэтгэгч, хянагчийн тооны гуравны нэгээс хэтрэхгүй байх.

Ийнхүү “Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон санг магадлан итгэмжлэх тухай хууль”-ийн 5-р зүйлийн 1-18 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд гэж үзэж бүртгэнэ.

Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдэд олгох татварын хөнгөлөлт

“Нийтийн ашиг сонирхлын төлөөх байгууллага болон санг магадлан итгэмжлэх тухай хууль”-ийн 2-р зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсноор шинжлэх ухаан, технологи, урлаг, уран сайхан, хандив, тусламж зэрэг энэ хуулийн хавсралтад заасан үйл ажиллагаанаас гадна нийтийн эрх ашгийн хамгаалахад хувь нэмэр оруулах үйл ажиллагааг хэлнэ. Энэхүү хавсралт нь 17 төрлийн үйл ажиллагааг багтаасан бөгөөд Засгийн газрын тогтоолоор тодорхой төрлийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа хэмээн нэмж заах боломжтой. Нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагаа эрхэлдэг, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд нь хуульд

заасны дагуу дараах татварын хөнгөлөлт эдэлнэ.

- Зөвхөн ашгийн төлөөх үйл ажиллагаанаас олсон орлогод нь татвар ногдуулна. Хуулийн этгээдийн татварын тухай хуулиар 34 төрлийн ашгийн төлөө үйл ажиллагааг тогтоосон байдаг. Гэхдээ ашгийн төлөө үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлын төлөөх үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн бол татвар ногдуулахгүй.
- Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээдэд хандив өгсөн этгээд мөн татварын хөнгөлөлт эдэлнэ.

Тусгай хуулиар зохицуулагдах ашгийн бус хуулийн этгээд

- 1998 онд батлагдсан “Тодорхой төрлийн ашгийн төлөө бус үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих тухай хууль (Act on Promotion of Specified Non-profit Activities)”-ийн дагуу байгуулагдсан ашгийн төлөө бус байгууллагыг NPO (Non Profit Organization) хуулийн этгээд гэж нэрлэдэг. Ашгийн төлөө үйл ажиллагааны орлогоос бусад орлогыг нь татвараас чөлөөлнө.
- 1951 онд батлагдсан Нийгмийн хамгааллын хуулийн 22-р зүйлд заасны дагуу байгуулагдах хуулийн этгээд болох нийгмийн хамгааллын хуулийн этгээд үүнд хамаарна.
- 1951 онд батлагдсан Шашны хуулийн этгээдийн тухай хуулийн 4-р зүйлд

шашны байгууллага нь энэ хуулийн дагуу ашгийн бус хуулийн этгээд байж болно.

- 1948 онд батлагдсан Эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тухай хуулийн 39-р зүйлд зааснаар “Эмнэлэг, клиник эмнэлэг, өндөр настны эрүүл мэндийн төв байгуулах зорилготой байгууллага болон сан нь энэ хуулийн дагуу ашгийн бус хуулийн этгээд болж болно”.
- 1949 онд батлагдсан Хувийн сургуулийн хуулийн 3-р зүйлд “Сургалтын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд гэж хувийн сургууль байгуулах зорилгоор энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг ойлгоно” гэж заасан байна.

Эдгээрээс энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн сургуулийн, эмнэлгийн болон шашны үйлчилгээний хуулийн этгээд нь бүгд ашгийн төлөө зорилготой байж болох төдийгүй, сан ба байгууллагын шинжийг давхар агуулдаг тул тусгайлсан хуулиар зохицуулах шаардлагатай болдог.

Сургалтын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

Сургалтын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь сангийн хэлбэрээр байгуулагдана. Хуулийн этгээдийн бүтэц нь *Гүйцэтгэгч нарын зөвлөл + Гүйцэтгэгч + Хянагч + Зөвлөх хороо* байна. Гүйцэтгэгч нарын зөвлөл нь шийдвэр гаргах дээд байгууллага бөгөөд таваас дээш гишүүнтэйгээр

гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт тавих хоёроос дээш тооны хянагчийг Гүйцэтгэгч нарын зөвлөлийн дарга томилно.

Зөвлөх хороо нь гүйцэтгэгч нарын тооноос хоёр дахин их бүрэлдэхүүнтэй байх ба гүйцэтгэгч нарын зөвлөлийн дарга нь төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөх хороотой заавал урьдчилан зөвлөлдөх үүрэгтэй. Цэцэрлэг, бага, дунд, ахлах сургууль зэрэг ерөнхий боловсрол олгох сургууль байгуулахад орон нутгийн засаг даргаас зөвшөөрөл авна. Харин их дээд болон мэргэжлийн сургууль байгуулах зөвшөөрлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд олгоно.

Боловсролын хуулийн этгээдийн зөвхөн ашгийн төлөөх үйл ажиллагааны орлогод татвар ногдуулна. Үүнд үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын татвар гэх мэт хамаардаг. Татвар оногдуулахдаа ердийн хэмжээ буюу 23.9 хувиас бага 19 хувийн татвар ногдуулдаг.

Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь байгууллагын болон сангийн хэлбэрээр байгуулагдаж болно. Гэхдээ ийм төрлийн нийт хуулийн этгээдийн 99.1 хувь нь байгууллагын хэлбэрээр

байгуулагдсан байна. Байгууллагын хэлбэртэй эмнэлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийг хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхтэй болон эрхгүй гэсэн төрөлд төрөлд ангилна. Гэвч 2007 оноос хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхтэй хуулийн этгээдийн тогтолцоог халжээ. Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн бүтэц нь *Нийт гишүүдийн хурал + Гүйцэтгэх зөвлөл + Гүйцэтгэх зөвлөлийн дарга + Гүйцэтгэгч* + Хянагч байна. Гүйцэтгэгч нь гурваас дээш тооны этгээд байх ба хянагч нь нэгээс илүү байхыг шаарддаг байна. Хөрөнгө оруулагч нь заавал гишүүн байх, эсвэл гишүүн нь заавал хөрөнгө оруулагч байхыг шаардахгүй.

Эмнэлгийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд бүгд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой байдаггүй. Харин Татварын тусгай зохицуулалтын тухай хуулийн 67 дугаар зүйлд заасан “Тусгай эмчилгээний хуулийн этгээд” гэсэн ангилалд хамаарах хуулийн этгээд татварын хөнгөлөлт эдлэх боломжтой. Гол шалгуур нь хөрөнгө оруулалтаа буцаан авах эрхгүй хуулийн этгээд байх, төдийгүй сангийн хэлбэрээр байгуулагдсан байхыг шаардана.

Захиргааны хуулийн этгээд болох улсын эмнэлэг, сургууль

Захиргааны бие даасан хуулийн этгээдийн тогтолцоо нь яам, Засгийн газрын тодорхой чиг үүргийг хариуцах ашгийн бус байгууллагаас бүрдэнэ. Эдгээр ашгийн

бус байгууллагын үйл ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах, идэвхжүүлэх, хараат бус, ил тод байдлыг хангахын тулд бие даасан хуулийн этгээдийн эрх олгодог. 1999 онд батлагдсан “Захиргааны бие даасан хуулийн этгээдийн ерөнхий хууль (Act on General Rules for Incorporated Administrative Agencies)-ийн 2-р зүйлийн 1 дэх хэсэгт захиргааны бие даасан хуулийн этгээд гэдэг нь иргэдийн амьдрал болон эдийн засгийн тогтвортой байдал зэрэг нийтийн ашиг сонирхлыг хангах чиг үүргийг баталгаатай хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа бөгөөд төр өөрөө шууд хэрэгжүүлэх шаардлагагүй асуудлуудыг хувь этгээдэд хариуцуулах, ийнхүү хариуцаж авсан байгууллага нь заавал хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг ойлгоно гэж заажээ. Харин дээрхээс бусад асуудал, эсвэл нэг этгээд дангаар хэрэгжүүлж болох үйлчилгээний чанар, үр нөлөөлөг хангахын тулд “дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэх хуулийн этгээд”, “улсын судалгаа, хөгжлийн хуулийн этгээд”, “захиргааны хэрэгжүүлэгч хуулийн этгээд”-ийн статустай байгууллага байгуулж болно. Япон Улсад одоогийн байдлаар захиргааны бие даасан нийт 87 хуулийн этгээд байна.

Улсын сургууль

2003 онд батлагдсан “Улсын их сургуулийн хуулийн этгээдийн хууль” (National University Corporation Act) – ийн 6 дугаар зүйлд зааснаар улсын их

сургууль нь хуулийн этгээдийн эрхтэй байна. Иймээс Улсын их сургуулийг захиргааны бие даасан хуулийн этгээдийн нэг төрөл гэж авч үздэг байна. Улсын их сургуулийн удирдах бүтэц нь Сургуулийн захирал + 2 хянагч + Гүйцэтгэгч байна. Мөн их сургуулийн удирдлагын гол шийдвэрийг гаргах удирдлагын хороо, сургалт, судалгааны асуудлыг хариуцсан хороо ажиллана. Их сургуулийн захирлыг тухайн сургуулиас санал болгосноор боловсрол, шинжлэх ухааны сайд томилно. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар их сургуулийн захирлын сонгууль нь хүнлэг шулуун шударга байдал, эрдэм судлалаараа тэргүүлсэн бөгөөд их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагааг зохистой, үр дүнтэй удирдан хэрэгжүүлэх чадвартай нэр дэвшигчдийг тогтоосон шаардлагад үндэслэн сонгох замаар явагдана.

Улсын эмнэлэг

2002 онд батлагдсан “Захиргааны бие даасан хуулийн этгээд улсын эмнэлгийн байгууллагын хууль” (Act on the National Hospital Organization, Independent Administrative Agency)-ийн 3-р зүйлд үндэслэн байгуулагдсан улсын бүх эмнэлгийг нэгтгэсэн захиргааны бие даасан нэгдсэн удирдлагыг бий болгож буй байгууллага юм. Энэ нь иргэдэд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний талаар туршилт, судалгаа болон дадлагажуулах үйл ажиллагааг

нэгдмэл байдлаар явуулах үндсэн зорилготой байгууллага юм. Тус хуулийн этгээдийн бүтэц нь *Захирал + 2 хянагч + Дэд захирал + 5 хүртэлх тооны гүйцэтгэгчтэй* байж болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. 私立学校法（昭和二十四年法律第二百七十号）
2. 国立大学法人法（平成十五年法律第一百十二号）
3. 地方独立行政法人法（平成十五年法律第一百十八号）
4. 独立行政法人通則法（平成十一年法律第三百三号）
5. www.mof.go.jp/tax_policy/summary/corporation/251.htm
6. www.moj.go.jp/MINJI/minji153.html#01
7. www.cao.go.jp/others/koeki_npo/koeki_npo_seido.html
8. www.koeki-info.go.jp/pictis_portal/other/pdf/20131021_kakukikan.pdf
9. www.mext.go.jp/a_menu/koutou/shinkou/07021403/003.ht

Хавсралт 2: АШГИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СУДАЛГАА

Монгол Улс дахь Ашгийн бус үйл ажиллагааны шинж чанар, эрхзүйн зохицуулалтын байдлыг судалсан асуулгын хариулт

2017 оны 9-р сараас 12-р сарын хооронд ашгийн бус хуулийн этгээдийн зохион байгуулалттай хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй дараах байгууллагуудаас судалгаа авсан юм. Манай судалгаанд:

1. Хөдөө аж ахуйн их сургууль
2. Санхүү эдийн засгийн их сургууль
3. Шинэ Монгол сургууль
4. Улсын нэгдүгээр эмнэлэг
5. Зориг сан
6. Урлагын зөвлөл
7. Чойжин ламын музей
8. Лантуун Дохио ТББ-ын төлөөлөл оролцож дараах хариултыг ирүүлсэн болно.

Монгол Улсад ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрхэлж болох нийтэд тустай үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны чиглэл	Хариулт
1	Нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 3 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 4
2	Нийгмийн эмзэг, ядуу хэсэгт дэмжлэг, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 3 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 4 Хамаарахгүй – 1
3	Боловсролын үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 3 Зарим хэсгийг нь хамааруулж болно –3 (Бүрэн дунд боловсрол, санхүүгийн хяналт, төрийн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг нөлөөлөл)
4	Эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 3 Зарим хэсгийг нь хамааруулж болно –2 (оношилгооны чиглэл, мэс засал, эмийн эмчилгээ) Хамаарахгүй – 1
5	Хүүхэд залуучууд, өндөр настны аж амьдралыг дэмжих үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 3 Зарим хэсгийг нь хамааруулж болно –2 Хамаарахгүй –2
6	Байгаль орчныг хамгаалах, байгалийн аюул, гамшигтай тэмцэх үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 4 Хамаарахгүй – 1
7	Хүний хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно –3 Хамаарахгүй – 1

8	Биеийн тамир, спортын үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно –3 Хамаарахгүй – 1
9	Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 2 Хамаарахгүй – 1
10	Иргэдэд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 2 Хамаарахгүй – 2
11	Нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 2 Зарим хэсгийг нь хамааруулж болно –1 (Олон нийтийн зам талбай, гудамжийг камержуулах гэх мэт) Хамаарахгүй – 2
12	Соёл, урлагийн үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 1 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 4 Хамаарахгүй – 1
13	Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 1 Зарим хэсгийг нь хамааруулж болно –3 (Хүүхэд, өсвөр үеийнхний чөлөөт цаг өнгөрөөх) Хамаарахгүй – 1
14	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа	Бүхэлд нь хамааруулж болно – 1 Зарим хэсгийг нь хамааруулж болно – 2 Хамаарахгүй – 1

Тухайн байгууллагын “ашгийн бус” статусыг илэрхийлэх үзүүлэлт, түүнийг нотлох хэлбэр

“Ашгийн бус” статусыг илэрхийлэх үзүүлэлт	Хэрхэн нотлох		Нотолгоог хэдийд, ямар хүрээнд гаргах
	Төр, засгийн байгууллагад тайлагнах	Тусгайлан байгуулсан зөвлөлд тайлагнах	
Үйл ажиллагааны зорилго, чиглэл нь нийтийн ашиг тусын тулд байх	4 (Шадар сайд)	4 (Энэ чиглэлээр байгуулсан комисс, УЗ, Сангийн дүрмийн хороонд)	Жилийн эцэст
Орлого, зарлага нь ил тунгалаг байх	5 (Шилэн дансны сайтад байршуулах ОУ-ын дотоод аудит)	4 (ОУ-ын УЗН-д)	Тухай бүрт
Татварын тайлангаа нийтэд ил байлгах	5 (ТЕГ)	5	Хуулийн дагуу
Үйл ажиллагааны тайлангаа нийтэд ил байлгах	5	4	
Аливаа хэсэг бүлгийн ашиг сонирхол, нөлөөнөөс хамааралгүй байх	5	4	
Хуваарилагдсан төсөв	Сангийн яам		Хуулийн хугацаанд

Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг илэрхийлэх гол шинж:

1	Нийтийн эрх ашгийн төлөө ажиллах ба шийдвэр гаргах процесс нь ил тунгалаг байх	заавал шаардах –8 шаардлагагүй –1
2	Бие даан хараат бусаар ажиллах	заавал шаардах – 7 шаардлагагүй – 1
